



**МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧИЛГЫН БАТАЛГААЖУУЛАЛТ©**

coffey  **international development**
SPECIALISTS IN DEVELOPING COMMUNITIES

2010 ОНЫ 2 ДУГААР САР

coffey  **international development**
SPECIALISTS IN DEVELOPING COMMUNITIES

**МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧИЛГЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

2010 оны 2 дугаар сар

**Coffey International Development Ltd (Коффи Интернейшнл Девелопмент
компани)**

The Malthouse 1 Northfield Road Reading Berkshire RG1 8AH United Kingdom

Утас (+44) (0) 1189 566 066 Факс (+44) (0) 1189 576 066

www.coffey.com/internationaldevelopment

Бүртгэгдсэн байршил: 1 Northfield Road Reading Berkshire RG1 8AH United Kingdom

Англи улсын бүртгэлийн дугаар No. 3799145, НӨАТ төлөгчийн дугаар GB 724 5309 45

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

МНБ

Мэргэшсэн Нягтлан Бодогч

ОУИТБС	Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга
ҮТЕГ	Үндэсний Татварын Ерөнхий Газар
ЗГ	Засгийн Газар
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ЭБЭХЯ	Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яам
МУУҮА	Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциац
СЯ	Сангийн Яам
ТАН	Төлсөн, Авсанаа Нийтэл
ҮЗ	Үндэсний Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
НӨАТ	Нэмэгдэл Өртгийн Албан Татвар

АГУУЛГА

БҮЛЭГ 1	ТАНИЛЦУУЛГА
----------------	--------------------

БҮЛЭГ 2	БАТАЛГААЖУУЛАЛТЫН АРГА ЗҮЙ БОЛОН ҮЙЛ ЯВЦ	
БҮЛЭГ 3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	
БҮЛЭГ 4	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ	
БҮЛЭГ 5	КОМПАНИУДЫН ТҮВШИН ДЭХЬ ХЭРЭГЖИЛТ	
БҮЛЭГ 6	НИЙТЛЭГ ҮНЭЛГЭЭ	
БҮЛЭГ 7	ЦААШДЫН ХЭРЭГЖИЛТЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖҮҮД	
БҮЛЭГ 8	СУРГАМЖУУД	
ХАВСРАЛТ А	ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ	А-1
ХАВСРАЛТ Б	ТОВЧ ТАЙЛАН	Б-1
ХАВСРАЛТ В	КОМПАНИЙН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ	В-1
ХАВСРАЛТ Г	БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛДӨГЧ ТАЛУУД	Г-1
ХАВСРАЛТ Д	ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ БОЛОН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД	Д-1
ХАВСРАЛТ Е	ГОЛ БАРИМТ БИЧГҮҮД	Е-1

1 ӨМНӨТГӨЛ

Энэхүү тайлан нь Монгол улсын ОУИТБС-ын хэрэгжилтэд хийгдсэн баталгаажуулалтын тайлан болно. Баталгаажуулалтын үйл ажиллагааг Коффи Интернейшнл Девелопмент болон Далайван Аудит компаниудын хамтарсан консорциум хийж гүйцэтгэлээ.

Энэхүү тайлан нь доор дурдсан бүлгүүдээс бүрдэж байна. Үүнд:

- Бүлэг 1. Энэ бүлэг дээр ОУИТБС-ын Монгол улсад үзүүлэх үр нөлөө, ач холбогдлыг хураангуйлан тусгасны зэрэгцээ баталгаажуулалтын үйл явц болон ОУИТБС-ын хэрэгжилтийн байдлын талаар товч дурдсан.
- Бүлэг 2 дээр баталгаажуулалтын арга зүйн талаарх мэдээллийг багтаасан.
- Бүлэг 3 нь ОУИТБС-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн хэрэгжилтийн талаар Баталгаажуулагчдын зүгээс өгч буй үнэлгээг оруулсан.
- Бүлэг 4 дээр ОУИТБС-ын Баталгаажуулалтын хүснэгтэд заасныг баримтлан санаачилгын үйл ажиллагааны үр дүн, үйл явцад үнэлэлт, дүгнэлт өгсөн.
- Бүлэг 5 нь уул уурхайн компаниудын зүгээс Монгол улсад ОУИТБС-ыг хэрхэн хэрэгжүүлж буй талаар тусгасан.
- Бүлэг 6 нь ОУИТБС-ын хэрэгжилтийн талаарх Баталгаажуулагчдын нийтлэг үнэлгээг багтаасан.
- Бүлэг 7 дээр Монгол улсад ОУИТБС-ын цаашдын хэрэгжилтэд зориулсан санал зөвлөмжүүдийг оруулсан.
- Бүлэг 8 нь Монгол улсад хийгдсэн баталгаажуулалтын үеийн сургамжуудын талаар цухас дурдсан.

Энэхүү тайлан нь дагалдах нийт 6 хавсралттай. Хавсралт А нь бүрэн хэмжээнд бөглөгдсөн Баталгаажуулалтын хүснэгтийг агуулах ба Хавсралт Б дээр ОУИТБС-ын баталгаажуулалтын дэлгэрэнгүй тайланг багтаасан. Дараагын Хавсралт В нь Баталгаажуулагч нарт гарган өгсөн компаниудын өөрийн үнэлгээг нэгтгэсэн байдлаар харуулсан. Хавсралт Г нь энэхүү баталгаажуулалтын үеэр уулзан ярилцсан оролцогч талуудын төлөөллийн нэрсийн жагсаалтыг багтаасан болно. Хавсралт Д дээр Үндэсний зөвлөл (ҮЗ) болон Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийн жагсаалт, Хавсралт Е нь Монгол улсын ОУИТБС-ын хүрээнд боловсруулагдан гарсан чухал баримт бичгүүдийг агуулсан.

2 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮҮРЭГ РОЛЬ

Монгол улсын алт, зэс, нүүрсний нөөц нь үндэсний хэмжээний орлогын ихээхэн чухал үүсвэрт тооцогдож байна. Одоогоор уул уурхайн үйлдвэрлэл нь аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 55%, Засгийн газрын орлогын 33%-ийг бүрдүүлж байна. 2006 оны байдлаар уул уурхайн салбараас орсон орлого нь Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 14%-ийг бүрдүүлж байжээ. Монгол улс нь зэсийн томоохон экспортлогч болохын хажуугаар алт болон молибденийн ихээхэн нөөцийг агуулж байгаа нь энэхүү салбарын ач холбогдлыг улам бүр өсгөж байгаа юм. Мөн Монгол улсын нүүрсний нөөц нь урьдчилсан байдлаар 100 тэрбум тонноор хэмжигдэж байгаа билээ. Сүүлийн жилүүдэд Монгол улсад нүүрс олборлолт ихээр нэмэгдсэн ба үүний шалтгаан нь хэд хэдэн төрийн өмчит уурхайг хувьчилсан болон Хятадын нүүрсний

эрэлт өссөнтэй холбоотой ажээ. Оюу Толгойн орд газрыг ашиглалтад оруулахаар шийдсэн, мөн 2006 онд батлагдсан Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль цуцлагдсантай холбоотойгоор энэ улсын зэс, алтны үйлдвэрлэл ирээдүйд ихээхэн хэмжээгээр нэмэгдэх төлөвтэй байна. Олборлох үйлдвэрлэл эрхлэж буй компаниудын тоо 2005 оны эхэн үеэс эхлэн хурдтайгаар нэмэгдэн төмрийн хүдэр, цайрын концентрац болон зэсийн экспорт нэмэгджээ. Түүнчлэн олон тооны гадаадын томоохон компаниуд Монгол улсад газрын тосны хайгуул хийж байна.

3 ОУИТБС-ЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮЙЛ ЯВЦ

Баталгаажуулалт нь ОУИТБС-ын нэгэн чухал элемент агаад энэ нь тухайн санаачилгын статус болон олон улсын стандартуудтай салшгүй хамааралтай юм. Үүний зорилго нь ОУИТБС-ын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшилд бие даасан үнэлгээ хийлгэн тухайн үйл явцыг үр дүнтэйгээр сайжруулахад ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатайг тогтоодог. Нэр дэвшигч улсуудын хувьд¹, баталгаажуулалт нь ОУИТБС-ын хэрэгжилтийн ахиц дэвшлийг хэмжин тогтоох зорилготой. ОУИТБС-ыг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлсэн улсуудын хувьд (Хэрэгжүүлэгч орнууд²), баталгаажуулалт нь ОУИТБС-ын шалгуурыг хэрхэн биелүүлж байгаа талаарх бодит үнэлгээ болдог.

2007 оны 9 дүгээр сарын 27-нд Осло хотод болсон Олон улсын ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн гуравдугаар хуралдаанаар Монгол улс зэрэг 15 оронд нэр дэвшигчийн статус олгосон билээ. Олон улсын ОУИТБС-ын Удирдах зөвлөлийн шийдвэр дээр үндэслэн хэрэгжүүлэгч статуст дэвшин орох хүсэлтэй нэр дэвшигч улсууд нь 2010 оны 3 дугаар сараас өмнө баталгаажуулалт хийлгэсэн байх үүргийг хүлээсэн юм.

4 ОУИТБС МОНГОЛ УЛСАД

Монгол улсын Засгийн газар (ЗГ) ОУИТБС-ыг хэрэгжүүлж эхлэх санаачилгыг 2005 оны 12 дугаар сард анхлан гаргасан юм. ОУИТБС-ын санаачилгыг анхан үедээ “Төлсөн авсанаа нийтэл” (ТАН) хэмээх иргэний нийгмийн эвсэл хэрэгжүүлэн олборлох салбарт ил тод байдлыг бий болгох зорилгоор үйл ажиллагаа явуулж иржээ. 2006 оны 12 дугаар сард Олон Талын Оролцоот Ажлын Хэсэг (Ажлын хэсэг) ҮЗ-ийн бүтцэд байгуулагдан ЗГ, иргэний нийгэм болон компаниудын тэгш төлөөлөлтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. 2007 оны 6 дугаар сард ОУИТБС-ын Ажлын Алба Дэлхийн Банкны дэмжлэгтэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. ТАН эвсэл нь ОУИТБС-ын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн хажуугаар олборлох салбарын ил тод байдал, гэрээ, лицензийн ил тод байдал, уул уурхайн үйл ажиллагаанд олон нийт, орон нутгийн засаг захиргааг татан оруулах, уул уурхайн салбарын бодлого боловсруулах, мониторинг хийх зэрэг өргөн хүрээг хамран үйл ажиллагаа явуулж байна.

Монгол улс нь албан ёсоор ОУИТБС-ын нэр дэвшигч улсаар 2007 оны 11 дүгээр сард батлагдан, 2010 оны 3 дугаар сарын 9-нөөс өмнө баталгаажуулалт хийлгэх үүрэг

¹ Нэр дэвшигч орон гэдэг нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр хүсэлт гарган нийт 4 шалгуурт нийцсэн улсуудыг багтаах ба үүнд (1) ОУИТБС-ыг хэрэгжүүлэх эрмэлзлэлтэй; (2) иргэний нийгэм болон хувийн хэвшилтэй хамтран ажиллах хүсэлтэй; (3) хэрэгжилтийг удирдах хүнийг томилсон; болон (4) оролцогч талуудын хүлээн зөвшөөрсөн Ажлын төлөвлөгөөтэй байх гэсэн шалгуурууд багтана.

² Хэрэгжүүлэгч орнуудад ОУИТБС-ыг бүрэн хэрэгжүүлж буй улсууд багтана. Тэд баталгаажуулалтын бүх шалгуурт нийцсэн байх ёстой ба үүний хажуугаар ОУИТБС-ын тайланг олон нийтийн хүртээл болгосон байх шаардлага тавигддаг.

хүлээжээ. Одоогоор ОУИТБС-ын хэрэгжилтийг Дэлхийн Банкны Олон талын оролцоот донорын итгэлийн сангаар дамжуулан санхүүжүүлж байна. Ажлын хэсэг нь ОУИТБС-ын Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гаргаж, үүнийг олон нийтэд зориулан хэвлэн нийтэлсэний зэрэгцээ бүх шатанд (үндэсний, бүсийн болон орон нутгийн) уул уурхайн компаниудаас ЗГ-т төлсөн татвар, хураамж болон ЗГ уул уурхайн компаниудаас хүлээн авсан татвар, хураамжийг тайлагнахад ашиглах маягтуудыг боловсруулан гаргасан байна.

Монгол улс нь ОУИТБС-ын анхны аудитын нэгтгэлийн тайланг 2008 оны 2 дугаар сард гаргасан нь 2006 онд компаниудын төлсөн болон ЗГ-ийн хүлээн авсан татвар, хураамжийг хамарсан байна. Энэхүү анхдугаар аудитын нэгтгэлийн тайланг уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй тэргүүлэх 25 компаниар гаргажээ. Аудитын нэгтгэлээр 25 тэрбум төгрөгийн зөрүүг илрүүлжээ. Одоогын байдлаар энэ зөрүү ямар шалтгаанаас үүдсэн болохыг тодруулах үйл ажиллагаа үргэлжлэн явагдаж байна. Түүнчлэн энэ тайланд ороогүй өөр 28 компанийн тайланд мөн нэмэлт байдлаар дотоодын аудиторуудаар аудитын нэгтгэл хийлгэсэн байна. Монгол улсын хоёрдахь тайлан нь нийтдээ 38 компаниар (жилд төлсөн татвар, төлбөрийн хэмжээ нь 200 сая төгрөгнөөс дээш) гарч 2007 оны санхүүгийн жилийг хамарсан ба энэхүү тайланг ҮЗ 2009 оны 11 дүгээр сарын хуралдаанаараа хэлэлцэн, баталсан байна.

БАТАЛГААЖУУЛАЛТЫН АРГА ЗҮЙ, ҮЙЛ ЯВЦ

Баталгаажуулалтын багийн бүрэлдэхүүнд Жереми Вийт (Коффи Интернейшнл Девелопмент компанийн зөвлөх), Харрисон Митчел (Коффи Интернейшнл Девелопмент компанийн зөвлөх) болон Ц.Жигдэн (Далайван Аудит компанийн захирал) нар багтан үйл ажиллагаа явуулсан билээ. Тим Руффер болон Даниел Таппитаке нар үйл ажиллагааг ерөнхийлөн хянах, удирдлагаар хангах үйл ажиллагааг эрхлэн явуулсан юм. Багийн гишүүд ОУИТБС-ын Баталгаажуулалтын зааварт дурдагдсан арга зүйг ашиглан үнэлгээг явуулсан болно.

2009 оны 10 дугаар сараас Баталгаажуулалтын баг бэлтгэл ажлаа хангаж эхэлсэн ба үүний хүрээнд:

- Монгол улс дахь ОУИТБС-ын үйл явцын талаарх баримт бичгийн судалгаа;
- Монголын ОУИТБС-ын Ажлын албатай хамтран төлөвлөлтийн чиглэлээрх хэд хэдэн удаагын яриа хэлэлцээр;
- Баталгаажуулалтын хандлагын талаар Олон улсын ОУИТБС-тай ярилцан, хэлэлцэх;
- Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олборлох компаниудад хандан бичгээр хүсэлт илгээн Баталгаажуулалтын өөрийн үнэлгээний хуудсын бөглөх хүсэлт гаргах (Хавсралт В-г үзнэ үү);
- Уулзалтуудын цагийн хуваарийг бэлтгэн ОУИТБС-ын Ажлын албаар дамжуулан зохион байгуулах;
- Баталгаажуулалтын арга зүйн талаар багийн хэмжээнд хэлэлцэх.

зэрэг үйл ажиллагаа багтаж байв.

Баталгаажуулалтын баг Улаанбаатар хотод 2009 оны 11 дүгээр сарын 15-21-ны хооронд ажилласан. Нийт нэг долоо хоногийн хугацаанд багийн гишүүд доорх уулзалтуудыг хийлээ. Үүнд:

- **Оролцогч талуудын төлөөлөлтэй уулзах** – ҮЗ (ЗГ-ын ерөнхий хянан зохицуулах байгууллага), Ажлын хэсгийн (ЗГ, иргэний нийгэм болон компаниудын төлөөлөл бүхий) гишүүдтэй ганцаарчлан болон бүлгээр уулзах болон Ажлын хэсгээс гадуурх бусад ерөнхий төлөөлөлтэй уулзах. Уулзаж ярилцсан оролцогчдын нэрсийн жагсаалтыг Хавсралт Г дээрээс харна уу.
- **Танилцуулах уулзалт** – Ажлын хэсгийн гишүүдтэй хувийн журмаар уулзан Баталгаажуулагч нарын зүгээс анхан шатны үр дүнгээ танилцуулах.

Монгол улсад ажиллаад ирсэнийхээ дараагаар багийн гишүүд энэхүү тайлангын анхны хувилбарыг гаргасан юм. Тайланг эцэслэн гаргахын өмнө тухайн хувилбарыг Монголын ОУИТБС-ын оролцогч талууд болон ОУИТБС-ын Олон улсын нарийн бичгийн дарга нарын газарт илгээн санал авсан болно.



БҮЛЭГ 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тайлангын энэхүү бүлэг нь ОУИТБС-ын 2008 оны Үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан гол ажлуудын талаарх хураангуйг агуулж буй болно (Төлөвлөгөөг бүрэн эхээр нь Хавсралт Е дээрээс үзнэ үү). Төлөвлөгдсөн ажил болгоны хажуу хэсэгт Баталгаажуулагч нарын гаргасан товч үнэлгээг бичсэн байгаа болно. ОУИТБС-ын зааварчилгааны хүрээнд шаардагдсаны дагуу ОУИТБС-ын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажил болон биелэлтийг нийтлэг байдлаар товчлон дүгнэсэн үнэлгээг мөн багтаасан болно.

ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АЖЛУУД	БАТАЛГААЖУУЛАГЧДЫН ҮНЭЛГЭЭ
ЗГ ОУИТБС-ын талаар олон нийтэд хандан мэдэгдэл хийх	Биелсэн
ҮЗ болон Ажлын хэсгийг байгуулах	Биелсэн
ОУИТБС-ын Ажлын албыг байгуулах	Биелсэн
ОУИТБС-ын хэрэгжилтийн талаар семинар зохион байгуулах (ЗГ, ТББ болон компаниуд)	Биелсэн
ОУИТБС-ын гарын авлага, товхимолыг Монгол хэлэнд орчуулах	Биелсэн
Хууль болон зохицуулалтыг баримт бичгүүдийг хэвлэн нийтлэж, оролцогч талуудад түгээх	Биелсэн
2006 болон 2007 оны аудитын нэгтгэл хийх аудиторыг сонгон шалгаруулах	Биелсэн
Баталгаажуулалтад бэлтгэх	Биелсэн

ОУИТБС-ын Үйл ажиллагааны төлөвлөгөө нь 30 зорилт, 90 үйл ажиллагаа бүхий цогц баримт бичиг байна. Дээрх хүснэгт нь Баталгаажуулагч нарын үнэлгээг ерөнхий үнэлгээг харуулж буй бөгөөд МОУИТБС нь төлөвлөсөн ажлынхаа хүрээнд ихээхэн ахиц дэвшлийг гарган, үндсэн үйл ажиллагаануудаа хийж гүйцэтгэсэн байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний талаарх нэмэлт тайлбарыг Баталгаажуулалтын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үр дүнг үнэлсэн Баталгаажуулагч нарын үнэлгээний хэсэг дээрээс харж болно.



БҮЛЭГ 4. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ХАНГАСАН БАЙДАЛ

Энэхүү бүлэг дээр Монголын ОУИТБС-ын үйл явц үр дүнг Баталгаажуулалтын хүснэгтэд дурдагдсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу үнэлсэн юм. Шалгуур үзүүлэлт бүр дээр тухайн шалгуур үзүүлэлтүүдийг хэрхэн хөрвүүлэн ойлгосон болохыг (шаардлагатай тохиолдолд) мөн тайлбарласан. Шалгуур үзүүлэлт болгоноор гаргасан бидний үнэлгээ нь тухайн шалгуур үзүүлэлтийн хүрээнд гарсан ахиц дэвшил (үйл явц, үр дүн), оролцогч талуудын санал бодол (оролцогч талуудын үнэлгээ) болон бидний зүгээс өгөх эцсийн ерөнхий үнэлгээг (баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ) багтаасан болно. Хураангуй Баталгаажуулалтын хүснэгтийг Хавсралт А дээр үзнэ үү.

ЭЛСЭН ОРОХ ЯВЦ

1. ЗАСГИЙН ГАЗАР ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮСЭЛ СОНИРХОЛТОЙ БАЙГАА ТУХАЙГАА ОЛОН НИЙТЭД ХАНДАЖ ОЙЛГОМЖТОЙ МЭДЭГДЭЛ ХИЙСЭН ҮҮ?

Үйл явц, үр дүн

2006 оны 10 дугаар сард хуралдсан УИХ-ын Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын хамтарсан хуралдаанаар Монгол улс ОУИТБС-д нэгдэн орох санаачилгыг дэмжин Монгол улсын ЗГ-т энэ чиглэлээр холбогдох үйл ажиллагаа явуулан санаачилгад нэгдэн орохыг даалгажээ. ЗГ 2006 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн хуралдаанаараа ОУИТБС-д нэгдэн орохыг баталгаажуулж Засгийн газрын зүгээс албан ёсоор ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр институцын үндсэн бүтцийг бий болгох тогтоол гаргажээ. ЗГ-ын 2006 оны 1 тоот тогтоолоор ОУИТБС-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хянан зохицуулах үүрэг бүхий ҮЗ-ийг байгуулан бүрэлдэхүүнийг нь баталсан байна. Тухайн үеийн Ерөнхий сайд С.Баяр ОУИТБС-ын талаар өөрийн хэлсэн үг, ярилцлагуудад олонтоо дурдсаны хажуугаар ЗГ-ын 1 дүгээр тогтоолын талаар олон тооны сонинд нийтлэн мэдээлжээ.

Оролцогч талуудын үнэлгээ

Уулазн ярилцсан оролцогч талын төлөөллүүд бүгд ЗГ-аас ОУИТБС-ыг хэрэгжүүлэх хүсэл, сонирхолтой байгаагаа олон нийтэд хандан ойлгомжтойгоор мэдэгдэл хийсэн болохыг хүлээн зөвшөөрсөн.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Шалгуур үзүүлэлт биелсэн.

2. ЗАСГИЙН ГАЗАР ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ ИРГЭНИЙ НИЙГМИЙНХЭН БОЛОН КОМПАНИУДТАЙ ХАМТРАН АЖИЛЛАХ АМЛАЛТ ГАРГАСАН УУ?

Үйл явц, үр дүн

ЗГ-ын 1 дүгээр тогтоолоор ОУИТБС-ын ҮЗ-д иргэний нийгмийн төлөөллийг багтаахаар заажээ. ҮЗ-ийн дүрэмд “ЗГ, олборлох үйлдвэрлэл эрхлэж буй компаниуд болон иргэний нийгмийн тэгш төлөөлөлтэй” байхаар заажээ. Улмаар ОУИТБС-ыг хамтран хэрэгжүүлэх, хамтран ажиллах 3 талын (ЗГ, компани, иргэний нийгэм) Санамж бичгийг боловсруулан ЗГ-ын газрын зүгээс оролцогч талуудтай хамтран ажиллах сонирхолтой буйгаа бүрэн баталгаажуулж энэхүү Санамж бичгээр нийтлэг 9 үүрэг болон оролцогч тал болгоны (ЗГ, компани, иргэний нийгэм) хүлээх 4 үүргийг тодорхойлжээ. ҮЗ болон Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш ҮЗ-ийн хуралдаан 4 удаа, Ажлын хэсгийн хуралдаан нийт 9 удаа зохион байгуулагдаад байна (2009 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар).

Оролцогч талуудын үнэлгээ

Бүх оролцогч талууд ЗГ-ын зүгээс ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд иргэний нийгэм, компаниудтай хамтран ажиллах сонирхолтой буйгаа бүрэн баталгаажуулсан ба энэхүү шалгуур үзүүлэлт биелсэн хэмээн үзэж байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Шалгуур үзүүлэлт биелсэн.

3. ЗАСГИЙН ГАЗАР ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭЛТИЙГ ХАРИУЦАН УДИРДАХ ХҮНЭЭ ТОМИЛСОН УУ?

Үйл явц, үр дүн

ҮЗ-ийн дүрмийн 4 дүгээр зүйлд ОУИТБС-ын ҮЗ-ийн дарга нь Монгол Улсын Ерөнхий Сайд байхаар заажээ. Ерөнхий сайдын Ахлах зөвлөх Б.Эрдэнэсүрэнг ҮЗ-ийн Нарийн бичгийн даргаар томилон, ажилуулж байна.

3 талын санамж бичгийн 10 дугаар зүйлийн дагуу олон талын оролцоо бүхий Ажлын хэсэг болон ОУИТБС-ыг хэрэгжүүлэх бие даасан Ажлын алба байгуулах тохиролцоонд хүрсэн байна. Үүний хүрээнд Ажлын албыг 2007 онд байгуулсан бөгөөд одоогоор орон тооны 2 ажилтан болон 1 гэрээт Мэдээлэл, харилцааны зөвлөхтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

Оролцогч талуудын үнэлгээ

ЗГ өөрийн өндөр албан тушаалтаныг ОУИТБС-ыг хариуцан удирхаар томилсон тул бүх оролцогч талууд энэхүү шалгуур үзүүлэлт биелсэн хэмээн үзэж байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Одоогоор ҮЗ-ийг боломжит хамгийн дээд албан тушаалтан буюу Монгол улсын Ерөнхий сайд даргалж байна. Тиймээс энэхүү шалгуур үзүүлэлтийг Монгол улс хангасан хэмээн үзэж байна.

4. ХЭМЖИЖ БОЛОХУЙЦ ЗОРИЛТУУД, ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ОРШИЖ ЧАДАВХИД (ЗАСГИЙН ГАЗАР, ХУВИЙН ХЭВШИЛ, ИРГЭНИЙ НИЙГЭМ) ГАРЧ БОЛЗОШГҮЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ЗЭРГИЙГ АГУУЛСАН, ЗАРДЛЫГ БҮРЭН ТУСГАСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖ ХЭВЛЭН НИЙТЭЛСЭН ҮҮ?

Үйл явц, үр дүн

Хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа болон зардлыг бүрэн тусгасан Үйл ажиллагааны төлөвлөгөөг ҮЗ-ийн 2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталжээ. Энэхүү Үйл ажиллагааны төлөвлөгөөг нийт 6 байгууллагын вебсайт дээр байрлуулсан ба эдгээрийн тоонд яамд, агентлагууд болон ТББ-уудын вебсайт багтаж байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг товхимол болгон оролцогч талуудад тарааснаас гадна www.eiti.mongolia.mn вебсайт дээрээс үзэх боломжтой байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Уулзан ярилцсан бүх оролцогч хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа болон зардал болон чадавхийн асуудлаарх үнэлгээг бүрэн тусгасан Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэвлэн нийтэлсэн гэдэг баримттай санал нэгдсэн.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Үйл ажиллагааны төлөвлөгөө нь бүрэн хэмжээний дэлгэрэнгүй баримт бичиг болсон бөгөөд нийт 30 зорилт, 90 үйл ажиллагааг багтаасан байна. Гэхдээ Баталгаажуулалтын зааварт заасны дагуу үйл ажиллагаа болгонд хамаарах зардлыг бүрэн тусгаагүй мөн гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээг (эрсдлийн дүн шинжилгээ болон эрсдлийг бууруулах хүчин зүйлсийг тооцоогүй) агуулаагүй байна. Баталгаажуулалтын

багийн зүгээс Үйл ажиллагааны төлөвлөгөө нь гүйцэтгэх үйл ажиллагаанд бус харин гарах үр дүнд тулгуурласан байх ёстой хэмээн үзэж байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан гаргаж, төлөвлөгөөнд тавигдах шаардлагын үндсэн хэсгүүд нь бүрэн тусгагдсан учраас энэхүү шүүмжлэл нь шалгуур үзүүлэлтийн биелэлтийг няцаах хангалттай шалтгаан болохгүй билээ. Тиймээс бидний зүгээс энэхүү шалгуур үзүүлэлт биелэгдсэн хэмээн үзэж байна.

БЭЛТГЭЛ ХАНГАХ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮЙЛ ЯВЦ

5. ЗАСГИЙН ГАЗРААС ОУИТБС-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН АЖЛЫН БҮТЦИЙГ (ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ, АЖЛЫН ХЭСЭГ) БАЙГУУЛСАН УУ?

Үйл явц, үр дүн

ҮЗ нь ОУИТБС-ыг хянан зохицуулах эрх мэдлийг эдэлж буй хамгийн дээд түвшний байгууллага билээ. 2009 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар Ажлын хэсэгт ЗГ-ыг төлөөлсөн 4 төлөөлөл, УИХ болон үүний харьяа байгууллагуудын 4 төлөөлөл, олборлох үйлдвэрлэл эрхлэж буй компаниудын 5 төлөөлөл болон иргэний нийгмийн 5 төлөөлөлтэй үйл ажиллагаа явуулан сонирхлын олон төрөл бүлгүүдийг бүрэн хэмжээгээр төлөөлөн үйл ажиллагаа явуулж байна.

ҮЗ-ийн дүрмээр¹ (2006 оны 5 дугаар сарын 12 нд батлагдсан) зөвлөлийн гишүүд нь хэлэлцэх асуудлыг санал болгох, үзэл бодлоо илэрхийлэх эрхээр (14 дүгээр заалт) хангагдсан байна. ҮЗ-ийн үйл ажиллагаанд Ажлын хэсэг дэмжлэг үзүүлэн (ҮЗ-ийн дүрмийн 12 дугаар заалтын дагуу) үйл ажиллагаа явуулж байна. ЗГ-ын 3 дугаар тогтоолын дагуу Ажлын хэсэг нь 2006 оны 1 дүгээр сард байгуулагдсан бөгөөд үүнээс хойш нийтдээ 9 удаагын хуралдааныг хийгээд байна. 2009 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар Ажлын хэсэгт 25 гишүүн хамаарч байгаагаас Ажлын хэсгийн дарга (Ерөнхий сайдын Ахлах зөвлөх), Засгийн газрын 8 төлөөлөл, олборлох үйлдвэрлэл эрхлэж буй компаниудын 7 төлөөлөл (Уул уурхайн компаниудын болон нүүрс олборлогч компаниудын эвсэл, холбоодын 2 төлөөллийг багтаагаад) болон иргэний нийгмийн 9 төлөөлөлтэй байна. Монголын МНБ-ын институтын Ерөнхийлөгч мөн Ажлын хэсэгт иргэний нийгмийн төлөөлөл болон багтсан байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Уулзан ярилцсан бүх оролцогч талуудын зүгээс ЗГ ОУИТБС-ыг хянан зохицуулах үүрэг бүхий олон талын оролцоот бүлгийг үүсгэн байгуулсан хэмээн үзэж байна .

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Баталгаажуулагчдын зүгээс ҮЗ үүсгэн байгуулагдсан цагаас хойш нийтдээ 4 удаа л хуралдсанаас Баталгаажуулагч нарыг Монгол улсад ажиллахаас өмнөх сүүлийн 18 сарын хугацаанд огт хуралдаагүй байгаад санаа зовниж буйгаа илэрхийлж байсан билээ. Үүний шалтгааныг тухайн үеийн Ерөнхий сайдын эрүүл мэндийн байдалтай холбон тайлбарлаж байлаа. Харин ҮЗ-ийн 4 дэхь хуралдаан 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр буюу Баталгаажуулалтын баг Монгол улсад ажилласнаас хойш долоо хоногийн дараа болжээ.

Баталгаажуулагч нар мөн Ажлын хэсэг болон ҮЗ-ийн хуралдаануудын талаарх мэдээлэл одоогоор хязгаарлагдмал, хаалттай байгаа болохыг тэмдэглэж байна. Ажлын хэсэг болон ҮЗ-ийн хуралдааны тэмдэглэлүүдийг Монголын ОУИТБС-ийн вебсайт дээр байрлуулан, олон нийтийн хүртээл болгоогүй байна. Эдгээр зүйлсийг үл харгалзан энэхүү шалгуур үзүүлэлт биелсэн хэмээн үзэж байна.

¹ Хавсралт Е-г үзнэ үү

6. ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦАД ИРГЭНИЙ НИЙГЭМ ОРОЛЦОЖ БАЙНА УУ?

Үйл явц, үр дүн

Монголын ОУИТБС нь бодитоор олон талын оролцоот үйл явц болж чадсан бөгөөд олон тооны иргэний нийгмийн төлөөлөл Ажлын хэсэг дэхь өөрсдийн төлөөлөл, үйл ажиллагаа болон бүтцийн талаар сэтгэл хангалуун байгаа талаараа Баталгаажуулагч нарт илэрхийлж байсан. ҮЗ болон Ажлын хэсэг нь ил тод байдал, нийгмийн хөгжил болон байгаль орчны ТББ-уудын¹ хэд хэдэн төлөөлөлтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

- ҮЗ дэхь ТББ-уудын гишүүнчлэл – 5 төлөөлөл (үүнээс 4 нь ТАН эвсэлээс).
- Ажлын хэсэг дэхь ТББ-уудын гишүүнчлэл – 9 төлөөлөл (үүнээс 4 нь ТАН эвсэлээс).
- Иргэний нийгмийнхэний гаргасан 4 саналыг ҮЗ болон Ажлын хэсгийн хуралдаанаар авч хэлэлцсэн.
- ТББ-уудын эвсэл нь Монгол улс дахь ОУИТБС-ын хэрэгжилтийг бүрэн хэмжээгээр туслан дэмжлэг үзүүлдэг бөгөөд үүний хажуугаар мөн бие даасан үйл ажиллагааг явуулж байна.

Доор дурдсан хэсэг дээр ОУИТБС-ын Ажлын хэсэг болон Монгол улсын ЗГ энэхүү санаачилгын хэрэгжилтэд иргэний нийгмийн оролцоог идэвхтэйгээр эрэлхийлж буйг харуулах нотолгоо болно:

- ОУИТБС-ыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх 3 талын санамж бичиг, 2007 оны 4 дүгээр сар².
 - Нэгдэн орогч талуудын тоонд ЗГ, компаниуд болон иргэний нийгмийн төлөөлөл багтсан.
- ҮЗ-ийн дүрэм¹
 - Заалт 6: “ҮЗ нь УИХ-ын харьяа байгууллагууд, Сайдүүд, яамд болон агентлагууд, уул уурхайн компаниуд, иргэний нийгэм, ТББ-уудын тэгш гурван талын төлөөллөөс бүрдэнэ.”
- ҮЗ болон Ажлын хэсэг дэхь иргэний нийгмийн идэвхтэй оролцоо:
 - ҮЗ-ийн 13 гишүүний 5 нь, Ажлын хэсгийн 25 гишүүний 9 нь иргэний нийгмийн төлөөлөл байна (2009 оны 11 дүгээр сарын байдлаар).
 - ҮЗ болон Ажлыг хэсгийн хуралдааны тэмдэглэлээс харахад иргэний нийгмийг төлөөлсөн гишүүдийн идэвхтэй оролцоог Баталгаажуулагч нар олсон.
- ОУИТБС-ын хүрээнд хийгдсэн Монгол улсын анхдугаар үндэсний тайлан дээрх иргэний нийгмийн үнэлгээ:
 - Анхлан хийгдсэн аудитын нэгтгэл дээр иргэний нийгмийн төлөөлөл өөрсдийн үнэлгээг гүйцэтгэсэн.
- ОУИТБС-ын Ажлын албанаас иргэний нийгмийн оролцоотойгоор гүйцэтгэсэн олон нийтэд хандсан үйл ажиллагаанууд:
 - 2009 оны 5 болон 9 дүгээр саруудад Өвөрхангай, Сэлэнгэ аймгуудад ОУИТБС-ыг танилцуулан ЗГ, компаниуд болон иргэний нийгмийн санал бодлыг сонсох зорилго бүхий 2 өдрийн семинар.

¹ Бүрэн хэмжээний жагсаалтыг Хавсралт Е дээрээс үзнэ үү.

² Хавсралт Е дээрээс үзнэ үү

- Сангийн яам (СЯ), Үндэсний татварын ерөнхий газар (ҮТЕГ), Ашигт малтмалын газар, Уул уурхайн үндэсний ассоциац (УУҮА), Байгаль орчны яам болон Ил тод сан, Нээлттэй нийгэм форум, Хил хязгааргүй алхам, Хүний эрх хөгжил төв зэрэг иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл энэхүү семинаруудад оролцсон.
- Ажлын алба нь мөн “2007 онд Өмнөговь, Сүхбаатар аймгууд болон Зүүн бүс, 2008 онд Өвөрхангай аймагт хоёр удаа, 2009 онд Өмнөговь, Хэнтий аймаг зэрэг Зүүн бүс болон Хөвсгөл аймагт ТАН эвсэлийн гишүүн иргэний нийгмийн байгууллагуудын зохион байгуулсан семинарт дэмжлэг үзүүлсэн.”

Монгол улсын олборлох үйлдвэрлэлийн салбарт мөн өөр нэгэн иргэний нийгмийн санаачилга болох Хариуцлагатай уул уурхайн санаачилга хэрэгжиж буй болохыг дурдах хэрэгтэй бөгөөд энэхүү санаачилгын хүрээнд 2006 оноос иргэний нийгэм, бизнес эрхлэгчид болон ЗГ-ын хамтарсан яриа, хэлэлцүүлгийг ил тод байдал, байгаль орчны талаар хүлээх хариуцлага болон олон нийтийн талаарх асуудлаар өрнүүлж байна. Хариуцлагатай уул уурхайн санаачилга болон ОУИТБС нь Монгол улс дахь иргэний нийгмийн дуу хоолой хүчтэй байгааг харуулж байгаагын хажуугаар тэдний дуу хоолойг компаниуд болон ЗГ ч гэсэн анхааралтайгаар хүлээн авч байгааг харуулж байна.

Оролцогч талуудын үнэлгээ

ЗГ-ын зүгээс санаачилгын нийт үйл ажиллагаанд иргэний нийгмийн оруулж буй хувь нэмэрт ихээхэн талархалтай хандаж буй ба Нээлттэй нийгэм форумын талаар “ОУИТБС-ыг анхлан эхлүүлсэн, голлох хөдөлгөгч хүч болсон байгууллага бөгөөд мэдээллийн голлох эх үүсвэр” хэмээн цохон тэмдэглэж байлаа. ЗГ-ын зүгээс мөн ОУИТБС-ийг дэмжих зорилгоор орон нутагт иргэний нийгмийн байгууллагуудын явуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байхыг хүсэлт болгон ҮЗ-ийн зүгээс албан захидал явуулсан болохыг дурдаж байсан.

Олборлох үйлдвэрлэл эрхлэж буй компаниудын зүгээс мөн ОУИТБС-ыг дэмжих, олборлох салбарт нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх чиглэлээр гүйцэтгэж буй иргэний нийгмийн байгууллагуудын үүрэг ролийг мөн үнэлж байгаа билээ. Хэдийгээр заримдаа компаниудын зүгээс иргэний нийгмийнхний үзэл бодлын зөрчилтэй тулгардаг хэдий ч олборлох үйлдвэрлэлийн салбарт явагдаж буй хэлэлцүүлгийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын ач холбогдлыг сайтар ойлгон, хүлээн зөвшөөрч байгаа юм. Баталгаажуулагч нарын уулзан ярилцсан иргэний нийгмийн төлөөллүүд нь өөр өөр үзэл бодолтой байсан хэдий ч өргөн хүрээнд авч үзвэл ялгаа нь зөвхөн эхлээд орлогын ил тод байдал уу эсвэл байгаль орчны асуудлууд уу хэмээх хүрээнд л энэ нь илэрч байсан юм. Орлогын ил тод байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн бүлгүүд нийт үйл явцад сэтгэл хангауун байгаагаа илэрхийлж байсан бөгөөд ялангуяа ОУИТБС-ын хүрээнд урьд өмнө хаалттай байсан мэдээллийг ЗГ болон компаниудын түвшинд ил тод болгосон явдлыг чухалчлан цохон тэмдэглэж байсан билээ. Эдгээр ТББ-ууд цаашид ч хийх ажил байгааг дурдаж байсан бөгөөд энэ нь Монголын ОУИТБС-ын хэрэгжилтийг цаашид шалгах нэгэн гол шалгалт болох билээ. Байгаль орчны хүрээнд, ТББ-ын нэг төлөөллийн зүгээс байгаль орчны асуудалд илүүтэй анхаарал хандуулахгүй байгаад сэтгэл дундуур буйгаа илэрхийлсэн хэдий ч бусад ТББ-ууд ОУИТБС-ын гол зорилго нь байгаль орчноос илүүтэйгээр орлогын ил тод байдал болохыг хүлээн зөвшөөрч байсан.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Шалгуур үзүүлэлт биелсэн.

7. ОУИТБС- ҮГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦАД КОМПАНИУД ОРОЛЦОЖ БАЙНА УУ?

Үйл явц, үр дүн

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олборлох үйлдвэрлэл эрхлэж буй компаниудын төлөөлөл 2007 оны 4 дүгээр сард Монголын ОУИТБС-ийн голлох үүрэг, үйл ажиллагааг тусгасан Санамж бичигт нэгдэн гарын үсэг зурцгаажээ. Эдгээрийн тоонд Монголын УУҮА, Нүүрс Ассоциац болон Эрдэнэт, Айвенхоу Майнз, Бороо Голд зэрэг томоохон компанийн төлөөлөл багтсан байна. Тодорхой тооны компаниуд болон УУҮА зэрэг үйлдвэрлэлийн эвсэл холбоод ОУИТБС-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцон ҮЗ болон Ажлын хэсэг дэхь өөрийн төлөөллөөр дамжуулан үйл ажиллагаа явуулж байна. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлүүдээс харахад компаниудын төлөөлөл нь ОУИТБС-ын үйл явцад идэвхтэй оролцогч болох нь харагдаж байна.

2006 онд нийт 60 компани ЗГ-т төлсөн татвар, хураамжаа тайлагнах ОУИТБС-ын шаардлагыг биелүүлсэн байна. 2007 оны аудитын нэгтгэлээр тайлан гаргасан компаниудын тоо нь 103 болсон болон 2008 онд 113 компани тайлангаа гаргасан байна. Үүнээс үзвэл компаниудын зүгээс Монгол улсад өрнөж буй ОУИТБС-ын талаарх мэдээлэл, мэдлэг нэмэгдсээр байгааг харуулж байна.

Доорх хэсэгт Монгол улсын ЗГ болон ОУИТБС энэхүү санаачилгын хэрэгжилтэд компаниудыг идэвхтэйгээр оролцуулахын тулд доорх үйл ажиллагааг явуулж байна:

- ОУИТБС-ыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх 3 талын санамж бичиг, 2007 оны 4 дүгээр сар¹:
 - Нэгдэн орсон талуудын тоонд ЗГ, компаниуд болон иргэний нийгмийн төлөөлөл багтсан.
- ҮЗ-ийн дүрэм⁴:
 - Заалт 6: “ҮЗ нь УИХ-ын харьяа байгууллагууд, сайдууд, яамд болон агентлагууд, уул уурхайн компаниуд, иргэний нийгэм, ТББ-уудын тэгш гурван талын төлөөллөөс бүрдэнэ.”
- ҮЗ болон Ажлын хэсэг дэхь компаниудын идэвхтэй оролцоо:
 - ҮЗ-ийн гишүүдийн 5 нь, Ажлын хэсгийн 25 гишүүний 7 нь иргэний нийгмийн төлөөлөл байна (2009 оны 11 дүгээр сарын байдлаар).
 - ҮЗ болон Ажлыг хэсгийн хуралдааны тэмдэглэлээс уул уурхайн компаниудыг төлөөлсөн гишүүдийн идэвхтэй оролцоог Баталгаажуулагч нар харсан.
- Монголын УУҮА-тай хамтран ОУИТБС-ын Ажлын албаны зохион байгуулсан олон нийтэд мэдээлэл хүргэх хөтөлбөрт 2009 оны 5 болон 9 дүгээр саруудад оролцсон.
- ОУИТБС-ын Ажлын алба 2009 оны 111 дүгээр сард болсон “Discover Mongolia” Олон улсын уул уурхайн хөрөнгө оруулагчдын 7 дугаар форум дээр санаачилгын талаар танилцуулга хийсэн. Энэ үеэр Ажлын алба Хариуцлагатай уул уурхайн санаачилгатай нэг павильонд цуг ажиллаж хөрөнгө оруулагч нар болон сонрхсон компаниудад ОУИТБС-ын талаар танилцуулсан.
<http://www.discovermongoliaforum.com/>
- ОУИТБС-ын Ажлын алба компаниудад зориулан хоёр удаагийн сургалт зохион байгуулж төлсөн татвар хураамжаа ОУИТБС-ын хүрээнд хэрхэн тайлагнах талаар зөвлөгөө өгсөн (Ажлын хэсгийн хуралдаан, 2009 оны 6 сарын 5).

¹ Хавсралт Е-г үзнэ үү.

Оролцогч талуудын үнэлгээ

Бидний уулзаж ярилцсан хэд хэдэн компанийн төлөөлөл (Айвенхоу Майнз, Бороо Голд, МАК, Эрдэнэт) ОУИТБС-д гарч буй ахиц дэвшилд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж, ЗГ-т төлсөн татвар, хураамж, төлбөрөө ил тод болгохыг дэмжиж буйгаа илэрхийлсэн.

Нэг компанийн зүгээс Ажлын хэсгийн хуралдааныг цаашид олон нийтийн форум хэлбэрээр зохион байгуулж байх нь олон нийтийг татан оруулах, Монголын ОУИТБС-ыг түгээн дэлгэрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болохыг цохон дурдаж байсан. Тухайн компани мөн хуралдааны тэмдэглэлүүдийг мөн Интернетээр дамжуулан олон нийтийн хүртээл болгож байх санал гаргаж байсан.

Иргэний нийгмийн төлөөлөл нь Монголын ОУИТБС дахь компаниудын оролцоонд ерөнхийдөө сэтгэл хангалуун байсан бөгөөд ялангуяа Ажлын хэсэг дэх тэдний оролцоонд сэтгэл хангалуун байлаа. Гэхдээ цаашид компаниудын зүгээс ОУИТБС-ыг дэмжих нь ихээхэн ач холбогдолтой болохыг санал болгож байсан. Иргэний нийгмийнхэн мөн цаашид компаниудын зүгээс ОУИТБС-ыг өргөжүүлэн голлох зарчмуудыг (ил тод байдал болон олон нийтэд тайлагнах, хариуцлагатай байдал зэрэг одоогоор Монголын ОУИТБС-д хамрагдаагүй байгаа асуудлууд) хэрэгжүүлж эхлэхэд дэмжлэг үзүүлэх ёстой хэмээх саналыг мөн гаргасан. Тухайлбал иргэний нийгмийн төлөөлөл гэрээний болон байгаль орчны ил тод байдлын асуудлыг голлон хөндсөн бөгөөд эдгээр нь одоогоор ил тод бус байгаа ч ОУИТБС-ын зарчмуудын дагуу хэрэгжих ёстой салбарууд билээ.

Монгол улсын ЗГ-ын зүгээс компаниудын оролцооны тал дээр ерөнхийдөө сэтгэл хангалуун байна. Гэхдээ Ажлын албаны зүгээс олон тооны компаниуд тайлангаа хоцроодог нь аудитын нэгтгэл хийх үйл ажиллагаанд ихээхэн хүндрэл учруулдаг болохыг дурдаж байсан. Түүнчлэн зарим компаниуд сонгогдсон аудитын компанийн зүгээс тодруулга хүсэх тохиолдолд цаг тухайд нь гаргаж өгдөггүй нь аудитын нэгтгэлийн тайланг цаг тухайд нь гарган, эцсийн байдлаар өргөн мэдүүлэхэд ихээхэн саад учруулдаг байна. Аудитын компанийн зүгээс санал болгосноор компаниудын эвсэл холбоод болон төрийн байгууллагуудын зүгээс компаниудыг тайлан болон хүссэн хариулт тодруулгыг цаг тухайд нь гаргуулж байх талаар арга хэмжээ авах хэрэгтэй ажээ.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Шалгуур үзүүлэлт биелсэн.

Гэвч Монгол улсад 200 гаруй уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж байгаа ч ҮЗ болон Ажлын хэсэгт жижиг болон дунд хэмжээний компаниудын төлөөлөл байхгүй буйг дурдах хэрэгтэй. Эдгээр жижиг болон дунд хэмжээний компаниуд нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын дийлэнх хувийг эзлэж байгаа билээ (үйл ажиллагааны цар хүрээ, үйлдвэрлэлийн хэмжээгээр бус харин тоон үзүүлэлтээр). Цаашдаа Монголын ОУИТБС нь эдгээр компаниудыг илүү зохистойгоор хамруулах талаар анхаарал хандуулах шаардлагатай байна.

8. ЗАСГИЙН ГАЗАР ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦАД ТУЛГАРЧ БУЙ АЛИВАА СААД ТОТГОРЫГ АРИЛГАЖ БАЙНА УУ?

Шалгуур үзүүлэлт тодорхой, ойлгомжтой эсэх

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хувьд Баталгаажуулагч нар өөрсдийн зүгээс төрөл бүрийн хууль, тогтоомжийн асуудлууд болон ОУИТБС-ын хэрэгжилтэд тулгарч буй бусад саад тотгорыг авч үзсэн.

Үйл явц, үр дүн

Үндэслэл: Хууль тогтоомж, зохицуулалт болон институцийн орчин

ОУИТБС-ыг Монгол улсын хууль зүйн болон зохицуулалтын үйл явцад хамруулан баталгаажуулсан хэд хэдэн тогтоол, шийдвэр гарчээ. Эдгээр голлох баримт бичгүүдийн тоонд:

- 2007 оны 4 дүгээр сард гарын үсэг зурсан ОУИТБС-ыг хамтран хэрэгжүүлэх, хамтран ажиллах 3 талын буюу ЗГ, компани, иргэний нийгмийн байгууллагуудын эвсэлийн хоорондын санамж бичиг.
- Монгол улсын ЗГ-ын 2007 оны 3 дугаар сарын 28-ны 80 дугаар тогтоол-ОУИТБС-ийн хэрэгжилтэд оролцож буй төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны тухай.
- Монгол улсын Ашигт малтмалын хуулийн 48.9 болон 48.10 дугаар заалтууд (Албан ёсний орчуулга- 2006 оны 10 дугаар сарын 30).

Санамж бичиг

Энэхүү Санамж бичгээр Монгол улсад хэрэгжиж буй ОУИТБС-ын үндсэн үйл ажиллагааны цөм болсон Ажлын хэсгийн үүрэг, үйл ажиллагааг тодорхойлон гаргасан байна. Хэдийгээр энэ нь албан ёсний хууль эрх зүйн баримт бичиг биш харин илүүтэйгээр даган мөрдөх ёс зүйн баримт бичиг ч гэсэн ҮЗ-д хандан Ажлын хэсгийн гаргасан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээрх үндсэн баримт бичиг болсон байна. Энэхүү баримт бичигт дурдагдсан гол үзэл баримтлалын тоонд: зөвшилцөлд тулгуурлан шийдвэр гаргах; ОУИТБС-ын стандартуудыг хүлээн зөвшөөрөх; голлон хөтлөх зарчмуудыг тогтоох болон ОУИТБС-ын хэрэгжилтийг Монгол улсад хангах хууль зүйн болон байгууллагын/ институцын бүтцийг хангах зэрэг асуудлууд орж байна.

80 дугаар тогтоол (2007)

ЗГ-ын 80 дугаар тогтоол нь ОУИТБС-ын хүрээнд ЗГ-ын харьяа байгууллагуудын тайлагнах үйл ажиллагааг зохицуулж байна. Энэхүү тогтоол нь төрийн байгууллагуудаас оролцогч талуудын хүрээнд ОУИТБС-ыг түгээн дэлгэрүүлэх шаардлагыг үүсгэж буй бөгөөд илүү практик түвшинд төрийн байгууллагууд ОУИТБС-ыг оролцогч талуудад дэлгэрүүлэх, жил тутмын аудитын үйл ажиллагааны хүрээнд ОУИТБС-ын ҮЗ болон Ажлын хэсэгт өөрийн тайлангаа гарган өргөн мэдүүлэх үйл ажиллагааг голлон зохицуулж буй билээ.

Монгол улсын Ашигт малтмалын хууль

Шинэчлэн батлагдсан Ашигт малтмалын хуулийн 48.9 дүгээр заалтын дагуу лиценз эзэмшигч аж ахуйн нэгж нь татварын албанд төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад төлбөрөө улирал, жил тутам тайлагнаж байх үүрэг ноогдуулдаг. 48.10 дугаар заалт нь лиценз эзэмшигч аж ахуйн нэгж нь тухайн жилийн борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар хураамжаа дараагын жилийн нэгдүгээр улиралд багтаан тайлагнаж байхыг хуульчилсан байна. Гэхдээ ОУИТБС-ын зүгээс энэхүү хуулийн заалтыг компаниудаас мэдээлэл авах зорилгоор тэр бүр ашиглахгүй байгаа нь компаниудын гаргаж байгаа тайлангууд нь ОУИТБС-ын шаардлагад нийцэхээргүй байгаагаас харагдаж байна. Харин ОУИТБС-ын зүгээс тайлангын маягтуудыг сайн дурын үндсэн дээр бөглөн ирүүлэхийг хүсэмжилж буй бөгөөд харин нөгөө талаас тайлангаа заавал ирүүлж байх хуулийн заалт байхгүй байгаа билээ.

Институцийн хүрээнд

Хууль зүйн болон зохицуулалтын асуудлаас гадна, ОУИТБС-ын үйл ажиллагаанд хамаарах хэд хэдэн байгууллага байгаа бөгөөд голлох байгууллагуудын тоонд доорх байгууллага, институцууд багтаж байна. Үүнд:

- ОУИТБС-ын Ажлын алба – ОУИТБС-ын үйл ажиллагааг голлон эрхлэх байгууллага.

- ОУИТБС-ын Ажлын хэсэг – Ерөнхий сайдын ахлах зөвлөх Б.Эрдэнэсүрэн даргалдаг бөгөөд энэхүү Ажлын хэсэг нь одоогоор ОУИТБС-ын бодлого боловсруулах бүтэц болж байна.
- ОУИТБС-ын ҮЗ (Олон талын оролцоот) – Монгол улсын Ерөнхий сайд даргалдаг бөгөөд одоогоор ОУИТБС-ын голлох гүйцэтгэх бүтэц болж байна.

Энэхүү гурван гол бүлгээс гадна 80 дугаар тогтоолоор заасан нилээд олон тооны төрийн байгууллага болон яамд ОУИТБС-ын хэсэг болж буй ба эдгээрт:

- Ерөнхий сайдын ажлын алба
- СЯ
- ЭБЭХЯ (Эрдэс баялаг эрчим хүчний яам)
- СЯ-ны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар
- Үндэсний аудитын газар
- ҮТЕГ
- Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар
- Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
- Гадаадын иргэн, харьяатын хэрэг эрхлэх газар
- Аймаг, сум, дүүргийн түвшний засаг захиргаа

Оролцогч талуудын үнэлгээ

Ихэнх компаниуд Ажлын хэсгийг ихээхэн үр дүнтэй ажиллаж байна хэмээн үзэж байна. Гэхдээ Ажлын хэсэгт багтаагүй компаниудын үзэж байгаагаар Ажлын хэсгийн хуралдааныг олон нийтэд нээлттэй байдлаар зохион байгуулбал гишүүн биш ч гэсэн сонирхсон талууд энэхүү үйл явцыг ажиглах боломжтой болно хэмээн үзжээ. Компаниуд мөн ОУИТБС-ын агуулга болон цар хүрээний талаар зарим нэгэн тайлбарыг гаргаж байв. Компаниудын үзэж байгаагаар зохицуулалтын орчныг бий болгох нь ихэнх тохиолдолд дарамт шахалт үзүүлсэн байдлаар хэрэгждэг ба үүнээс үүдэн бизнесийн орчин тогтворгүйжих хандлагатай болдог байна. Тодорхой хэлбэл компаниуд нь төв болон орон нутгийн түвшинд төрөл бүрийн татвар, төлбөр төлөх шаардлагатай үргэлж тулгарч байдаг бөгөөд эдгээр нь зарим тохиолдолд хоорондоо ихээхэн зөрчилддөг байна. Компаниудын зүгээс Баталгаажуулагчдад хэлэхдээ тэд ЗГ-тай харилцах өөр төрлийн харилцаагаа ч (жишээ нь гэрээ гэх мэт) олон нийтэд нээлттэй болгох боломжтой ч заримдаа ЗГ-ын зүгээс мэдээлэл гаргахгүй байх хүсэлттэй тулгардаг байна. Тэдний санал болгож буйгаар ОУИТБС-ын зарчмуудыг энэхүү салбар руу чиглүүлэн өргөтгөх хэрэгтэй байна.

Төрийн байгууллагуудын төлөөлөл Баталгаажуулагч нарт ихээхэн нээлттэй хандсан ба ялангуяа ОУИТБС-д цаашид тулгарч болох сорилтуудын талаар нээлттэй байсан болно. Тэдний зүгээс доорх голлох асуудлуудыг цохон дурдсан юм. Үүнд:

- Одоогоор Монголын ОУИТБС-ын үйл ажиллагаа нь донорын санхүүжилтээс бүрэн хамааралтай байгаа тул цаашдын тогтвортой байдлын асуудал ихээхэн ноцтой буйн хажуугаар одоогоор энэхүү үйл явцыг төрийг байгууллагуудад өөриймшүүлэн хэрэгжүүлэхэд тодорхой хомсдол байсаар байна.
- Ажлын хэсгээс стратегийн шинжтэй шийдвэр гаргах явдал учир дутагдалтай байгаа явдал. Үүний жишээнд үйл ажиллагааны төлөвлөгөө орох бөгөөд тухайн төлөвлөгөө нь үр дүн дээр бус үйл ажиллагаанд илүү ихээр тулгуурласан байхын хажуугаар эхний хоёр аудитаар илэрсэн алдаа дутагдлыг багасгах, алдааг засварлах төлөвлөгөө байхгүй байгаагаар тайлбарлагдаж болно.
- Төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа сул байгаа нь мэдээлэл цуглуулах болон аудитын нэгтгэл хийхэд ихээхэн саад учруулж буй явдал.
- Төрийн төв байгууллагууд болон орон нутгийн түвшний төрийн байгууллагуудын хоорондын харилцаа холбоо, хамтын ажиллагаа дутмаг байгаа

нь төрийн байгууллагуудын төлөөллийн цохон тэмдэглэж буй хамгийн гол асуудал бөгөөд ялангуяа энэ нь аймаг болон сумын түвшин дэхь татвар хураамж, хандивт гарч буй мөнгөн дүнгийн ихээхэн том хэмжээний зөрүүнээс харагдаж байна.

Иргэний нийгмийнхэн одоогоор ОУИТБС-ын хүрээд буй ололт амжилтад ерөнхийдөө сэтгэл хангалуун байгаа бөгөөд үүний тоонд олон талын оролцоот бүтэц болон зөвшилцөлд суурилсан хандлагад ихээхэн талархалтай хандаж байна. Гэхдээ иргэний нийгмийн төлөөлөл тулгараад буй хэд хэдэн асуудлыг дэвшүүлэн гаргаж ирсэн нь хууль зүйн орчин болон институцын бүтцийн асуудал байлаа. Үүнд:

- Иргэний нийгмийнхэний голлох санаа зовоож буй асуудал нь ҮЗ сүүлийн 18 сарын туршид хуралдаагүй асуудал болж байна. ҮЗ нь Монголын ОУИТБС-ын голлох гүйцэтгэх эрх мэдлийг хадгалсан бүтэц бөгөөд ялангуяа энэхүү хуралдааныг хийлгүй удсанаас хамааран 2006 оны аудитын нэгтгэлээр илэрсэн ихээхэн хэмжээний зөрүүг магадлан тодруулах үйл ажиллагаа орхигдож байна хэмээн иргэний нийгмийн зүгээс үзэж байна.
- Иргэний нийгмийнхэний санал болгосноор төрийн байгууллагууд ихээхэн “салангид тусгаарлагдсан” байдлаар ажиллаж байгаагаас төрийн байгууллагуудын хоорондын харилцаа холбоо маш сул байж үүнээс үүдэн аудитын үйл ажиллагааны гол хэсэг болох нэгтгэсэн тайланг (Маягт 4) гарган өгөхөд ихээхэн саад тотгор учруулж байна.
- Иргэний нийгмийн зүгээс “өөрийшүүлэх тал дээр хомсдолтой” байгаа асуудлыг голлох нэгэн асуудал хэмээн үзсэнээс үүдээд зөрүү үүссэн шалтгааныг тодруулахад саад учирч, шаардлагатай хариуцлага тооцох үйл ажиллагааг удаашруулж байна хэмээн үзэж байна.
- Иргэний нийгмийн санал болгож байгаагаар ОУИТБС-ыг үндэсний болон орон нутгийн хэмжээнд өргөтгөх шаардлагатай буйн хажуугаар улмаар үйл ажиллагааг мөн гэрээний ил тод байдлыг мөн хамруулах хэрэгтэй байна. Учир нь эдгээр хоёр салбар нь (орон нутаг болон гэрээг хамруулан) авлигад өртөж болох магадлал өндөртэй үүний хажуугаар ойрын жилүүдэд уул уурхайн салбараас орж ирэх орлогын хэмжээ ихээр нэмэгдэх төлөвтэй байгаа зэргийг харгалзан үзвэл эдгээр салбарт олон нийтийн хяналт илүү ихээр шаардагдахаар байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Баталгаажуулагч нарын үзэж байгаагаар одоогын хууль зүйн, зохицуулалтын болон байгууллага/институцийн бүтэц нь ОУИТБС-ыг Монгол улсад үр дүнтэйгээр хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний саад тотгорыг учруулж байна. Гэхдээ 2006 оноос хойш хүрсэн ололт амжилт ихээхэн өндөр түвшинд байгааг хажуугаар хоёр удаагийн аудитын нэгтгэлийг гүйцэтгэсэн байна.

Баталгаажуулагч нарын үзэж байгаагаар гол саад тотгорууд доорх шалтгааны улмаас үүдэж байна. Үүнд:

Хууль зүйн болон зохицуулалтын бүтэц

- ОУИТБС-ын хууль

Одоогоор ОУИТБС-ын үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль Монгол улсад байхгүй байна. Харин ЗГ-ын харьяа байгууллагуудын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх 80 дугаар тогтоол болон шинэчлэн найруулсан Ашигт малтмалын хуулиар компаниуд зарим төрлийн мэдээллээ тайлагнаж байх үүргийг үүсгэсэн цөөн тооны заалтууд зэрэг байгаа ч энэ нь ОУИТБС-ын тайлангын маягтуудын шаардлагад бүрэн нийцэхгүй байна. Тийм ч учраас одоо компаниудын тайлангын маягтуудыг зөвхөн сайн дурын үндсэн дээр бөглөн тайлагнаж байгаа бөгөөд компаниудад ноогдох хууль

зүйн хүрээний ямар нэгэн үүрэг хариуцлага байхгүй байна. Үүнийг ОУИТБС-ын нэгэн сул тал гэж Засгийн газар, компаниуд болон иргэний нийгэм зэрэг бүх талууд хүлээн зөвшөөрч байгаа билээ. Үүн дээр нэмээд нэгтгэсэн тайланг гаргаж буй аудитын компаниуд ч үүнийг хүлээн зөвшөөрч байгаа юм.

Энэ талаар гарсан ахиц дэвшилийн хувьд 2009 оны 12 дугаар сард Монголын ОУИТБС 2010-2012 онд хэрэгжүүлэх стратегийн төслийг боловсруулан гаргаж энэ тал дээр холбогдох саналыг авахаар Ажлын хэсгийн гишүүдэд тараагаад байна. Энэхүү стратегид ОУИТБС-ын тусгайлсан хуулийн төслийг боловсруулан гаргаж хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд, газрын тосны болон ураны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй компаниудыг тайлангаа гаргаж өгөх үүргийг бий болгох, хэрэв тайлангаа гаргаагүй болон буруу гаргасан тохиолдолд тодорхой торгууль ноогдуулах зэрэг заалтуудыг оруулахаар төлөвлөжээ. Мөн энэхүү хуулиар лицензийн, үйлдвэрлэлийн, борлуулалтын, экспортын, хөрөнгө оруулалтын болон байгаль орчны нөхөн сэргээлтийн ил тод байдлыг хуульчлан заахаар төлөвлөж байна.

- **Хариуцлага тооцох**

Дээрхийн адилаар ОУИТБС-ын маягтын дагуу мэдээллээ үнэн зөв гаргаж өгөөгүй тохиолдолд хэрэглэх ямар нэгэн хуулийн хариуцлага байхгүй, мөн компаниуд нь маягтуудыг олон улсын аудитын стандартуудын дагуу буюу аудитлагдсан тайлан дээрхийн адил баталгаажсан дүнг тайлагнана гэсэн хуулийн ямар нэгэн заалт үгүй байна. Харин үүнийг гүйцэтгэх цорын ганц зүйл нь маягтууд дээрх “Энэхүү тайланд дурдсан мэдээлэл нь үнэн зөв болохыг баталгаажуулж байна” гэсэн утгатай мэдэгдлийн цөөн үг л байна. Энэхүү мэдэгдэл нь хууль ёсний мэдэгдэл үү, эсвэл буруу тайлагнасан тохиолдолд ямар үр дагавар үүсэх вэ гэдэг нь огт тодорхойгүй байна. Харин Баталгаажуулалт хийгдсэнээс хойш тодорхой ахиц дэвшил гараад буй бөгөөд 2009 оны 12 дугаар сард Ажлын хэсгээс тусгайлан хэсэг байгуулан одоогын тайлангийн маягтуудыг хянан үзэж шинэчлэхээр ажиллаж байна. Энэхүү үйл ажиллагаа нь одоо үргэлжлэн явагдаж буй бөгөөд 2010 оны 2 дугаар сард дуусах төлөвлөгөөтэй байгаа билээ. Дээр дурдсанчлан Ажлын хэсэг дээр ОУИТБС-ын тусгайлсан хууль гаргахаар яригдаж байгаа бөгөөд энэ хуулиар тайлангаа гаргаагүй эсвэл буруу гаргасан компаниудад торгууль ноогдуулахаар төлөвлөж байна.

Байгууллага/институцийн бүтэц

1 ОУИТБС-ын бүтэц

Монгол улсын ОУИТБС-ын гурван талын оролцоот бүтэц нь Ажлын алба, Ажлын хэсэг болон ҮЗ-өөс бүрдэж байна. Хэдийгээр Ажлын хэсэг нь ОУИТБС-ын бодлогын ихэнхийг боловсруулдаг ч гүйцэтгэх эрх мэдэл нь ҮЗ-д хадгалагдаж байна. Гэхдээ ҮЗ нь байгуулагдсан цагаасаа хойш ердөө 4 удаа л хурал хийжээ. ҮЗ нь гүйцэтгэх гол бүтэц болохын хувьд удаан хугацаагаар хуралдахгүй байгаагаас Монголын ОУИТБС-ын ахиц дэвшилд ихээхэн ноцтой сул зогсолтыг үүсгээд байгааг иргэний нийгмийнхэн цохон тэмдэглэж байна. Тулгараад буй энэхүү асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.

Харин энэхүү Баталгаажуулалт явагдсаны дараа зарим ахиц гарч 2009 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр ҮЗ хурлаа хийсэн ба дараагын хуралдааныг 2010 оны эхээр хийн 2009 оны 12 дугаар сард Ажлын хэсэг дээр хэлэлцэн шинээр баталсан Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэхээр тохироод байна.

2 Хариуцлага тооцох

Одоогын бүтцийн хүрээнд ОУИТБС-ын зарим бүрэлдэхүүн хэсгийг гүйцэтгэх үүрэг хариуцлага төрийн байгууллагуудын алинд нь ноогдож байгаа нь тодорхойгүй байна. Одоогоор ҮТЕГ нь ЗГ-ын тайлангуудыг нэгтгэн гаргах үүргийг хүлээгээд байна. Гэхдээ эдгээр байгууллагуудад зөвхөн ОУИТБС-ын ажлыг хариуцсан байнгын

ажилтан байхгүй, мөн гаргаж буй тайлан нь нямбай, цаг тухайдаа гарч буйг баталгаажуулах хэмжээний чадавх мөн бүрдээгүй байна. ҮТЕГ-ын ажилтнууд ч мөн өөрсдөө харьяанд нь ажиллаж байгаа дээд түвшний яамнаас мэдээлэл гаргаж өгөхийг шахаж шаардаж байх нь протоколын хэмжээний асуудал, хүндрэлийг үүсгэдэг талаар дурдаж байсан.

Аудитаар илэрсэн зөрүүг нягтлан шалгах, тодруулах үүрэг хариуцлагыг аль тал хүлээх талаар мөн тодорхойгүй байна. Хэдийгээр ҮЗ-өөс ҮАГ-т 2006 оны аудитаар илэрсэн зөрүүний учрыг олох хүсэлт гарган шилжүүлсэн ч тухайн байгууллага нь зөрүүг нягтлан шалгаагүй нь хариуцлага хүлээх байдал тодорхойгүйтэй холбоотой.

Баталгаажуулагч нарын зүгээс энэхүү үүрэг хариуцлагыг зөвхөн төрийн нэг байгууллагад хариуцуулах нь ихээхэн чухал бөгөөд ингэснээр тухайн зөрүүнүүдийг цаашид нягтлан шалгах боломжийг бий болгохыг тэмдэгдэж байна.

Харин энэ талаар одоогын байдлаар тодорхой ахиц гараад буй ба ОУИТБС-ын Ажлын албанаас мэдээлсэнээр СЯ одоогоор 2007 оны аудитын нэгтгэлээр илэрсэн зөрүүний шалтгааныг тодруулахаар ажиллаж буй ба удахгүй болох ҮЗ-ийн хуралдаанаар энэхүү асуудлыг цэгцлэх төлөвлөгөөг хэлэлцэхээр бэлтгэж байна.

3 Байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Нилээд олон тооны хүмүүстэй ярилцлага хийх үеэр төрийн байгууллагуудын зүгээс ОУИТБС-ын хүрээнд төрийн байгууллага, агентлагууд анх удаагаа хоорондоо үр дүнтэйгээр хамтран ажиллах боломжийг нээн өгсөн хэмээн талархаж байсан билээ.

Энэхүү хамтын ажиллагаа нь одоо үргэлжилж буй үйл явц ч гэсэн даван туулах шаардлагатай томоохон хүндрэл байсаар байна. Баталгаажуулагч нарын зүгээс хариуцсан байгууллагуудын үйл ажиллагаанд үйл явцын/гүйцэтгэлийн аудит хийх байдлаар эдгээр байгууллагуудын дотоодын болон хоорондын хамтын ажиллагаанд байгаа дутагдалтай талуудыг илрүүлэн засах боломжтой хэмээн үзэж байна.

Энэхүү тайланг бэлтгэж байх үед Баталгаажуулагч нарт СЯ хандив, тусламж дээр гарч буй зөрүүнүүдийг мөн нийт зөрүүг тодруулахдаа хамтатган шалгахаар болсон талаар Ажлын албанаас мэдээлсэн. Энэ нь мөн ОУИТБС-ийн хуулийн асуудлаарх үйл ажиллагаанд мөн тусгалаа олох болно.

4 Төв болон орон нутгийн хамтын ажиллагаа болон зөрүүнүүд

Аудитын нэгтгэлээр илэрсэн голлох томоохон зөрүүнүүдийг компаниудын зүгээс орон нутгийн төрийн байгууллагуудад төлсөн мөнгөн урсгал эзэлж байсан билээ.

Компаниудын зүгээс хандив, бэлэг, мөнгөн бус туслалцаа, тусгай сангуудад төлсөн төлбөр хэмээн тайлагнаж байгаа ч харин орон нутгийн засаг захиргаа үүнийг хүлээн авсан талаараа огт тайлагнаагүй байгаа юм. Энэ нь Монгол улсын олборлох салбарын авлигад автсан байж болох боломж өндөртэй хэсэг байж болох юм. Орон нутгийн төрийн байгууллага, засаг захиргаа нь орон нутгийн хэмжээний зөвшөөрөл лиценз олгодог, мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг баталгаажуулдаг зэргийг харгалзан үзвэл эдгээр төлбөрүүдийг ил болгох нь энэхүү салбарыг эрүүлжүүлэхэд ихээхэн түлхэц болох билээ. Баталгаажуулагч нарын зүгээс ОУИТБС нь дээр дурдагдсан зөрүүнүүдийг нягтлан шалгаж, улмаар үүнийг бууруулах, тулгараад байгаа асуудлыг шийдэх стратегийг боловсруулах шаардлагатай хэмээн санал болгож байна. Харин ОУИТБС-ын Ажлын албанаас Баталгаажуулагч нарт мэдээлсэнээс үзвэл СЯ хандив, тусламж дээр гарч буй зөрүүнүүдийг мөн нийт зөрүүг тодруулахдаа хамтатган шалгахаар болсон талаар мэдээлсэн. Үүнээс гарах үр дүн ОУИТБС-ийн хуулийг боловсруулах асуудлаарх үйл ажиллагаанд мөн тусгалаа олох болно.

Бусад чиглэлээр гарсан ахиц дэвшил

Шинээр боловсруулаад буй Үйл ажиллагааны төлөвлөгөөн дээр 2009 оны аудитын нэгтгэлийн тайланг хийлгэхэд зориулан улсын төсвөөс хөрөнгө гаргуулах асуудлыг тусгасан ба эхнийх олон улсын болон дотоодын аудитын компанийн консорциум, дараагынх нь дотоодын аудитын компани, байгууллагын гүйцэтгэх үйл ажиллагаанд зориулагдахаар төлөвлөгдөж байна. Үүний хажуугаар Ажлын албаны үйл ажиллагааны тодорхой хэсгийг буюу харилцаа холбоо болон хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд зориулан хөрөнгө гаргуулахаар төлөвлөж байна. Эдгээр үйл ажиллагаанд ойролцоогоор 247 сая төгрөг буюу ойролцоогоор 170 000 ам долларыг гаргуулахаар төлөвлөөд байна.

Дүгнэлт

ОУИТБС нь байнгын үргэлжлэн явагдаж буйн хажуугаар сайн дурын үйл явц бөгөөд үүнийг хэрэгжүүлэх тогтсон арга зам гэж байхгүйн улмаас ЗГ нь санаачилгын хэрэгжилтэд цаашид тохиолдож болох саад тотгоруудын талаарх бүрэн хэмжээний ойлголтгүй байх нь тодорхой юм. Баталгаажуулагчдын зүгээс дээр дурдагдсан энэ бүлэг болон дэлгэрэнгүй тайланд дурдагдсан боломжит саад тотгоруудыг ОУИТБС-ын оролцогч талууд нарийвчлан судлаж тухайн саад тотгоруудыг арилгах стратеги боловсруулах шаардлагатай хэмээн санал болгож байна. Авч хэрэгжүүлэх арга хэмжээний тоонд хууль зүйн болон зохицуулалтын орчинд өөрчлөлт хийх, эсвэл ОУИТБС-ын байгууллагын бүтцэд өөрчлөлт хийх зэрэг үйл ажиллагаа багтаж болно. Дээр дурдсан энэхүү санал зөвлөмжүүдийг гаргаж байгаа ч Баталгаажуулагчдын үзэж байгаагаар ЗГ-ын зүгээс ОУИТБС-ыг үүсгэн байгуулах тал дээр ихээхэн хичээл зүтгэл гаргаж, амжилтад хүрсэн хэмээх үндэслэлээр энэхүү шалгуур үзүүлэлт биелэгдсэн хэмээн дүгнэж байна.

9. ОУИТБС-ЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТУУДЫГ ОРОЛЦОГЧ ТАЛУУД ХЭЛЭЛЦЭН ТОХИРСОНЫ ҮНДСЭН ДЭЭР БОЛОВСРУУЛСАН ГАРГАСАН УУ?

Үйл явц, үр дүн

ОУИТБС-ын хүрээнд ашиглаж буй маягтуудыг анхлан 2006 оны 12 дугаар сард ҮЗ болон Ажлын хэсэг дээр хянан үзэж, зөвшөөрсөн байна. 2006 оны нэгтгэлийн тайлан гарсаны дараагаар 2008 оны 3 дугаар сарын 19 нд маягтуудыг шинэчлэх шийдвэр гарч шинэ маягтуудыг Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн баталсан байна. Одоогоор Монголын ОУИТБС-ын хүрээнд нийт 4 маягтыг ашиглаж байгаа бөгөөд эдгээр маягтуудыг 2006 оны анхдугаар аудитын дүгнэлтийн дагуу засан сайжруулсан байна. Үүнд:

- Маягт 1: Компаниудын тайлагнах маягт. Энэхүү маягтад борлуулсан барааны тоо хэмжээ, болон төрийн байгууллагуудад төлсөн татвар төлбөрийг багтаасан байна.
- Маягт 2: Төв болон орон нутгийн төрийн байгууллагуудын тайлагнах маягт ба үүнд компаниудаас хүлээн авсан татвар, төлбөрийг тайлагнахаар багтаасан байна.
- Маягт 3: УТЕГ-аас эрхлэн компаниас төрийн бүх байгууллагуудад төлсөн татвар, төлбөр, хураамжийг нэгтгэн тайлагнах маягт.
- Маягт 4: ЭБЭХЯ-наас эрхлэн ашигт малтмалын үйлдвэрлэсэн болон борлуулсан тоо хэмжээ, үнийн дүнг тайлагнах маягт.

Гэхдээ ҮЗ болон Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс үзвэл материаллаг гэдэгт ямар төрлийн төлбөрүүд багтах энэ нь ямар зүйлийг агуулах, материаллаг ямар

төлбөрийг маягтуудад багтаах, алийг нь нэгтгэлийн үйл явцад хамруулах талаар гүнзгийрүүлсэн, тусгайлан хэлэлцүүлэг болж байгаагүй байна.

2006 оны аудитын тайлангын зохиогчид 2006 онд ОУИТБС-ийн хүрээнд тайлагнасан НӨАТ-ын талаар нилээд ноцтой асуудлыг гарган ирсэн ба үүнд дурдахдаа “компаниуд болон татварын албадын хоорондын харилцаанд огт уялдаа холбоо байхгүй” хэмээн дүгнэжээ. Үүнээс үүдэн ОУИТБС-аас энэхүү татварыг болон нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар зэргийг маягтуудаас хасахаар шийдсэн байна. Энэхүү шийдвэрийг Ажлын хэсэг зөвшөөрч (Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, 2009 оны 6 сарын 5) баталжээ. Үүнээс хойш Ажлын хэсгээс тусгайлан бүлэг томилон ажилуулж нэгтгэлийн тайланд гарсан санал зөвлөмжүүд болон Ажлын хэсгийн гишүүдийн саналд үндэслэн маягтуудыг дахин хянан шинэчлэх ажлыг хийж байна. Энэхүү үйл ажиллагаа 2010 оны 2 дугаар сард дуусна.

Оролцогч талуудын үнэлгээ

Иргэний нийгмийн үзэж байгаагаар тухайн маягтуудыг илүүтэйгээ өргөжүүлэх шаардлагатай ба үүн дээр нэмж хийсэн гэрээ, нийгмийн даатгалын шимтгэл, НӨАТ болон гаалийн үйлчилгээний болон хадгалалтын хөлс зэргийг оруулах саналтай байна. ЗГ-ын зүгээс одоогын тайлангын маягтуудыг зөвшөөрч байгаа.

Компаниудын хувьд одоогын тайлангуудын маягтад сэтгэл хангалуун байгаа хэдий ч маягтуудыг хэрхэн бөглөх талаар илүү тодорхой мэдээлэл өгч байхыг санал болгож байна. Өнгөрсөн хугацаанд ямар төрлийн татварыг хэрхэн тайлагнах нь тодорхойгүй байснаас зарим тохиолдолд ихээхэн хэмжээний зөрүү үүсэхэд хүргэж байсан тохиолдол байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Зарим нэгэн төрлийн татвар, төлбөрийг тайлангын маягтаас хасах болон эргэн авч үзэх зэрэг үйл ажиллагааг Ажлын хэсэг дээр хэлэлцэн шийджээ. Гэхдээ Баталгаажуулагч нарын зүгээс НӨАТ болон нийгмийн даатгалын шимтгэл нь ЗГ-т төлж буй төлбөр мөн тул бусад татвар, төлбөрийн адилаар хяналтад байх ёстой хэмээн үзэж байна. Тиймээс тэдгээрийг эргүүлэн маягтуудад оруулах асуудлыг бодож үзэх хэрэгтэй хэмээн зөвлөж байна.

Үүн дээр нэмээд Ажлын хэсэг дээр материаллаг болон материаллаг бус хэмээх төлбөрүүдэд ямар төлбөр багтах талаар нарийвчлан тогтоох хэрэгтэй байна. 2007 оны аудитын тайлан дээр дурдагдсан цаашид хандив туслажтай холбоотой мэдээллийг нийтэд мэдээлэх, энэхүү мэдээлэхдээ мөнгөн болон мөнгөн бус хандивыг бүгдийг багтааж байх, хэрхэн тайлагнах талаар сургалт явуулж байх болон ЗГ өөрийн харьяа байгууллагууд нь холбогдох бүх мэдээллийг аудиторуудад гарган агч буйг баталгаажуулах зэрэг зөвлөмжүүдийг Ажлын хэсэг мөн хэрэгжүүлж эхлэх шаардлагатай байна. Түүнчлэн Маягт 1-ийн дагуу компаниудын зүгээс тайлагнаж буй мөнгөн дүн нь тухайн компанийн аудитлагдсан санхүүгийн тайлангаар давхар баталгаажиг байх, үүн дээр ямар нэгэн зөрүү гаргавал хуулийн дагуу шийтгэл ноогдуулж байх зэрэг арга хэмжээг ОУИТБС авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ирээдүйдээ маягтуудын цар хүрээг илүү өргөтгөж гүйцэтгэлийн аудит хийх, борлуулалтын үнийн аудит хийх болон бүтээгдэхүүнийг мөнгөн дүнгээр аудитлах зэргээр өргөжүүлж болох юм.

Гэхдээ одоогын маягтууд нь нарийвчлал сайтай, эдгээрийг ашиглан тодорхой тооны асуудал, зөрүүнүүдийг илрүүлсэн амжилт гараад байгаа. Үүн дээр нэмээд ОУИТБС одоо маягтуудыг мөн эргэн харж 2007 оны нэгтгэл тайлан дээр дурдагдсан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Материаллаг төлбөр буюу төлбөрийн материаллаг байдлыг бүрэн тодруулах асуудал нь зөвхөн энэ хэсэг дээр ч бус мөн шалгуур үзүүлэлт 14, 15 дээр гарах асуудлуудтай ч

адил хамаарах хэдий ч бидний зүгээс энэхүү шалгуур үзүүлэлт биелсэн хэмээн санал болгохуйц хэмжээний хангалттай ахиц дэвшил гараад байна хэмээн дүгнэж байна.

10. ТАЙЛАНГУУДЫГ НЭГТГЭН ОУИТБС- ЫН ТАЙЛАН ГАРГАСАН АУДИТЫН БАЙГУУЛЛАГЫН ДҮГНЭЛТИЙГ ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ЮУ?

Үйл явц, үр дүн

Одоогоор аудитын хоёр өөр компани аудитын нэгтгэлүүдийг гүйцэтгээд байна. 2006 оны санхүүгийн жилд Австралийн Крейн Вайт АссоушиэТС компани аудитын ажиллагааг гүйцэтгэсэн бол 2007 оны аудитыг Монголын болон олон улсын хамтарсан Эрнст Яанг компани хийжээ.

2008 оны санхүүгийн жилийн нэгтгэлийн аудитын хувьд Ажлын хэсэг дээр тендер сонгон шалгаруулах протоколыг хэлэлцэн шийдээд байна. Ажлын хэсгээс тендерийн баримт бичгийг боловсруулах үүргийг Ажлын албанд 2009 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр ноогдуулж, тухайн өдөр болсон Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэн сэдвийн дагуу баримт бичиг боловсруулахыг үүрэг болгосон байна. Мөн Ажлын хэсэг нь тендерийн баримт бичгийг Дэлхийн Банкинд хүргүүлэн батлуулж, сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг явуулах үүргийг хүлээсэн байна. Үүний дараагаар 2009 оны 10 дугаар сарын 20-нд болсон Ажлын хэсгийн хуралдаанаар ЗГ, компани болон иргэний нийгмийн төлөөллийг багтаасан Үнэлгээний хороог байгуулжээ.

Оролцогч талуудын үнэлгээ

Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс харвал анхдугаар аудитын тайлангын талаар бүх оролцогч талуудын зүгээс ихээхэн ноцтой шүүмжлэлүүд өрнөсөн байна. Иргэний нийгмийн санал болгосноор дараагын аудитын үйл ажиллагааг сайжруулахын тулд илүү зохистой үйл ажиллагааг явуулан өмнөх аудитаас сурсан сургамж дээрээ үндэслэн дараа дараагын тайланг сайжруулах саналтай байжээ. Анхдугаар аудитын нэгтгэл ЗГ-ын зүгээс татвар, төлбөр, хураамж, хандив зэрэг дээр тусдаа тайлан гарган өгөх боломжгүй байсан ба ялангуяа лицензийн төлбөр, газрын төлбөр, ус ашигласны төлбөр, гадаадын ажилтнуудын ажлын байрны төлбөр болон сонгогдсон 25 компаниас хүлээн авсан хандивын талаар мэдээлэл гаргаж өгөх боломжгүй байжээ.

Ажлын хэсгийн бусад гишүүдийн адилаар ТАН эвсэлийн төлөөлөл санхүүгийн тайлан гаргасан бүх компанийг 25 компаниас гадна хамруулах санал гаргасан байна.

Бүх оролцогч талууд Баталгаажуулагч нарт анхдугаар тайлан бол суралцах үйл явц байсан хэмээн хэлцгээж байлаа. Үүнтэй зэрэгцээд 2006 болон 2007 оны тайлангуудыг харьцуулахад сүүлийн тайлан дээр ихээхэн дэвшил гарсанд сэтгэл хангалуун байгаа болохоо илэрхийлж байв. Гэсэн ч иргэний нийгмийн зүгээс 2006 оны тайлангаар илэрсэн зөрүүнүүдийг (25 тэрбум төгрөг) шалган тодруулах явдал орхигдсоор байгаа талаар дурдсан.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

2006 оны болон 2007 оны тайлангуудыг харьцуулахад ихээхэн ахиц дэвшил гарсан нь тодорхой харагдаж буйн хажуугаар анхны аудиторуудын санал болгосон маягтуудыг өөрчлөх санал нь хэрэгжин сайжирсан зэрэгээс үүдэн дараагын аудитын үйл ажиллагаа, тайлан ихээхэн сайжирсан байна. Шалгуур үзүүлэлт биелсэн.

11. ЗАСГИЙН ГАЗРААС БҮХ КОМПАНИУДАД ОУИТБС- ЫН ТАЙЛАНГИЙН МАЯГТААР ИЛ ТОД ТАЙЛАГНАХ ТЭГШ НӨХИЦЛИЙГ ХАНГАЖ ӨГСӨН ҮҮ?

Үйл явц, үр дүн

Одоогоор Монгол улсад татварын албанд бүртгэлтэй 360 компани үйл ажиллагаа явуулж байгаагын ихэнх нь жижиг хэмжээний компаниуд байна. Аудитын үйл

ажиллагаанд учрах хүндрэлийг багасгах үүднээс хичнээн компани тайлагнах ёстой, тэднийг хэрхэн хамруулах талаар Ажлын хэсэг дээр ярилцсан байна. Үүнтэй холбогдуулан Ажлын хэсгийн дарга 2009 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хурал дээр “Олон туулай хөөсөн анчин хоосон хоцордог гэдгийг санаж бид өмнөх алдаагаа давтахгүй байх ёстой байна. Юу хийх ёстой байна тэрийгээ л хийх хэрэгтэй. Үйл ажиллагаанд маш бага хэмжээний төсөв байдагын хажуугаар бидэнд төлбөр хийх ёстой зүйлс маш их байна” гэж хэлж байжээ.

Энэхүү хуралын дараагаар Дэлхийн банктэй зөвлөлдсөний үндсэн дээр Ажлын хэсгийн хурлаар аудитын нэгтгэлд оруулах компаниудын төлсөн татварын хэмжээ нь 200 сая төгрөгнөөс дээш компаниудын тайланд аудит хийх босго тавигдсан байна. Энэхүү богыг 2006 оноос эхлүүлэн хэрэгжүүлэхээр тогтжээ. 2007 ионьд нийт 200 саяаас илүү хэмжээний төлбөр төлсөн компаниудаас 7 компани тайлангаа гаргаагүй байна.

2006 оны шинэчлэн найруулсан Ашигт малтмалын хуулийн 48.10 дугаар заалт дээр “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн татварт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ” хэмээн заасан байна.

Гэхлээ Ажлын албанаас энэхүү Ашигт малтмалын хуулийн заалтыг компаниудаас мэдээлэл авах хөшүүрэг болгон ашигладаггүй ба гарган өгч буй тайлангууд нь ОУИТБС-ын шаардлагад нийцэхээргүй байдаг байна. Харин компанид нь сайн дурын үндсэн дээр л тайлангаа гарган өгч байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Ажлын хэсгийн зүгээс төлбөрийн материаллаг байдлын талаар хэлэлцсэн хэмээн баталаажуулсан ба аудитын нэгтгэлд хамруулах компаниудад 200 000 төгрөгийн босго тогтоох асуудлыг Ажлын хэсгийн гишүүд болон Дэлхийн банктэй зөвлөлөн гаргажээ. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс харахад тайлан гаргах шаардлагыг нь хангуулах зохицуулалт байхгүй й байгаа бөгөөд (компанийн маягт болон зөрүүг шийдвэрлэх тал дээр) энэхүү асуудлыг иргэний нийгмийн төлөөлөл, ЗГ-ийн төлөөлөл болон компаниудын төлөөлөл хэд хэдэн удаа сөхөн гаргаж байсан байна. Компаниудыг тайлангаа гаргахыг баталгаажуулах талаар гарсан асуултад Ажлын алба энэ талаар компаниудад шахалт үзүүлэх хангалттай хуулийн заалт байхгүй хэмээх хариуг өгч буй байна. Энэ талаар Ажлын хэсэг дээр илүү тодорхой ярилцаж үүнээс гарах арга замыг олох ёстой байсан. Ажлын хэсгийн гишүүд нэмэлт хууль тогтоомж гаргах асуудлаар ярилцаж, санал гаргасан ба гэхдээ энэ асуудлаар Ажлын хэсгийн хуралдаанаар шийдэл, зөвшилцөлд хүрээгүй байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Шинэчлэн найруулсан Ашигт малтмалын хууль нь Монгол улсад ОУИТБС-ын аудитыг явуулах хууль зүйн орчин байгаа болохыг харуулах тодорхой нотолгоо юм. Гэсэн хэдий ч ОУИТБС-ыг хуулиар заах нь чухал шаардлагатай ч гэсэн олборлох үйлдвэрлэл эрхлэж буй бүх компаниудыг тайланг гаргуулах хангалттай хөшүүрэг болохгүй юм. Үүнээс үүдээд 7 компани 2007 онд тайлангаа гаргаагүй бөгөөд аудиторудын зүгээс ч гэсэн 2006 болон 2007 онд гарсан их хэмжээний зөрүүнүүдийн учрыг олох тал дээр ихээхэн хүндрэлтэй тулгарч байжээ. Ажлын хэсгийн хуралдаанаар оролцогч талууд энэ асуудлыг сөхөн ярьж бүх компаниуд заавал тайлагнаж байх хуулийн зохицуулалт хэрэгтэй талаар хэлэлцсэн байна.

Баталгаажуулагч нар Монгол улсад үйл ажиллагаагаа явуулсаны дараа буюу 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр болсон Ажлын хэсгийн хуралдаанаар тайлангаа буруу гаргасан болон гаргаагүй компаниуд болон удирдах ажилтнуудад хариуцлага тооцох талаар хуулийг өөрчлөх талаар ярилцсан байна. Үүнийг хуралдааны тэмдэглэлийн 6 дугаар зүйл дээрээс харж болно.

Гэсэн хэдий ч Баталгаажуулагч нар ЗГ-ын зүгээс бүх оролцогч талуудын нийтлэг зөвшөөрсөн үйл ажиллагааг явуулан компаниуд нь тайлангаа гаргах үйл явцыг бүрэн баталгаажуулж байгаа талаарх шалгуур үзүүлэлтэд нийцэхүйц хангалттай нотолгоо олж чадаагүй болно.

Тиймээс Баталгаажуулагч нарын зүгээс энэхүү нөхцөл биелэгдээгүй хэмээн дүгнэж байна.

12. КОМПАНИУДЫН ТАЙЛАН ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУДЫН ДАГУУ АУДИТЛАГДСАН ТОО БҮРТГЭЛД ТУЛГУУРЛАСАН БАЙХ НӨХЦЛИЙГ ЗАСГИЙН ГАЗРААС ХАНГАЖ ӨГСӨН ҮҮ?

Шалгуур үзүүлэлт тодорхой, ойлгомжтой эсэх

Шалгуур үзүүлэлт 12 дээр байгаа зарим ойлголтыг (Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний аргачлалын дагуу) энэхүү Баталгаажуулалтын хүрээнд тайлангаа гаргаж байгаа компаниуд нь аудитын олон улсын стандартын дагуу тухайн компаниуд дээр хийгдсэн аудит дээр үндэслэгдсэн мэдээлэл дээр тулгуурласан байх шаардлагатай хэмээн ойлгож, авч үзлээ.

Үйл явц, үр дүн

Нягтлан бодох бүртгэлийн хууль, Компанийн хууль болон Аудитын хуулинд зааснаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж бүр өөрийн санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж байх ёстой ажээ. Хуулинд зааснаар нийт хөрөнгийн хэмжээ нь 50 сая төгрөгөөс дээш компаниуд өөрийн санхүүгийн тайланг заавал аудитаар баталгаажуулах ёстой бол 50 саяас доош хэмжээний хөрөнгө бүхий компани нь сайн дурын үндсэн дээр аудитаар баталгаажуулж болох ажээ. Түүнчлэн ОУИТБС-ын Маягт 1 буюу компанийн тайлангын маягтын доод хэсэгт “Дор дурдсанаас бусад тохиолдолд тайлангийн заавар ёсоор тайлангийн маягтыг үнэн зөв гаргаснаа бид хариуцахаа мэдэгдэж байна” гэсэн мэдэгдэл мөн “Тайлангын маягт нь аж ахуйн нэгжийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлантай тохирсон байна” гэсэн мэдэгдлүүд байна.

2008 онд ОУИТБС нь өөрийн санаачилгаар аудитын үйл ажиллагааг явуулсан бөгөөд үүнийг Монгол МНБ-ын институтын захирлаар ахлуулсан баг хийж гүйцэтгэсэн байна. Үүний шалтгаан нь Ажлын хэсгийн хэд хэдэн гишүүн олон улсын компаниудаас илүүтэйгээр дотоодын аудиторудыг сонгох хэрэгтэй хэмээх санал гаргасантай холбоотой байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Зарим оролцогч талууд одоогоор ОУИТБС-ын маягтуудын дагуу тайлагнаж байгаа мэдээллийн чанарт шүүмжлэлтэй хандаж байгаа ба үүний хажуугаар аудитын үйл ажиллагааны чанарт ч мөн шүүмжлэлтэй хандаж байсан. Энэхүү асуудлыг 2007 оны аудитаас илүүтэйгээр өмнөх анхдугаар аудитын тайланг хэлэлцэх үед гаргаж байсан байна. 2008 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар анхдугаар аудитын нэгтгэлийг гүйцэтгэх үүрэг бүхий компанийн төлөөлөл “Анхан шатны санхүүгийн баримт бичгүүдийг шалгахын хувьд компаниуд үүнийг гарган өгөх эсэх эргэлзээтэй байна” хэмээн хэлж байжээ. Анхдугаар аудитын чанарын талаарх шүүмжлэл мөн 2008 оны 5 дугаар арын 30-ны өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар мөн яригдсан байна. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлүүд дээр аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх талаар тодорхой ярилцсан ямар нэгэн тэмдэглэл байхгүй байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх компани өөрийн санхүүгийн тайландаа олон улсын стандартын дагуу аудит хийлгэж байх ёстой бөгөөд

ОУИТБС-ын тайлангын маягт дээр тайланд дурдагдсан мэдээлэл нь аудитаар батлагдсан тайлан дээр суурилсан байх ёстойг заажээ. Хэрэг дээрээ Олон улсын санхүүгийн тайлангын стандартууд нь Монголд анх удаа 2003 онд орчуулагдсан ба үүнээс хойш хийгдсэн өөрчлөлтүүд нь огт орчуулагдан хэрэгжээгүй байна. Бүгд биш ч гэсэн ихэнх томоохон уул уурхайн компаниуд олон улсын стандартад нийцсэн аудитын компаниар санхүүгийн тайландаа аудит хийлгэж байна. Хэдийгээр хууль тогтоомж дээр дээр дурдагдсан олон улсын стандартыг даган мөрдөх талаар заалтууд байгаа хэдий ч үүний хэрэгжилт нь бүрэн хэмжээгээр хэрэгжиж чадаагүй байна⁷. Үүнтэй холбоотойгоор СЯ-наас “Татвар төлөгч компаниуд нь санхүүгийн тайлангаа Монгол улсын хууль тогтоомж болон олон улсын стандартын дагуу гаргахгүй байгааг харуулж байна” хэмээжээ. ОУИТБС-ын Ажлын төлөвлөгөөг гаргах үед Ажлын хэсгийн гишүүд Дэлхийн банктай хамтран компаниудын санхүүгийн тайлан гаргах үйл явцыг олон улсын стандартад нийцүүлэх талаар ярьсан хэдий ч энэ нь ОУИТБС-ын хүрээнээс хальсан хэрэг хэмээн үзсэн байна.

Баталгаажуулагч нар Ажлын хэсэг дээр компаниудын тайлангын мэдээллийн чанарын асуудлаар ярилцан, ямар нэгэн арга хэмжээ авсан талаарх ямар нэгэн нотолгоог олж чадаагүй. Цаашид ОУИТБС хамтын ажиллагааны болон хууль зүйн аргуудыг ашиглан компаниудын тайлан нь олон улсын стандартын дагуу гаргасан санхүүгийн тайлан дээр үндэслэхийг баталгаажуулах байх хэмээн найдаж байна. Эдгээр шалтгааны улмаас Баталгаажуулагч нар тухайн шалгуур үзүүлэлтийг биелээгүй хэмээн дүгнэж байна.

13. ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАНГУУД ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУДЫН ДАГУУ АУДИТЛАГДСАН ТОО БҮРТГЭЛД ТУЛГУУРЛАСАН БАЙХ НӨХЦЛИЙГ ЗАСГИЙН ГАЗАР ХАНГАЖ ӨГСӨН ҮҮ?

Шалгуур үзүүлэлт тодорхой, ойлгомжтой эсэх

Баталгаажуулагч нар “Засгийн газрын тайлан” хэмээх ойлголтонд ЗГ-ын харьяа агентлагуудын бэлтгэн аудитын нэгтгэлд оруулахаар нэгтгэж буй тайланг хамруулж үзсэн болно.

Үйл явц, үр дүн

ҮАГ-аас төрийн байгууллагууд болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлан олон улсын аудитын стандартад нийцсэн байх тухай зааварчилгааг 2006 онд гаргасан байна. Төрийн байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн стандартыг 2008 онд боловсруулан гаргажээ. Түүнчлэн Монгол улсын ЗГ нь мэргэшсэн нягтлан бодогч зэрэгтэй хүнийг төсвийн байгууллагуудын болон төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн нягтлан бодохын албан тушаалд ажиллуулах бодлого баримталдаг байна. Гиймээс төрийн байгууллагууд, төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан нь үндсэндээ олон улсын аудитын стандартад нийцэж байна хэмээн үзэж болно.

Гэхдээ төрийн болон төрийн өмчит байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг саяханаас нэвтрүүлж эхэлсэн тул цаашид төрийн байгууллагуудын гаргаж буй тайлан нь олон улсын стандартын дагуу аудитаар баталгаажсан байх нөхцлийг сайжруулах зүйлс ихээр байгаа нь ойлгомжтой.

Бүрэн хэмжээгээр шийдэгдээгүй, төрийн байгууллагаас гаргаж буй тайлангын чанарт ихээр нөлөөлдөг зүйл бол төв болон орон нутгийн түвшинд өгч байгаа мөнгөн хандив тусламж билээ. Үндсэндээ орон нутгийн засаг захиргаа хүлээн авсан хандив, тусламаа тайлагнадаггүй нь ЗГ-ын тайланд ихээхэн хэмжээний зөрүү гарах шалтгаан болж байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Бүх оролцогч талууд ЗГ-ын зүгээс гаргаж буй тайлангууд нь олон улсын стандартын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлан дээр суурилж байгаа болон орон нутагт тайлагналт сул байгаа гэдэгтэй санал нийлж байсан.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Аудитын хуулиар төрийн байгууллагуудын санхүүгийн тайлан нь олон улсын стандартын дагуу аудитаар баталгаажсан байх ёстой ба СЯ-ны Төрийн нарийн бмчгийн дарга тухайн тайлангууд нь олон улсын стандартын дагуу аудитлагдсан болохыг шалган баталгаажуулдаг байна.

Гэхдээ ЗГ-ын тайлан нь орон нутагт авч буй хандив, тусламжийг бүрэн тусгаагүй тул олон улсын стандартын дагуу аудитаар баталгаажсан хэмээн тооцох боломжгүй байна. Аймаг болон сумын засаг захиргаа хүлээн авсан бүх хандив тусламжаа тайлагнахгүй байгаа нь үндсэндээ тэдний авсан тусламжийг төв дээр төвлөрүүлэн дахин хуваарилалтад оруулна гэсэн айдасаас үүдэлтэй байна. Ажлын хэсгийн хуралдаанаар энэ асуудлыг хэд хэдэн удаа ярилцсан хэдий ч одоогоор тодорхой зөвшилцөлд хүрээгүй байна.

Аудитын хоёрдахь тайлангын 5.2 дугаар хэсэг дээр ЗГ-ын харьяа байгууллагууд олборлох салбарын дүн мэдээг цуглуулан удирдах тал дээр сайжруулах зүйлс их байгааг тэмдэглэн үүний тоонд ҮТЕГ болон Ашигт малтмалын хэрэг эрхлэх газруудыг цохон дурдсан байна.

ЗГ-ын тайланд тулгарч буй голлох асуудал нь орон нутгийн засаг захиргааны түвшинд (аймаг болон сум) ЗГ-ын маягтыг бүрэн хэмжээгээр бөглөн тайлагнах чадавх ихээхэн доогуур хэмжээнд буй явдал байна. Баталгаажуулагч нар Монгол улсад ажилласнаас хойш буюу 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ҮЗ хуралдсан бөгөөд энэхүү хуралдааны тэмдэглэлийн 1 дүгээр заалт дээр “компаниудаас хандив, тусалцаа авах үйл явцыг бүх шатанд зохицуулан, тэдгээрийг тайлагнаж байх талаар ҮЗ-д танилцуулах” хэмээн тэмдэглэсэн байна.

ҮЗ нь хүлээн авсан хандив, тусламжийн асуудал дээр анхаарлаа хандуулсанаар ЗГ-ын тайлангын чанарыг сайжруулах чиглэлээр тодорхой ажлыг байна. Гэхдээ Баталгаажуулагч нар Ажлын хэсэг дээр энэ талаар ярилцан, ЗГ-ын тайланг сайжруулах талаар зөвшилцөлд хүрч үйл ажиллагаа явуулж бй талаарх хангалттай нотолгоог олсонгүй.

Энэ шалтгааны улмаас энэхүү шалгуур үзүүлэлт биелээгүй гэж үзэж байна.

ИЛ ТОД ТАЙЛАГНАХ ЯВЦ

14. КОМПАНИУДААС ТӨЛЖ БАЙГАА ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙ, УУЛ УУРХАЙН ХОЛБОГДОЛТОЙ БҮХ МАТЕРИАЛЛАГ ТӨЛБӨРҮҮД (ТӨЛБӨРҮҮД) – ИЙГ НЭГТГЭН ДҮГНЭЖ, ТАЙЛАН ГАРГАХ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН АУДИТОРЫН БАЙГУУЛЛАГАД НЭЭЛТТЭЙ БАЙСАН УУ?

Үйл явц, үр дүн

Хоёрдахь удаагын аудитын тайланг (2007 оны санхүүгийн жилийн) анхдугаар тайлантай (2006 оны санхүүгийн жилийн) харьцуулбал компаниудын татвар, хураамж, төлбөрт төлсөн мөнгөн дүнг нилээд өндөр түвшинд олон нийтэд тайлагнасан байна. Гэхдээ шалгуур үзүүлэлт 13-ын хүрээнд Маягт 3 дээр байгаа компаниудын хандивыг тайлагнахгүй байгаа болон дутуу тайлагнаж байгаа нь явдал болж байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Компаниудыг төлөөлөн оролцсон хэд хэдэн төлөөллийн зүгээс орон нутгийн захиргааны зүгээс өөрийн дураар тогтоосон төлбөрийн төрөл, хэмжээний талаар ихээхэн санаа зовниж буйгаа илэрхийлсэн ба эдгээр төлбөрүүд нь хандив хэлбэрээр

болон лиценз авахад шаардагдах төлбөр хэлбэрээр голдуу илэрдэг байна. Энэхүү асуудлыг Ажлын хэсгийн хэд хэдэн хуралдаан дээр авч хэлэлцсэн нь хуралдааны тэмдэглэлүүдээс тодорхой байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Компаниудын зүгээс ЗГ-т төлж байгаа бүх төрлийн материаллаг төлбөрийг одоогоор тодорхойлон, тайлагнахгүй байгаа болох нь илэрхий байна. Үүний тоонд гол нь орон нутагт өгсөн хандив тусламж болон орон нутагт зөвшөөрөл авахад төлдөг төлбөр багтаж байна. Эдгээрийн орон нутгийн засаг захиргаа ихэнхдээ тайлагнахгүй, эсвэл дутуу тайлагнадаг, мөн компаниуд үүнийгээ хандив биш харин зардал хэмээх ангилалд оруулдаг учир сайтар тодрохгүй байна. Одоогоор орлогын материаллаг байдал гэдэгт хандив тусламж орсон хэдий ч энэхүү компанийн зүгээс төлсөн төлбөр болон орон нутагт хүлээн авсан хандив тусламж дээр гарч буй зөрүүг хэрхэн талаар Ажлын хэсэг дээр ярилцан шийдээгүй л байна.

Хамгийн сүүлд болсон ҮЗ-ийн хуралдааны хэлэлцэх асуудлын 2 дугаарт ЗГ-ийн зүгээс энэхүү асуудал буюу орон нутагт төлж буй хандив тусламжийг тайлагнуулах чиглэлээр анхаарал хандуулж эхэлж байгааг харуулж байна. Гэсэн ч Баталгаажуулагч нар орлогын материаллаг байдлын талаар ярилцах, үүнийг тайлагнуулах талаар ямар нэгэн үйл ажиллагаа явуулж буй талаарх хангалттай нотолгоог олоогүй тул одоогийн байдлаар энэхүү шалгуур үзүүлэлт биелээгүй байна.

15. ЗАСГИЙН ГАЗАРТ ХҮЛЭЭН АВСАН ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙ, УУЛ УУРХАЙН БҮХ МАТЕРИАЛЛАГ ОРЛОГУУДЫН (ОРЛОГУУД)- ЫГ НЭГТГЭН ДҮГНЭЖ, ТАЙЛАН ГАРГАХ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН АУДИТОРЫН БАЙГУУЛЛАГАД НЭЭЛТТЭЙ БАЙСАН УУ?

Үйл явц, үр дүн

Одоогын байдлаар Монгол улсын ЗГ уул уурхайн компаниудаас өөрийн хүлээн авсан татвар, төлбөрийг Маягт 2, Маягт 3-ыг ашиглан тайлагнаж байна (Дээрх Шалгуур үзүүлэлт 9 дээрх үйл явц, үр дүн хэсгийг харна уу). Гэвч орон нутгийн засаг захиргаа (Аймаг болон сумын түвшинд) хүлээн авсан хандив, тусламжийн орлогоо тайлагнахгүй, эсвэл дутуу тайлагнах явдал байсаар байна. Энэхүү дурдагдсан асуудлыг Сангийн яамны зүгээс тулгараад буй, цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын тоонд багтаасан байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл болон Баталгаажуулагч нарын хийсэн уулзалтын үр дүнгээс харахад ЗГ-ийн хүлээн авсан бүх орлогыг тайлагнаагүй болох дээр нийтээ хүлээн зөвшөөрч байсан болохыг харуулсан.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Уул уурхайн компаниудын зүгээс орон нутагт өгч байгаа хандив, тусламжийн тал дээр Ажлын хэсэг бүрэн хэмжээгээр тодорхойлолт гаргаагүй ч одоо явагдаж байгаа аудитын үйл ажиллагааны хүрээнд энэ талаар зарим мэдээллийг гаргаж байгаа нь ихээхэн сайшаалтай хэрэг бөгөөд ЗГ-ийн хүлээн авсан бүх орлогийг нээлттэй болгох анхны алхамуудыг хийж эхлээд байна. Аудитын үйл ажиллагаа бүрэн хэмжээгээр хамарч чадахгүй байгааг нээлттэйгээр хүлээн зөвшөөрч буй нь ихээхэн ололттой тал бөгөөд одоогоор Монгол улсын ЗГ-ын хүлээн авсан бүх материаллаг орлогыг ил тод, нээлттэй болгоогүй байна. Бүх материаллаг орлогыг нээлттэй болгон тайлагнуулах чиглэлээрх ҮЗ-ийн шийдвэр нь (хандив, тусламж болон мөнгөн бус төлбөр) энэ талаар үйл ажиллагаа явуулж эхэлж байгааг баталгаа болж байна. Гэхдээ энэхүү шатанд ҮЗ ч, Ажлын хэсэг ч “материаллаг орлого” гэж юу болохыг бүрэн тодорхойлон гаргаагүйн улмаас уул уурхайн компаниудын зүгээс ЗГ-т өгсөн ихээхэн өндөр хэмжээний төлбөр

ОУИТБС-ийн тайланд тусгагдалгүй үлдэж байна. Энэхүү шалтгааны улмаас тухайн шалгуур үзүүлэлт биелээгүй хэмээн үзэж байна.

16. КОМПАНИ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАНГУУДЫГ НЭГТГЭН ДҮГНЭХ ГЭРЭЭ БАЙГУУЛСАН АУДИТОРЫН БАЙГУУЛЛАГА ҮҮРГЭЭ ХАНГАЛТТАЙ БИЕЛҮҮЛСЭН ГЭДГИЙГ АЖЛЫН ХЭСЭГ, ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ЮУ?

Үйл явц, үр дүн

2006 болон 2007 онуудад ОУИТБС-ын нийт 2 удаагын тайлан гарчээ. Ажлын хэсгийн хурлын тэмдэглэлээс харахад эхний тайлангийн үр дүнд ихээхэн сэтгэл дундуур байж, шүүмжлэлтэй хандаж байсан нь харагдаж байна. Ялангуяа оролцогч талуудын төлөөлөл аудиторуд компанийн тайланг эх баримттай нь болон компанийн аудитлагдсан тайлантай тулган шалгаагүй явдалд ихээхэн шүүмжлэлтэй хандсан байна. Гэсэн хэдий ч 2006 оны аудитын дүгнэлтээр гарсан хэд хэдэн санал зөвлөмжүүдийг 2007 оны тайланг гаргасан аудиторуд үйл ажиллагаандаа хэрэгжүүлжээ. 2007 оны аудитын нэгтгэлийн тайланг ҮЗ 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа баталсан байна.

2006 оны аудитын тайлангаас авсан туршлага, сургамжийн хүрээнд ОУИТБС нь одоо Монголын болон олон улсын аудитын консорциумыг сонгон шалгаруулах болсоныг оролцогч талууд үндэсний аудиторудын чадавхийг бэхжүүлэх чухал боломж хэмээн үзэж байна.

Монголын ОУИТБС нь 2008 оны тайлангуудад аудитын нэгтгэл хийх сонгон шалгаруулалт зарлаад байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаа 2010 оны 1 дүгээр сард эхлэхээр төлөвлөгдөж байна.

2008 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн ҮЗ-ийн хуралдааны тэмдэглэл дээр “ҮЗ 2006 оны санхүүгийн жилд уул уурхайн 25 компаниас ЗГ-т төлсөн болон ЗГ уул уурхайн компаниудаас хүлээн авсан татвар, төлбөрийн анхдугаар аудитын нэгтгэлийн тайланг зарчмын хувьд зөвшөөрсөн” хэмээн тэмдэглэжээ.

2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр болсон ҮЗ-ийн хуралдааны тэмдэглэл дээр Ернст Яанг компанийн гүйцэтгэсэн 2007 оны аудитын нэгтгэлийн тайланг зөвшөөрөн баталсан талаар дурдсан байна.

Оролцогч талуудын үнэлгээ

ҮЗ болон Ажлын хэсэг дээр 2006 оны аудитын тайланд ихээхэн шүүмжлэлтэй хандсан байна. Оролцогч талууд 2006 оны тайланд ихээхэн дутагдалтай зүйлс байсан гэдгийг бүрэн хүлээн зөвшөөрсөн бол харин 2007 оны тайлан дээр харьцангуй их ахиц дэвшил гарчээ.

Иргэний нийгмийн төлөөллийн үзэж байгаагаар 2006 оны тайлангаар илэрсэн ихээхэн хэмжээний зөрүү шийдэгдээгүй хэвээр байгаа бөгөөд, хэдийгээр тухайн тайлан нь учир дутагдалтай байсан ч гэсэн холбогдох төрийн байгууллага энэхүү ихээхэн хэмжээний зөрүүний учир шалтгааныг тодруулан тогтоох ёстой хэмээн үзэж байна.

Монгол улсын ЗГ-ын зүгээс СЯ-наас тайланд гарсан зөрүүнүүдийг нягтлан шалгаж дүгнэлт гаргасны үндсэн дээр аудитын анхдугаар тайланг ҮЗ баталгаажуулсан байна. ЗГ-аас мөн 2007 оны тайлангаар илрэн гарсан зөрүүнүүдийг ҮЗ дээр анхааралтай авч үзэх бөгөөд тухайн зөрүүнүүдийг тодруулах үйл ажиллагааг эхлүүлнэ хэмээн мэдэгдээд байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Ажлын хэсэг дээр хэлэлцсэнээр 2006 оны аудитын тайланд нилээд тооны асуудал байсан ба хамгийн гол асуудал нь аудиторуд тоон үзүүлэлтүүдийг эх баримт болон аудитлагдсан санхүүгийн баримттай тулган шалгаагүй явдал байсан ажээ. Гэхдээ 2007

оны аудитын үр дүнд тодорхой ахиц дэвшил гарсан ба сонгогдсон аудитын компани болох Эрнст Яангын мэдэгдсэнээр боломжтой бүх тохиолдолд зарим тоон үзүүлэлтүүдийг эх баримттай нь тулган шалгаасан байна. Гэсэн ч зарим тохиолдолд аудиторуд баримтуудыг гарган өгөхийг шаардах хууль ёсний эрх дутмагаас болоод саад тотгортой тулгарч байжээ.

2006 онтой харьцуулбал 2007 оны аудитын нэгтгэлийн тайлан хавьгүй сайжирсан бөгөөд цаашид өгөх санал зөвлөмжүүдийг биелүүлсэнээр 2008 оны тайлан илүү сайжирна хэмээн итгэж байна. Тиймээс энэхүү шалгуур үзүүлэлт биелсэн хэмээн бидний зүгээс үзэж байна.

17. ОУИТБС-ЫН ТАЙЛАНД ЗӨРҮҮТЭЙ БАЙДЛЫГ ОЛЖ ТОДОРХОЙЛОН, АВБАЛ ЗОХИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР САНАЛ ЗӨВЛӨМЖ ГАРГАСАН УУ?

Үйл явц, үр дүн

2006 болон 2007 онуудад гарсан аудитын нэгтгэл тайлангууд нь компаниудын төлсөн татвар, хураамж болон ЗГ-ын зүгээс хүлээн авсан татвар, хураамжийн хэмжээнд ихээхэн зөрүү гарч байгааг илрүүлсэн байна. 2006 онд гэхэд нийт 17.2 сая ам долларын зөрүү гарсан нь одоог болтол учир шалтгаан нь бүрэн тодроогүй байна. 2007 оны санхүүгын жилийн аудитын нэгтгэлийн хувьд 9 дүгээр сарын 4-ний өдрийн Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцсэн зөрүүний хэмжээ 17.4 сая ам доллар байсан байна. Эдгээр зөрүүнүүд нь ихэнхдээ уул уурхайн компаниудын зүгээс татвар төлбөрт төлсөн хэмээн тайлагнасан дүн нь төрийн байгууллагуудын хүлээн авсан хэмээн тайлагнаснаас хавьгүй илүү байснаас үүджээ.

Аудиторуудын зүгээс тухайн зөрүүнүүдийг төрийн байгууллагууд болон компаниудтай хамтран ажиллах замаар тодруулан шалгажээ. Зарим тохиолдолд тодруулга хийхдээ аудиторуд санхүүгийн анхдагч баримтууд болон мөнгө төлсөн, хүлээн авсан баримт зэргийг биечлэн шалгах, төрийн байгууллагуудын мэдээллийн санг нягтлан шалгах зэргээр ажилласан байна. Зарим тохиолдолд энэ нь боломжгүй байсан бөгөөд Эрнст Яанг аудитын компанийн зүгээс компани болон ЗГ-ын байгууллагууд нарийвчилсан мэдээлэл гарган өгөх боломж үгүй тул зарим зөрүүг нягтлан тодруулах боломжгүй болсон талаар мэдэгдэж байжээ. Дээр дурдагдсан шалган, тодруулах үйл явцын үр дүнд 2007 оны аудитын нэгтгэл дээр гарсан зөрүүнүүд ихээхэн хэмжээгээр буурсан байна.

2006 оны аудитаар илэрсэн зөрүүнүүд одоог хүртэл бүрэн шийдэгдээгүй бөгөөд үүнийг шалган нягтлах хүсэлт хүлээн авсан ҮАГ шалгахаас татгалзан буцаасан байна.

2009 оны 11 дүгээр сард гаргасан 2007 оны аудитын тайлангаар илэрсэн зөрүүг одоогоор СЯ шалгаж буй ба энэ талаарх цаашид авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны стратегийг 2010 оны 1 дүгээр улиралд багтаан Ажлын хэсэгт танилцуулахаар болсон байна.

Өмнө гарсан хоёр тайланд санал зөвлөмж гаргахдаа үйл явц болон арга зүйн тал дээр ихээхэн онцлон гаргаж байжээ. Баталгаажуулагч нартай уулзах үеэрээ аудиторудын зүгээс хэлэхдээ аудитын үйл ажиллагаа явуулах хууль зүйн эрх нь дутагдалтай байснаас болж тэдний гаргасан хүсэлтүүдийг компаниуд үл хайхрахад хүргэж байсан талаар хэлж байжээ.

Дээрх тайлангууд дээр гарсан санал зөвлөмжүүдийг доор хураангуйлан харууллаа.

Үүнд:

2006 оны тайлан

- Цаг хугацаа:

- Цаашид хийгдэх ажлын үр дүнг сайжруулахын тулд аудитын нэгтгэл хийх цагийг нийтийн амралтын өдрүүд болон санхүүгийн жилийн эцэстэй давхцуулахгүй байх шаардлагатай байна. *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- тендерийн үйл явц илүү үр дүнтэй явагдах болсон).*
- Цаашдын аудитын үйл ажиллагааг хоёр шатанд хуваан хэрэгжүүлэх талаар анхаарах. Эхний шатанд маягтуудыг харьцуулан шалгах, зөрүүнүүдийг олж илрүүлэх, ЗГ болон компаниудад хандан энэ талаар тодруулга хүссэн захидал явуулах. *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн ҮЗ-ийн хуралдаан дээр төрийн байгууллагуудын тайланг хэрхэн цаг хугацаанд нь гаргуулж байх талаар хэлэлцсэн).*
- Төрийн байгууллагуудын мэдээллийн бүрдэл дутуу байх:
 - Уул уурхайн компаниудаас хүлээн авсан төлбөрийн талаарх хүсэлтийг хамаарах бүх төрийн байгууллагад илгээхэд хариу мэдээлэл өгөх тогтолцоог бий болгох (шаардлагатай бол 0 гэсэн хариутай ч байж болно). *(Баталгаажуулагчдын зүгээс: Ажлын хэсэг хэлэлцэж байгаа).*
 - Орон нутгийн болон бусад төрийн байгууллагуудын хүлээн авсан хандив, тусламжийн талаар ЗГ-ын тайланд тусгах бол ЗГ-ийн зүгээс тухайн хандив, тусламжийг хэнд өгсөн талаар тодорхойлох энгийн үр дүнтэй тогтолцоог бий болгох. *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- одоо хандив тусламжийг Маягт 1 болон 2 дээр тайлагнах ёстой хэмээн заасан ба гэхдээ одоогоор нарийвчилсан байдлаар тайлагнахыг шаардаагүй байна. Энэхүү асуудал дээр одоо СЯ ажиллаж байна).*
 - Мөнгөн бус хэлбэрээр өгсөн хандив тусламжийг нэгтгэн аудит хийх нь ихээхэн асуудлыг үүсгэж байна. Хандив, тусламжийг өгч байгаа уул уурхайн компани нь үүнийг өөрсдийн зардалд тайлагнах, эсвэл үзүүлсэн үйлчилгээний зардал хэмээн тайлагнаж байна. *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- одоо маягтууд дээр "мөнгөн хандив, тусламж" хэмээх шинэ зүйл орсон ба энэ асуудлыг мөн одоо СЯ хэлэлцэж байна).*
- Маягтуудын загвар:
 - Маягтуудыг дахин боловсруулан үүнд компаниудаас болон ЗГ-ийн байгууллагуудаас авч байгаа мэдээллүүдийг нэг хэлбэр, загварт оруулах шаардлагатай. Тайлангаар гаргуулан авч байгаа бусад мэдээллийг тусдаа хэсэг дээр төвлөрүүлэн авч болно. *(Баталгаажуулагчдын зүгээс: Гүйцэтгэгдсэн. Маягтуудыг дахин боловсруулж, стандартчилсан. Одоо хянан үзэх шатанд яваа).*
- Маягтуудын дагуух тайлангын үнэн зөв байдал:
 - Маягтуудын дагуу бүрэн хэмжээний, үнэн зөв мэдээлэл гарган өгөх нь ихээхэн чухал бөгөөд энэхүү асуудлыг ЗГ болон компаниудад сайтар ойлгуулах шаардлагатай. *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- ОУИТБС-аас компаниудад зориулан сургалт явуулсан).*
- Маягтуудыг бөглөх талаарх зааварчилгаа:
 - Маягтуудыг хэрхэн бөглөх талаарх зааварчилгааг дахин хянан үзэж, шаардлагатай мэдээллийг хэрхэн тайлагнах талаар дэлгэрэнгүй болгох. Тайлагнах ёстой ихэнх зардал, төлбөр дээр ихээхэн тодорхой зааварчилгаа шаардагдаж байгаа ба жишээ нь НӨАТ, гаалийн татвар,

суутгал гэх мэт). *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- Маягтууд дээр зааварчилгааг оруулсан боловч энэхүү асуудал 2007 оны аудитын тайлан дээр дахин гарч ирсэн).*

- НӨАТ:
 - НӨАТ-ыг төлсөн болон хүлээн авсанийг аудитын нэгтгэлд оруулахад ихээхэн хүндрэл учирч байна. Энэхүү татварыг 2006 оны аудитын нэгтгэлд хамруулсан нь томоохон хэмжээний зөрүүг үүсгэх шалтгаан болсон ба үүнийг тайлангын маягтаас хасах нь тухайн татварт суутган тооцсон бусад татварыг тогтооход ч бас хүндрэл учруулж байна. *(Баталгаажуулагчдын зүгээс: НӨАТ-ыг аудитын нэгтгэлээс хассан. Хэдийгээр үүнийг аудитын нэгтгэлд оруулахад ихээхэн хүндрэл үүсдэг ч гэсэн маягтуудад дахин оруулах талаар ОУИТБС-д санал болгож байна).*
- Гаалийн татвар:
 - Маягтуудын зааварчилгаан дээр компанийн зүгээс ч, ЗГ-ын зүгээс ч энэхүү татвартай холбоотой мэдээллийг тайлагнахдаа юуг анхаарах талаар нарийвчилсан зааварчилгааг оруулах шаардлагатай байна. Ялангуяа гааль дээр импортоор гаргасан бүтээгдэхүүнд ноогдуулан авсан НӨАТ татварыг маш тодорхой тусгах хэрэгтэй. Монголын ОУИТБС-ын зүгээс мөн гаалийн хураамж болон бүрдүүлэлтийн төлбөр зэргийг тайланд тусгах эсэхийг хэлэлцэн шийдэх хэрэгтэй. *(Баталгаажуулагчдын зүгээс: Гаалийн татварыг маягтууд дээрээс хассан. Дээр дурдагдсан хүндрэлүүдийг үл харгалзан бидний зүгээс энэхүү төлбөрийн маягт дээр эргүүлэн оруулахыг зөвлөж байна).*
- Цаг хугацаа- “Цаг хугацаа дуусгавар болох”:
 - Энэхүү асуудал нь зөвхөн цөөхөн нөхцөлд тохиолдож болох бөгөөд үүнийг тулд төрийн байгууллагууд санхүүгийн жил дууссан, эсвэл тухайн нэгэн төлбөрийн ноогдох хугацаа дууссаны дараа хүлээн авсан өмнөх оны/хугацааны татвар, төлбөрт хамаарах төлбөрүүдийг хянан үзэж тайлагнаж байх замаар даван туулж болно. *(Баталгаажуулагчдын зүгээс: 2007 оны аудитын тайланг энэхүү асуудлыг харгалзан үзэж гүйцэтгэсэн).*
- Төрийн байгууллагууд болон орон нутагт өгсөн хандив, тусламж:
 - Өөрийн эрх мэдлийг хэтрүүлэн ашиглах боломж их байгаагаас үүдэн хандив тусламж нь ихээхэн асуудлыг үүсгэж байна. Төрийн байгууллагуудын мэдээллийн бүрдэл дутуу байх хэмээх хэсэг дээр байгаа зөвлөмжүүд нь энэ талаар зарим мэдээллийг өгөх бөгөөд энэхүү асуудлыг даван туулахын тулд тодорхой арга хэмжээг авах хэрэгтэй гэж үзэж байна. *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- Хэдийгээр хандив тусламж нь ЗГ-ын тайлан дээр ихээхэн асуудалтай хэвээр байгаа ч гэсэн энэ асуудлыг одоо СЯ судлаж байна).*

2007 оны тайлан

- Цаг хугацаа:
 - Цаашид хийгдэх ажлын үр дүнг сайжруулахын тулд аудитын нэгтгэл хийх цагийг нийтийн амралтын өдрүүдтэй давхцуулахгүй байх шаардлагатайн хажуугаар ЗГ болон компаниудын зүгээс мэдээлэл гарган өгөхөд зориулан хангалттай цаг хугацааг гаргах хэрэгтэй байна. *(Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- 2008 оны аудитыг гүйцэтгэх тендерийг 2009 оны 12 сард зарлан 2010 оны 1 дүгээр улирлаас гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулахаар болсон).*

- Төрийн байгууллагуудын мэдээллийн бүрдэл дутуу байх (*Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- ҮЗ-ийн 2009 оны 11 дүгээр сард болсон хурлаар энэхүү асуудлыг цэгцлэх төлөвлөгөөг боловсруулахаар болсон. Төлөвлөгөөний төсөлд ОУИТБС-ын тусгай хууль гаргахаар заах бөгөөд энэхүү асуудлыг одоогоор боловсруулж байгаа ба 2010 оны 1 дүгээр улиралд багтаан хийхээр заасан*):
 - Төрийн байгууллагууд ЗГ-ын 80 дугаар тогтоолын талаар мэдэхгүй.
 - СЯ-наас хамаарах байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулан ОУИТБС-д үнэн зөв, бүрэн хэмжээний мэдээлэл гаргаж өгч байхыг баталгаажуулах.
 - Ихэнх тохиолдолд нэгтгэлийн тайлан нь бүрэн бус байхын хажуугаар төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг байгааг харуулж байна. Аудиторын зүгээс энэхүү мэдээллийг цуглуулах болон гарсан үр дүн дээр нь тулгуурлан үйл ажиллагаа явуулахыг санал болгосон.
 - Тэмдэгтийн хураамж болон газрын төлбөр зэрэг төлбөрүүд дээр тодорхой хэмжээний сургалт хийж төрийн байгууллагуудын зүгээс зөв тайлагнах боломжийг бий болгох.
 - Төрийн байгууллагуудад өгч байгаа хандив, тусламжийн талаарх тодорхой мэдээллийг маягт дээр тусгайлан зааж өгөх, ингэснээр илүү үр дүнтэй нэгтгэл хийх боломж олгох.
 - Компаниудын зүгээс ЗГ-т өгч байгаа бүх татвар, төлбөрийг бүрэн хэмжээгээр үнэн зөвөөр гаргуулан авах талаар СЯ-наас цаашид судлан үзэж энэхүү салбар дахь бүх төлбөрийг бүрэн хамруулж буй талаар баталгаажуулах.
- Маягтуудын загвар болон тэдгээртэй хамаарах зааварчилгаа (*Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- Маягтуудыг одоогоор Ажлын хэсэг хянан үзэж байна*).
 - Хандив, тусламжийн хэсэг дээрээс “мөнгөн” гэсэн үгийг хасах ингэснээрээ мөнгөн болон мөнгөн бус хандив, тусламжуудыг тайланд тусгуулж байх.
 - Тайлангын маягт дээрх зүйл болгон дээр хэрхэн бөглөх талаарх тодорхой зааврыг оруулж өгөх.
 - Сургалт зохион явуулсанаар маягтууд дээр байгаа төлбөр болгоныг бүрэн хэмжээгээр тайлагнуулж байх.
 - Хэрэгтэй үед шуурхай туслалцаа үзүүлж байх тогтолцоог бий болгон эхлүүлэх.
- Маягтуудыг бэлтгэх нарийвчлал (*Баталгаажуулагчдын зүгээс: Зарим талаар ахиц гарсан- Маягтуудыг одоогоор Ажлын алба хянан үзэж байгаа*).
 - Тайлангын хүрээнд гаргасан бүх мэдээлэл нь үнэн зөв болохыг баталгаажуулах зорилгоор мэдээллээ илгээхээс өмнө хянуулж байх, ингэснээр цаг хугацаа болон аудитын нэгтгэлийн чанарт эерэг нөлөө үзүүлнэ.
 - Тайлангын үйл явцад гарсан тодорхой бус зүйлсийн хувьд нэгтгэлд оруулахаас өмнө нэн даруй ЗГ-т хандан засуулж, тодруулж байх.
 - ҮАГ ЗГ-ийн зүгээс гаргаж байгаа мэдээллийг хянан үзэж саналаа тусгаж байх.
 - Компанийн аудиторууд тусдаа баталгаа гаргах, үүн дээр ОУИТБС-д гарган өгч байгаа мэдээлэл нь тухайн компанийн аудитлагдсан

санхүүгийн тайлангын дагуу тайлагнагдсан болохыг баталгаажуулж гарын үсэг зурж байх.

- Тайлан дээр дурдагдсан үнийн дүнг батлах баримт бичгүүд
(Баталгаажуулагчдын зүгээс: *Зарим талаар ахиц гарсан- ОУИТБС-ын хуулийн төслийг боловсруулах талаар шийдвэр гарсан ба үүнийг Ажлын хэсэг судлаж байна*).
 - Гаалийн татвар, гаалийн үйлчилгээний төлбөр, байгаль орчныг нөхөн сэргээхэд зарцуулах мөнгөн хөрөнгө зэрэг төлбөрийн талаарх мэдээлэл ихэнхдээ аудиторуудад хаалттай байсан ба зарим тохиолдолд эдгээрийг нэгтгэсэн дүнгээр нь төлсөн байлаа. Энэ тал дээр компаниудын талаар тодорхой мэдээлэх хэрэгтэй байна.
 - Зарим тохиолдолд мэдээлэл олдохгүй, байхгүй байна. Компаниуд бүртгэлээ сайжруулах болон ОУИТБС-д бүрэн хэмжээний тайлан явуулж байх шаардлагатай байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Иргэний нийгмийн зүгээс 2006 оны аудитын нэгтгэлээр илэрсэн 17.2 сая ам долларын зөрүү нь одоо ч гэсэн бүрэн тодроогүй байгаа бөгөөд үүнийг цаашид үргэлжлүүлэн шалгахыг хүсэж байна. 2007 оны аудитын нэгтгэлийн тайлангын хувьд иргэний нийгмийн зүгээс хэд хэдэн асуудлыг гарган тавьж байна. Үүнд:

- Тодроогүй үлдсэн голлох зөрүү нь Алтан Дорнод Монгол болон Монполимет компаниудын зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварт төлсөн хэмээн тайлагнасан мөнгөн дүн дээр гарч буй бөгөөд тухайн мөнгөн дүнг хүлээн авсан болохоо ҮТЕГ тайлагнаагүй байна.
- Үйлчилгээний хөлс болон тэмдэгтийн хураамж, төрийн байгууллагуудад өгсөн хандив тусламж болон байгаль орчний нөхөн сэргээлтэд зарцуулах зардал зэрэг хэсгүүд дээр томоохон хэмжээний тодроогүй зөрүү үлдсэн ба орон нутгийн төрийн байгууллагууд болон төрийн бусад агентлагуудаас гарган өгөх мэдээлэл хангалтгүй байгаагаас хамаараад эдгээрийг тодруулах боломжгүй болоод байна.
- 2009 оны 10 дугаар сарын 12-ны өдөр болсон Ажлын хэсгийн хурлаар авч хэлэлцсэн тодролгүй үлдсэн нийт зөрүүний хэмжээ 3,842,574,000 төгрөг буюу 2.6 сая ам доллар байсан нь тухайн хурлаас нэгхэн сарын өмнө Эрнст Яанг компанийн мэдэгдэж байснаас хавьгүй ихээр буурсан дүн байжээ. Гэхдээ аудитын компанийн зүгээс үүнд тодорхой тайлбарыг өгсөн бөгөөд Алтан Дорнод Монгол болон ТунШин компаниуд дээр гарсан зөрүүнүүдийг оруулах тохиолдолд энэхүү нийт зөрүүний хэмжээ 14,635,507,000 төгрөг болтол өсөх боломжтой юм.

Төрийн байгууллагын зарим төлөөллийн үзэж байгаагаар зөрүүнүүдийг шалган шийдвэрлэсэн арга зам нь зохистой бус бөгөөд учир нь өөр өөр төрлийн татварууд дээр өөр өөр аж ахуйн нэгжийн төлсөн дүн дээр үүссэн зөрүүнүүдийг харьцуулан шалгах нь буруу хэмээн үзэж байсан болно.

Компаниудын зүгээс 2006 оныхтой харьцуулбал 2007 оны тайланд гарсан ахиц дэвшилд талархалтай хандаж буйгаа илэрхийлж байсан. Гэхдээ тэдний зүгээс хэдийгээр төлсөн боловч төрийн байгууллагуудын зүгээс хүлээн аваагүй хэмээн гарч ирсэн төлбөрүүдийг нарийвчлан шалгах, ялангуяа дээр дурдагдсан орон нутгийн төрийн байгууллагуудад төлсөн төлбөрийн талаар нарийвчлан шалгах шаардлага байгаа болохыг илэрхийлж байсан.

Эцэст нь хэлэхэд оролцогч бүх талуудын үзэж байгаагаар ОУИТБС-ын гол зорилгын нэг нь энэхүү зөрүүнүүдийг тэг түвшинд хүргэх явдал болоод байгаад санаа зовниж буйгаа илэрхийлсэн. Харин үүний оронд оролцогч талуудын санал болгож буйгаар

тухайн зөрүүнүүдийг огт байхгүй болгохоос илүүтэйгээр үйл явцад тулгарч буй асуудлууд эсвэл авлигатай холбоотой асуудлуудыг тодруулан тогтоох аргачлал байдлаар ашиглавал зүйтэй гэсэн санал гаргаж байсан болно.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Монгол улсад хэрэгжиж буй ОУИТБС нь байнгын тасралтгүй үргэлжилж буй үйл явц болоод байгаа бөгөөд үүнийг 2006 оны болон 2007 оны тайлангуудын хооронд гарсан ихээхэн ахиц дэвшлээр нотлон тайлбарлаж болно. Үйл явцтай холбоотой хэд хэдэн асуудал аудиторын гаргасан тайлан болон Баталгаажуулагч нарын ярилцлагад туссан ба тэдгээр асуудлуудад холбогдох талууд Ажлын хэсэг, ҮЗ анхаарлаа хандуулах ёстой. Түүнчлэн иргэний нийгмийн зүгээс 2006 оны шийдэгдээгүй үлдсэн ихээхэн хэмжээний зөрүүнүүдийн талаар асуудлыг дэвшүүлсэн ба үүний гол агуулга нь зөрүү илэрсэн тохиолдолд хэн үүнийг цааш нь лавшруулан шалгах ёстой асуудал дээр оршин буй болно. Учир нь аудиторуудын зүгээс үйл явцтай холбоотой асуудлаар санал зөвлөмж гаргах тал дээр ихээхэн анхаарч байгааг хажуугаар зөрүүнүүдийг хэрхэн тодруулах талаар ямар нэгэн зааварчилгаа өгөх боломжгүй байгаад оршино. Тиймээс үүнтэй холбоотой хариуцлага нь Ажлын хэсэг болон ҮЗ-д ноогдож, хэрхэн цаашид зөрүүнүүдийг тодруулж байх тал дээр тодорхой шийдвэр гаргах шаардлагатай байна. Хэдийгээр ОУИТБС-ын зүгээс 2006 болон 2007 оны аудитаар тогтоогдсон зөрүүнүүдийг шалгах талаар тодорхой ажил цаашид явуулах шаардлагатай байгаа ч одоогоор ОУИТБС-ын хүрээнд зөрүүг тогтоох, үүнийг шийдэх арга замыг хайх, хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний ахиц дэвшил, амжилт гараад байгаа учраас Баталгаажуулагчдын зүгээс энэхүү шалгуур үзүүлэлт биелэгдсэн хэмээн дүгнэж байна.

ГАЗРЫН ТОС, БАЙГАЛИЙН ХИЙ, УУЛ УУРХАЙН КОМПАНИУД ОУИТБС-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТАЛААР ХЭРХЭН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛСЭН БЭ?

Үйл явц, үр дүн

Компаниудын гаргасан өөрийн үнэлгээний хүснэгтийг Хавсралт В дээрээс үзнэ үү. Олон тооны компаниуд ОУИТБС-ын үйл ажиллагаанд дангаараа болон эвлэлдэн нэгдсэн эсвэл холбоодоор дамжуулан идэвхтэй оролцож байна. Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээс харахад компаниуд нь Ажлын хэсгийг ОУИТБС-ын бодлогыг Монгол улсад хэрэгжүүлэх, дэмжих суваг байдлаар идэвхтэй ашиглаж байна.

Оролцогч талуудын үнэлгээ

Олон тооны иргэний нийгмийн төлөөлөл компаниудын зүгээс ОУИТБС-ын үйл ажиллагаанд оролцох оролцоо хангалттай өргөн хүрээнд бус байгаа хэмээн үзэж байсан ч энэхүү үйл явц сайжирч буй тодорхой шинж тэмдэгүүд ажиглагдаж байгаа ба үүний тоонд ОУИТБС-ын тайланг маягтын дагуу тайлангаа гарган өгч буй компаниудын тоо нэмэгдэж байгаа явдал мөн багтана.

Түүнчлэн иргэний нийгмийн төлөөлөл цаашид аудитын нэгтгэлд илүү олон тооны компаниудыг хамруулах ёстой хэмээн санал гаргаж байлаа. Одоогоор зөвхөн нийт төлсөн татвар, төлбөрийн хэмжээ нь 200 сая төгрөгний босгыг давахуйц хэмжээний компанийн тайланг аудитын нэгтгэлд оруулж байгаа билээ. Үүний хүрээнд 2006 онд 25 компани, 2007 онд 38 компани хамрагдсан байна. Гэхдээ дээр дурдсан босго хэмжээг тогтоох нь ихээхэн зөв бөгөөд учир нь 2008 онд тайлангаа гаргасан 113 компанийг аудитын нэгтгэлд хамруулах тохиолдолд үүний зардлыг ихээхэн өндөрсгөх билээ. Үүн дээр нэмээд хэлэхэд тухайн аудитын нэгтгэлд хамрагдаж байгаа компаниудын нийтдээ төлсөн мөнгөн дүн нь ихээхэн өндөр бөгөөд 2007 оны улсын төсвийн 40% орчмыг эзэлж байна.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

ОУИТБС-ын зүгээс аудитын нэгтгэлд зарим жижиг болон дунд хэмжээний компаниудаас хамруулах талаар авч үзэх шаардлагатай бөгөөд үүгээр дамжуулан тухайн компаниудын түвшинд хэдий хэмжээний зөрүү гарч болох талаарх мэдээллийг цуглуулан тогтоож болно. Гэсэн нь энэхүү шалгуур үзүүлэлт дээр Баталгаажуулагчдын зүгээс тухайн шалгуур нөхцөл бүрэн биелэгдсэн хэмээн үзэж байна.

ТАЙЛАНГ ИЛ ТОД МЭДЭЭЛЭХ, ТҮГЭЭХ ҮЙЛ ЯВЦ

18. ЗАСГИЙН ГАЗРААС ОУИТБС-ЫН ШАЛГУУРЫН ДАГУУ ТАЙЛАНГИЙН ДҮНГ ОЛОН НИЙТИЙН ХҮРТЭЭЛ БОЛГОСОН УУ? ТАЙЛАНГИЙН ДҮН ОЛОН НИЙТЭД ОЙЛГОМЖТОЙ, БҮРЭН БҮТНЭЭР, ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛААР ОЧСОН УУ?

Үйл явц, үр дүн

ОУИТБС-ын Ажлын алба нь тухайн санаачилгын талаар Монгол улсын ард иргэд, олон нийтэд мэдээлэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа ба олон тооны баримт бичгүүд үүний дотор 2006 оны аудитын нэгтгэлийн тайлан вебсайт дээр байрлаж олон нийтэд нээлттэй байна. 2007 оны аудитын нэгтгэлийн тайлан бүрэн дуусангуут Ажлын хэсгийн бүх гишүүдэд тараагдсан ба 2009 оны 12 дугаар сарын сүүлээр албан ёсоор олон нийтэд ил тод болсон байна.

Түүнчлэн Ажлын алба болон иргэний нийгмийн бүлгүүд ОУИТБС-ын талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор уулзалтууд, олон нийтийн арга хэмжээ болон компаниудад зориулсан сургалтуудад өргөнөөр оролцсон байна. Жишээ нь Эрдэнэт компани гэхэд компанийн тайланг хэрхэн гаргах талаар сургалт авсан болон ОУИТБС-ын Ажлын алба, Нээлттэй нийгэм форум болон Азийн сан хамтран УУҮА-ийн зохион байгуулсан үзэсгэлэнгийн үеэр ОУИТБС болон Хариуцлагатай уул уурхайн санаачилгын талаар танилцуулга хийсэн зэрэг жишээг дурдаж болно.

Оролцогч талуудын үнэлгээ

Оролцогч талууд үндсэндээ аудитын нэгтгэл тайлантай холбоотой олон нийтийн мэдээлэл, харилцааны асуудлаар сэтгэл хангалуун байсан бөгөөд 2006 болон 2007 оны тайлангуудын хооронд гарсан ахиц дэвшлүүдийг цохон дурдаж байв. Иргэний нийгмийнхэн олон нийтэд зориулсан хураангуй тайланг энгийн хэллэгээр боловсруулан гаргаснаар тайлангын үр дүнг олон нийтэд хүргэж болох юм гэсэн санал гаргасан болно.

Ихэнх оролцогч талууд ерөнхийдөө Ажлын албанаас эрхлэн явуулж буй мэдээллийн урсгалд сэтгэл хангалуун байсаны хажуугаар иргэний нийгмийнхэн мөн тухайн үед явагдаж байгаа үйл ажиллагааны талаар илүү идэвхтэйгээр мэдээлэл түгээх чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагааг явуулж болох байсан хэмээн үзэцгээж байв.

Гэсэн хэдий ч бүх оролцогч талууд ОУИТБС-ын талаарх ерөнхий мэдээлэл, мэдлэг цаашид илүү сайжирах ёстой гэдэгт санал нэгдэцгээсэн. Ялангуяа иргэний нийгмийнхэний үзэж байгаагаар ОУИТБС-ын талаарх мэдлэг орон нутгийн түвшинд ихээхэн доогуур байна. Үүний зэрэгцээ аймаг болон сумын түвшиний засаг захиргааны чадавхи мөн ихээхэн доогуур байгааг хүлээн зөвшөөрч байлаа. Орон нутгийн түвшинд хийгдэж байгаа төлбөр, хураамж нь аудиторын тайлангаар илэрч байгаа хамгийн томоохон хэмжээний зөрүүг үүсгэж байгаа эх үүсвэр тул иргэний нийгмийн төлөөллийн зүгээс ОУИТБС-ыг орон нутгийн түвшинд хүргэх, дэлгэрүүлэх талаар үйл ажиллагаагаа эрчимжүүлэх хэрэгтэйг дурдаж байлаа.

Иргэний нийгмийн төлөөллийн хөндөн ярьсан өөр нэгэн асуудал нь тайлант жилийн эцэс болон аудитын нэгтгэл тайланг олон нийтэд хүргэх хоорондын хугацаа ихээхэн урт байгаа явдал байлаа.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Аудитын нэгтгэл тайлангууд нь Монгол болон Англи хэл дээр бичигдэн, олон нийтэд нээлттэй байгаа бөгөөд 2006 болон 2007 оны тайлангуудыг харьцуулан харахад ихээхэн ахиц дэвшил гарсан байна. Баталгаажуулагч нарын зүгээс тайлангуудыг олон нийтэд бүрэн хэмжээгээр, ойлгомжтой байдлаар нээлттэй болгосон хэмээн дүгнэж буй ба Ажлын хэсгийн зүгээс олон нийтэд мэдээлэл хүргэх асуудлыг ирэх жилийн үйл ажиллагааны чухалчлах асуудал болгон тогтоогоод байна. Шалгуур үзүүлэлт биелсэн.

ОУИТБС-ЫГ ЦААШ НЬ ТОГТВОРТОЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ, СУРГАМЖ, АЛДААНААС СУРАХ, ГАРСАН ЗӨРҮҮГ ШИЙДВЭРЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЯМАР АРГА ХЭМЖЭЭ АВАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Үйл явц, үр дүн

2006 болон 2007 онуудын аудитын нэгтгэсэн тайлангуудыг гаргах үйл явцад ихээхэн ахиц дэвшил гарсанаас үзвэл 2006 оны тайлан дээр дурдагдсан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр ОУИТБС-аас тодорхой ажил хийгдсэнийг харуулж буй бөгөөд үүнтэй холбогдох үйл ажиллагааг Монголын ОУИТБС-ын зүгээс авч хэрэгжүүлсэн байна.

Гэсэн ч 2006 оны аудитын нэгтгэлээр илэрсэн зөрөөнүүд одоог хүртэл шийдэгдээгүй байгаа бөгөөд, ОУИТБС-ын хүрээнд эдгээрийг аль байгууллага цаашид нягтлан шалгах талаар үүрэг хариуцлагын цоорхой байж болохоор байна.

ОУИТБС-ын хүрээнд тогтоогдон, үйл ажиллагаа явуулсан бусад асуудлуудын тоонд:

- Одоогоор ОУИТБС-ын Ажлын албаны санхүүжилт нь Дэлхийн Банкнаас бүрэн хамааралтай байгаа ба үүнээс үүдэн тухайн албаны урт хугацааны тогтвортой байдлын талаар асуулт гарах бөгөөд ОУИТБС-ын зүгээс өөр боломжуудыг эрэлхийлэх шаардлагатай юу хэмээх асуудал зүй ёсоор тавигдаж байна. Бодит байдал дээр санхүүжилтын энэхүү хамааралтай байдал нь 2007 оны тайлангуудад аудитын нэгтгэл хийх компанийг тендерээр сонгон шалгаруулахад саад учруулсан байна. Хэдийгээр Дэлхийн Банкны зүгээс тухайн хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн хэдий ч энэхүү асуудалд ихээхэн нухацтайгаар хандах шаардлага үүсээд байна.
- Дээр дурдсанчлан аудитын нэгтгэлээр илэрсэн зөрүүнүүдийн нэг голлох эх үүсвэр нь компаниудын зүгээс орон нутгийн засаг захиргаанд хандив, тусламжаар өгсөн мөнгөн дүнгүүд байсан билээ. Үүнийг мөн ОУИТБС-ын зүгээс ихээхэн ноцтой асуудал хэмээн үзэж байна. Улмаар ЗГ-ын зүгээс ОУИТБС-ын салбарыг 14 аймагт байгуулах санал гаргасан ба үүний зорилго нь орон нутгийн төрийн байгууллагууд хандив, тусламжаар хүлээн авсан бүх мөнгөн дүнг төв засгийн газарт тайлагнаж байх нөхцлийг бүрдүүлэх явдал байсан билээ. Иргэний нийгмийн зүгээс түүнчлэн орон нутгийн түвшинд тухайн асуудлаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой үйл ажиллагаа, семинарыг ОУИТБС-ын Ажлын албаны дэмжлэгтэйгээр явуулсан байна. Одоогийн байдлаар энэхүү хүчин чармайлт нь зөвхөн эхлэлийн шатанд байна.
- Иргэний нийгмийн төлөөлөл болох оролцогч талууд ҮЗ 18 сарын туршид хуралдаагүй байгаад санаа зовниж буйгаа олон удаа дурдаж байв. Баталгаажуулагчдын зүгээс цаашид ҮЗ жил тутам хэдэн удаа хуралдах тоо, хугацааг тогтоон тухайн хуралдаан болох өдрүүдийг урьдчилан тогтоон, зарлаж байхыг санал болгож байна.
- Эцэст нь хэлэхэд ОУИТБС-ын нэг гол санаа зовних асуудал нь Ажлын хэсгийн гишүүдийн хүрээнд болон олон нийтэд чиглэсэн мэдээлэл, харилцаа холбооны

асуудал болоод байна. ОУИТБС-ын Ажлын албанаас энэхүү асуудлыг 2010 оны чухалчлан үзэх асуудал болгон тодорхойлоод, үйл ажиллагаа явуулж байна.

Оролцогч талуудын үнэлгээ

“ТАН” эвсэлийн гишүүд, үүний тоонд Нээлттэй нийгэм форумын менежер, Олон улсын ОУИТБС-ын Удирдах хорооны гишүүн Н.Дорждарь, Миний Монголын газар шороо хөдөлгөөний дэд тэргүүн Болдбаатар, Ил Тод сангийн тэргүүн Цэрэнжав болон Хил хягааргүй алхам ТББ-ын тэргүүн Баярсайхан нарыг зүгээс дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- Авлигатай тэмцэх газар болон хамаарах төрийн байгууллагын зүгээс дээр дурдагдсан 2006 оны аудитын нэгтгэлээр илэрсэн ихээхэн хэмжээний зөрүүнүүд буюу “хууль бус” байх боломжтой үйл ажиллагааны талаар хариуцлага хүлээлгэж болох хууль тогтоомжийг даган мөрдүүлэх чиглэлээр хариуцан үйл ажиллагаа явуулах.
- Алтан Дорнод Монгол болон Тун Шин компаниуд дээр гарсан зөрүүнүүдийг 2007 оны тайлангаас тусгаарласныг болиулах, учир нь тухайн компаниуд нь засгийн газрын зүгээс хүлээн авсан хэмээн тайлагнасан мөнгөн дүнтэй харьцуулах тоо баримт, тайлан гарган өгөөгүй байгаа билээ.
- Аудиторын гаргаж буй тайлангын загварт өөрчлөлт оруулсанаар олон нийт компани нэг бүрээр болон нэгдсэн байдлаар төлсөн татвар, хураамжийн талаар мэдээллийг үзэж, харьцуулах боломжтой болно.

Тодорхой тооны төрийн байгууллагуудын төлөөллийн зүгээс төрийн байгууллагуудын дүн, мэдээг нэгтгэх болон тайлагнах чадавхид (хүн хүчний болон боломжийн) сэтгэл дундуур байсан юм. Үүнийг мөн аудиторуд ч гэсэн тодруулан гаргаж ирсэн билээ. Төрийн байгууллагын нэгэн төлөөллийн санал болгосноор хамаарах төрийн байгууллага болгоны дүн мэдээ цуглуулах болон тайлагнах үйл ажиллагаанд үйл явцын гүйцэтгэлийн аудит явуулах нь тэдний чадавхийг цаашид бэхжүүлэх үндэс болно хэмээх санал гаргаж байсан билээ.

Хэд хэдэн компанийн зүгээс 2006 оны аудитын нэгтгэлээр илэрсэн томоохон хэмжээний зөрүүний учрыг магадлан шалгах үйл ажиллагаа дутагдалтай байгаад шүүмжлэлтэй хандаж байсан. Түүнчлэн тэдний зүгээс цаашид зөрүүний учрыг олох, тодруулах үйл ажиллагааг илүү нарийвчлан хянаж, улмаар төрийн байгууллагууд дүн мэдээ цуглуулан нэгтгэж буй болон тайлагнаж буй үйл явцыг илүү ил тод болгох хэрэгтэй хэмээн санал болгоцгоож байсан юм.

Баталгаажуулагчдын зүгээс өгөх үнэлгээ

Баталгаажуулагч нарын үзэж байгаагаар ОУИТБС Монгол улсад анхлан үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш ихээхэн хэмжээний ахиц дэвшил гарсан байна. Тайлангын маягтуудыг сайжруулсан, сургамжууд дээрээ үндэслэн үйл ажиллагааг сайжруулсан, зөрүүнүүдийг тогтоон тайлагнасан болон тогттортой байдлыг хангах чиглэлээр амжилтад хүрчээ. Маягтууд, зөрүүнүүдийн тайлан болон нийтэд мэдээлэл түгээх чиглэлээр хөрөнгө оруулалт хийж эхэлсэн зэрэг нь ОУИТБС нь оролцогч талууд болон аудиторудын гаргасан шүүмжлэлд нухацтай хандаж, арга хэмжээ авч ирсэнийг харуулж байна. Энэхүү шалгуур үзүүлэлтийн биелэлт хангагдсан байна.

БҮЛЭГ 5. КОМПАНИУДЫН ТҮВШИН ДЭХ ХЭРЭГЖИЛТ

Олон тооны компаниуд Монгол улс дахь ОУИТБС-ын үйл явцад идэвхтэйгээр оролцон ҮЗ болон Ажлын хэсэгт төлөөллөө оруулан үйл ажиллагаа явуулж байна.

Хавсралт В дээр доор дурдагдсан 5 шалгуур үзүүлэлтүүдийн дагуу Компаниудын өөрийн үнэлгээний хүснэгтийг харуулсан болно. Шалгуур үзүүлэлтэд:

1. Танай компани Монгол улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэхийг дэмжинэ гэдгээ ил тод мэдээлсэн үү?
2. Танай компани Монголын ОУИТБС-ын Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах амлалт өгсөн үү? Үүнд хууль тогтоомж, ЗГ-ын тогтоол, захирамж, санамж бичиг зэрэг эрх зүйн баримт бичгүүд орно. Мөн оролцогч талуудын хуралд оролцож байв уу?
3. Танай компани нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагад тайлангын маягтын дагуу болон тогтоосон хугацаанд материаллаг төлбөрүүдээ ил тод гаргаж өгч байсан уу?
4. Нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагад гаргаж өгсөн танай компанийн тайлангын тоон үзүүлэлтийг олон улсын стандартын дагуу хараат бус аудитаар хянуулсан уу?
5. Нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагын тодруулга, тайлбар хүссэн хүсэлтэд өмнө гаргаад байсан ОУИТБС-ын тайлангын маягтын дагуу хариу тодруулга өгч, ЗГ-ын тайлантай нэгтгэх ажилд дэмжлэг үзүүлсэн үү?

Одоогийн байдлаар Монгол улсад 200 гаруй уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр компаниудаас 60 компани 2006 онд, 102 компани 2007 онд тайлангаа гаргажээ. Гэхдээ энэхүү үнэлгээний зорилгоор Баталгаажуулагчдын зүгээс нийт 38 компанид үнэлгээний хуудас илгээсэн ба эдгээр нь 2007 оны аудитын нэгтгэлд хамрагдсан компаниуд билээ. Үүний хариуд нийт 37 компанийн хариулт үнэлгээг хүлээн авсан болно. Хариу өгөөгүй нэг компани байгаа нь АлтанДорнод компани билээ.

Компаниудын бөглөсөн хүснэгтийг доор хураангуйлан харуулсан ба зарим компани бүх шалгуурт нийцсэн, зарим нь үгүй байна. Хамгийн чухал нь бүх компани материаллаг төлбөрүүдээ ил тод гаргаж өгч байсан талаарх Асуулт 3-т Тийм хэмээх хариулт өгсөн мөн нэгээс бусад компани нь ОУИТБС-ын мэдээлэл хүссэн хүсэлтэд зохих хариуг өгч байсан хэмээн хариулсан ихээхэн чухал юм. Компаниудын хувьд

ОУИТБС-ын тайлан гаргах шаардлагыг сайтар даган мөрдөж байгаагын хажуугаар хоёр ч зүйл дээр ахиц дэвшил гаргах шаардлагатай байгаагын тоонд: компаниуд ОУИТБС-д дэмжлэг үзүүлэх болон үүний хэрэгжилтэд зориулан мэдээллээр ханган үүний ач холбогдлыг сайжруулах зэрэг багтаж байна.

Компанийн нэр	Асуулт					Тайлбар
	1	2	3	4	5	
Адамас майнинг	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	
Багануур	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Болд төмөр Ерөө гол	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Бороо Голд	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Буд Инвест	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Бүүргэнт	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Чинхуа Мак- Нарийн Сухайт	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Дацан трейд	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Элтрана	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Эрдэнэт	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Эрдэс холдинг	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Зөвхөн нэг хуралд оролцсон
Эрдмин	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	
Гацуурт	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Бид жил болгон тайлангаа гаргаж өгдөг, ямар ач холбогдолтойг мэдэхгүй байна. Сургалт семинар байвал сууж мэдмээр байна .
Гурван төхөм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Гоби Коул анд Энержи	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Айвенхоу Майнс Монголиа	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Жамп	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Хэвлэл мэдээллээр дамжуулан мэдэгдэл хийгээгүй, харин вебсайгаараа дамжуулан хийхээр төлөвлөж байгаа.
Хааншижир	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	2007 болон 2008 онуудад хуралд нэг нэг удаа оролцсон
Монголчехметал	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Монголросцветмет	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Монголын алт	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Мондулаан трейд	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Монполимет	Тийм	Тийм	Тийм	Хоосон	Хоосон	
Одод Голд	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	2 дугаар асуултанд- Бид зөвхөн хуралд оролцсон, ямар нэгэн амлалт өгөөгүй

Петрочайна Дачин	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Шарын гол	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Үгүй гэсэн хариултын тайлбар: Ямар байгууллага, хэнд хандаж зөрүүг тодруулахаа мэдэхгүй юм
Шим Технологи	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
ШинШин	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Шижир алт	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Шивээ овоо	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Шонлун	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	
Сонор трейд	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	
Таван толгой	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	
Тефис майнинг	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	
Цайрт минерал	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Бид ерөнхийдөө санаачлагыг дэмжих бодлого барьдаг
Улз гол	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Амлалт гарга гэж хэн ч шаардаагүй

БҮЛЭГ 6. НИЙТЛЭГ ҮНЭЛГЭЭ

Монгол улсад ОУИТБС-ын хэрэгжилт гурван жилийн өмнө эхэлжээ. Энэхүү хугацаанд ихээхэн нилээд амжилтад хүрч энэхүү салбарын ил тод байдлыг байгууллагын бүтцэд оруулан, үйл ажиллагааг жигдрүүлсэн байна. Гол үр дүнгүүдээс дурдвал:

- **Мэдээллийн нээлттэй байдал.** Монгол улсын олборлох салбарын талаарх урд өмнө хаалттай байсан ихээхэн хэмжээний мэдээлэл нээлттэй, илт тод болсон байна. Оролцогч талуудын үзэж байгаагаар ОУИТБС нь энэхүү салбарт үлгэр жишээ болохуйц шилжилтийг хийн цуурхал, хий хоосон яриаг баримт нотолгоо болгон өөрчилж чадсан байна.
- **Хоёрдахь тайлан ихээхэн сайжирсан.** Дөнгөж дуусаад байгаа 2007 оны аудитын нэгтгэлийн тайлан нь 2006 оны анхдугаар тайлантай харьцуулбал эрс сайжирсан байна. Тайлангын маягтуудын талаар илүү их хэмжээний ойлголцотой болсоноор техникийн чанартай зөрүүнүүд гарах нь багассан байна.
- **Олон талын бодит оролцоо.** ҮЗ болон Ажлын хэсгийн түвшинд ЗГ, компаниуд болон иргэний нийгмийн хооронд тэгш төлөөлөлтэй байх хүчин чармайлт бодитоор хэрэгжсэн байна.
- **Сорилтод нээлттэй байх.** ОУИТБС-ын оролцогч талууд урдаа тулгараад байгаа сорилтуудад нээлттэй хандаж байгаа нь тухайн сорилтуудыг даван туулж чадна хэмээх итгэлийг бий болгож байна.
- **Аудитын үйл ажиллагааг өргөжүүлэх.** Хоёрдугаар аудитаар хамрагдах компаниудын тоог нэмэгдүүлж цаашид улам өргөжүүлэх чиглэлтэй байна.
- **Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа.** Хэдийгээр одоо бүрэн төгс болоогүй байгаа хэдий ч Монголын ОУИТБС-ын үр дүнд төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сайжран энэхүү үйл явц нь цаашид үргэлжлэх шинж тэмдэг ихээр ажиглагдаж байна.

Дээр дурдагдсан магтууштай үйл ахиц дэвшлийн зэрэгцээ Монголын ОУИТБС-д доорх шалгуур үзүүлэлтүүдийг биелүүлэхэд хэдэн сорилт тулгараад байна. Үүний тоонд:

Шалгуур үзүүлэлт 11- Засгийн Газраас бүх компаниудад ОУИТБС-ын тайлангийн маягтаар ил тод тайлагнах нөхцлийг хангаж өгсөн үү? Ажлын хэсгээм нийт компаниудад 200 сая төгрөгөөр босго тогтоосон боловч олдоогоорүбх компаниудыг заавал тайлагнахыг шаардах хуулийн механизм байгүй байна. Үүнээс

болоод 2007 онд 7 компани тайлангаа гаргаагүй байна. ҮЗ болон Ажлын хэсгийн гишүүд энэ талаарх илүү чанад зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байна.

Шалгуур үзүүлэлт 12- Компаниудын тайлан олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг Засгийн газраас хангаж өгсөн үү? Компаниудын гаргасан тайлан болон үнэлгээний хуудсаас харахад тайлан грагаж буй компаниуд нь аудитаар батлагаажаагүй тайлантай байдаг бөгөөд үүнийг СЯ ч мөн баталсан билээ. Одоогоор Ажлын хэсэг олон улсын нягтлан бодох, бүртгэлийн стандартын асуудалд анхаарлаа хандуулаагүй байгаа бөгөөд үүнийг ОУИТБС-ын үйл ажиллагаанаас гадуурх зүйл хэмээн үзэж байна.

Шалгуур үзүүлэлт 13- Засгийн газрын тайлангууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг Засгийн газар хангаж өгсөн үү? ҮАГ-аас гаргасан тайлан гаргах зааврыг төрийн байгууллагууд даган мөрдөхгүй байна. Материаллаг төлбөр болон орон нутгийн засаг захиргаанд өгсөн хандив, тусламжийн талаарх бүх мэдээллийг бүрэн гаргаж чадахгүй байна. Энэхүү цоорхойг бөглөхийн тулд илүү их харилцан уялдаа бүхий хандлагаар ажиллан төрийн байгууллагуудын бүх шатанд мэдээлэл цуглуулах, солилцох шаардлагатай байна. Түүнчлэн төрийн байгууллагуудын тайлан гаргах үйл явцыг хянах, үнэн бодит мэдээлэл гарган санаачилгыг даган мөрдөх үйл явцыг баталгаажуулахын тулд ҮАГ зэрэг бие даасан институцийн бүтцийг бий болгох талаар авч үзэх шаардлагатай байна.

Шалгуур үзүүлэлт 14- Компаниудаас төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд (төлбөрүүд) – ийг нэгтгэн дүгнэж, тайлан гаргах гэрээ байгуулсан аудиторын байгууллагад нээлттэй байсан уу? Одоогоор бүх материаллаг төлбөрийг тайлангаар гаргуулахгүй байгаагын хажуугаар орон нутагт өгсөн хандив тусламж тайланд тусахгүй, дутуу тусч байна. ҮЗ-ийн хамгийн сүүлд болсон хуралдаанаар бүх төлбөрийг бүрэн хэмжээгээр нээлттэй болгох талаар хүчин чармайлт явуулах талаар хэлэлцсэн байна.

Шалгуур үзүүлэлт 15- Засгийн газарт хүлээн авсан газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг орлогуудын (орлогууд)- ыг нэгтгэн дүгнэж, тайлан гаргах гэрээ байгуулсан аудиторын байгууллагад нээлттэй байсан уу? Ажлын хэсэг дээр материаллаг төлбөр гэж яг юу болох, юуг багтаах талаар тохиролцон тодорхойлоогүй бөгөөд Монгол улсын ЗГ-ийн зарим байгууллагын зүгээс бүх материаллаг төлбөрийг ОУИТБС-ын тайланд тусгаж чадаагүй болохыг шударгаар хүлээн зөвшөөрсөн. ҮЗ-ийн хамгийн сүүлд болсон хуралдаанаар бүх төлбөрийг бүрэн хэмжээгээр нээлттэй болгох талаар хүчин чармайлт явуулах талаар хэлэлцсэн байна.

Эдгээр шалтгааны улмаас болон ОУИТБС-ын журмын дагуу (Ялангуяа ОУИТБС-ын Бодлогын Тэмдэглэл 3) Монголын ОУИТБС нь одоогоор “шалгуур хангахад ойртсон” гэсэн түвшинд байна. Энэхүү тайлангын дараагийн хэсэг дээр Монголын ОУИТБС-д ахиц гарган бүрэн хэрэгжүүлэгчийн статусд хүрэхэд нь шаардлагатай зарим санал зөвлөмжүүдийг тусгалаа (ОУИТБС-ын Нарийн бачгийн дарга нарын газрын саналын дагуу).

БҮЛЭГ 7. ЦААШДЫН ХЭРЭГЖИЛТЭД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖҮҮД

Баталгаажуулалтын багийн зүгээс Монгол улсад ОУИТБС-ыг бэхжүүлэн хөгжүүлэхэд шаардлагатай хэд хэдэн голлох санал зөвлөмжүүдийг өгч байна. Энэхүү санал зөвлөмжүүдийн хураангуйг доор дурдсан бөгөөд дэлгэрэнгүйг Хавсралт Б дээрээс үзнэ үү.

Баталгаажуулагч нар доорх зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

- **Эрдэс баялагийн салбарын стратеги:** Монгол улс нь ОУИТБС-ын гол зарчмууд, орлогын ил тод байдал болон хариуцлагатай байдал зэргийг харгалзан үзсэн ирээдүйн стратегийг боловсруулан ирэх гурван жилийн эрдэс баялагийн салбарын стратегитай уялдуулах хэрэгтэй байна.
- **Эмчилгээний/засварлах стратеги.** Ажлын хэсэг болон ҮЗ ирэх гурван жилийн хугацааны ОУИТБС-ын чухалчлах үйл ажиллагааг багтаасан ирэх гурван жилд хэрэгжүүлэх эмчилгээний буюу засварлах стратегийг боловсруулан батлах шаардлагатай байна. Одоо ашиглаж буй Үйл ажиллагааны төлөвлөгөө нь хуучирсан байна. Шинэчлэн боловсруулах төлөвлөгөөнд Ажлын хэсгийн зүгээс ОУИТБС-ын тулгараад буй асуудлууд болон үйл ажиллагааг чухалчлах байдлаар эрэмбэлэх, 2006 болон 2007 оны аудитын тайлангуудаас авсан сургамжуудаа цааш цаашдын тайлангууд дээр анхаарах, ОУИТБС-ын хэрэгжилтийг тасралтгүйгээр сайжруулахад анхаарах болон чадавхийг бэхжүүлэх зэрэг асуудлыг багтаах хэрэгтэй. Эцэст нь хэлэхэд энэхүү баримт бичигт Оксфордын их сургуулийн Байгалийн баялагийн эрх хэмээх баримт бичгийг ашиглаж болно.
- **Хариуцлага болон хэрэгжилтийн сорилтууд.** Оролцогч талууд бүгд ЗГ-ын харьяа байгууллагуудын хамтын ажиллагаа сул байгаа, ЗГ-ын 80 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байгаа, зөрүүнүүдийг шалган тогтоох үйл ажиллагаа дутмаг буй талаар дурдаж байна. ОУИТБС доорх асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байгаа ба үүнд: зөрүүнүүдийг тодруулан шалгаж, нягтлах; тодорхой, тухайлан бий болгосон хариуцлагын тогтолцоо дутуу байгаа; бүрэн хэмжээгээр тайлагнах болон даган мөрдөх хуулт зүйн хэрэгжилт тааруу байгаа; болон төрийн байгууллагуудад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чадавх дутмаг байгаа (жишээ нь одоо ОУИТБС-ыг хариуцсан байнгын ажилтан байхгүй) зэрэг болно.
- **Хандив, тусламж болон орон нутгийн орлогийн урсгал.** Орон нутгийн төрийн байгууллага, засаг захиргаанд компаниудын зүгээс үзүүлж буй хандив, тусламж нь 2006 болон 2007 оны тайлангаар ихээхэн томоохон асуудлуудыг үүсгэсэн бөгөөд үүнийг оролцогч талууд ч мөн хүлээн зөвшөөрч байгаа юм.

ОУИТБС нь санаачилгын тайлан гаргах үйл ажиллагаа, ялангуяа төрийн байгууллагуудын тайлагналтыг орон нутгийн түвшинд сайжруулах талаар үйл ажиллагааг стратегидаа тусгах хэрэгтэй. ОУИТБС нь мөн эдгээр хандив, тусламжийн дийлэнхийг өгч байж магадгүй жижиг болон дунд хэмжээний компаниудыг аудитад хамруулах талаар бодож үзэх шаардлагатай байна. Аудитын зардлыг өндөрсгөхгүйн тулд үүнийг илүүтэйгээр зөрүү гараад байгаа нь тогтоогдсон аймгийн түвшинд гүйцэтгэж болно.

- **Аудитын нэгтгэлийн тайланг сайжруулах.** 2007 оны тайлан нь өмнөх жилийнхтэйгээ харьцуулбал илүү сайжирсан байна. Гэхдээ компанийн тайлангын маягтууд нь системтэйгээр аудитаар баталгаажуулаагүй байгаа, материаллаг төлбөр дээр бодит аудит хийгдэхгүй байгаа, мөн төрийн байгууллагууд дээр ч гэсэн аудит хийгдэхгүй байна. Тиймээс ОУИТБС нь аудитын үйл явцад: компаниудын тайланг санхүүгийн баталгаатайгаар авч байх, олон улсын санхүүгийн тайлангын стандартыг даган мөрдөхийг баталгаажуулах, биет бодит аудит хийх, мэдээлэл цуглуулахад гарч буй асуудлыг тогтоохын тулд төрийн байгууллагуудад үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийх зэргийг хэрэгжүүлж болно.
- **ОУИТБС-ын Ажлын албаны чадавх болон эрх мэдэл.** Одоогоор Ажлын албанд хоёр хүн ажиллаж байгаа ч (мөн гэрээт мэдээлэл, харилцааны зөвлөх) ихээхэн ажлыг амжуулж байна. Гэхдээ тэдний хувьд бүтээмж чадавхаа сайжруулах тал дээр боломж хязгаартай байна. Тиймээс ОУИТБС нь доорх зүйлсийг харгалзан үзэх ёстой байна. Үүнд:
 - Ажилтнуудын техникийн чадавхийг сайжруулах, зөрүү бүхий мэдээллийг задлан шинжлэх боломж олгох, стратегийн баримт бичгийг боловсруулах чиглэлээрх чадавх сайжруулах; болон
 - Мэдээлэл харилцаа болон олон нийтэд хүрч ажиллах боломжийг бий болгон мэдээллийг олон нийтэд үр дүнтэйгээр хүртээл болгох, түүнчлэн компаниуд болон төрийн байгууллагуудын ОУИТБС-ын тайлан гаргах чадавхийг сайжруулах.
- **ОУИТБС-ын тогтвортой байдал.** Түүнчлэн ОУИТБС-ын Ажлын албаны тогтвортой байдал нь одоогоор донорын санхүүжилтээс хамааралтай байгаа бөгөөд төрийн ямар нэгэн байгууллагад хамрахгүй байна. Урт хугацаандаа ЗГ Ажлын хэсгийг байгууллагын бүтцэд оруулах талаар болож үзэх хэрэгтэй ба ингэснээр ОУИТБС-ын үйл ажиллагаа, үүргийг ЗГ-ын үйл ажиллагаанд хамруулах (ОУИТБС-ын үүрэг, үйл ажиллагааг тусдаа хуулиар зохицуулах) боломжтой болно.

БҮЛЭГ 8. СУРГАМЖУУД

Монгол улсад хийсэн ОҮИТБС-ын баталгаажуулалт нь бидний хувьд хийсэн гуравдахь удаагын баталгаажуулалт байлаа. Зөвлөхүүдийн зүгээс өмнө нь Азербайжан болон Либери улсад хийсэн баталгаажуулалтын сургамж дээрээ үндэслэн үйл ажиллагаа явуулсан. Цааш цаашдын үйл ажиллагаанд доорх сургамжуудыг харгалзан үзэж болох юм. Үүнд:

- 1 **Өөрийн үнэлгээ.** Баталгаажуулалтаас өмнө ОҮИТБС-ын гүйцэтгэсэн өөрийн үнэлгээ нь ихээхэн үр дүнтэй бэлтгэл байв. Өөрийн үнэлгээ нь үнэлгээний анхан шатны суурь болж Баталгаажуулагч нар өөрсдийн бие даасан үр дүнгээ харьцуулан шалгах боломжийг олгож байв.
- 2 **Цаг хугацаа.** 5 хоногт багтаан нийт 30 гаруй уулзалт, ярилцлага хийх түүнчлэн анхан шатны үр дүнгийн талаар гол оролцогч талуудад танилцуулга хийх нь ихээхэн ачаалалтай, сорилт бүхий ч боломжоороо гүйцэтгэсэн үйл ажиллагаа боллоо.
- 3 **Компанийн маягт.** Одоогоор хэрэглэсэн компанийн өөрийн үнэлгээний хүснэгт нь ОҮИТБС-ын хэрэгжилттэй хамаатай үндсэн асуултуудад зөвхөн тийм, үгүй гэсэн хариулт авч байгаа (Тайлбар гэсэн хэсэг дээр нэмэлт мэдээлэл өгч болно). Компанийн энэхүү хүснэгтийг шинэчлэн боловсруулж компаниудаас илүү тодорхой хариулт авах нь цаашид ихээхэн ашигтай байж болно.

ХАВСРАЛТ А. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ХҮСНЭГТ

Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулагчдын тайлбар	Баталгаажуулагчдын үнэлгээ
ЭЛСЭН ОРОХ		
1. Засгийн газар Олборлох Үйлдвэрлэлийн Ил тод байдлын санаачлагыг (цаашид ОҮИТБС гэнэ) хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой байгаа тухайгаа олон нийтэд хандаж ойлгомжтой мэдэгдэл хийсэн үү?		Биелсэн
2. Засгийн газар ОҮИТБС- ыг хэрэгжүүлэхдээ Иргэний нийгмийнхэн болон Компаниудтай хамтран ажиллах амлалт гаргасан уу?		Биелсэн
3. Засгийн газар ОҮИТБС- ыг хэрэгжүүлэлтийг хариуцан удирдах хүнээ томилсон уу?	Одоогоор ҮЗ-ийг боломжит хамгийн дээд албан тушаалтан буюу Монгол улсын Ерөнхий сайд даргалж байна. Тиймээс энэхүү шалгуур үзүүлэлтийг Монгол улс хангасан хэмээн үзэж байна. Баталгаажуулалтын баг Монгол улсад хүрэлцэн ирэхээс өмнө ҮЗ нь байгуулагдсан цагаасаа хойш нийтдээ 3 удаа л хуралдсанаас сүүлийн 18 сарын хугацаанд хуралдаан огт явуулаагүйд Баталгаажуулагч нар ихээхэн санаа зовниж байсан билээ. Үүний шалтгааныг тухайн үеийн Ерөнхий сайдын эрүүл мэндийн байдалтай холбон тайлбарлаж байсан болно. Баталгаажуулалтын баг үйл ажиллагаагаа явуулсанаас хойш 7 хоногийн дараа буюу 2009 оны 11 дүгээр сарын 27-нд ҮЗ өөрийн 4 дэхь хуралдаанаа зарлан хуралдуулжээ.	Биелсэн
4. Хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, оршиж чадавхид (Засгийн газар, Хувийн хэвшил, Иргэний нийгэм) гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг агуулсан, зардлыг бүрэн тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэвлэн нийтэлсэн үү?	Үйл ажиллагааны төлөвлөгөө нь бүрэн хэмжээний дэлгэрэнгүй баримт бичиг болсон бөгөөд нийт 30 зорилт, 90 үйл ажиллагааг багтаасан байна. Гэхдээ үйл ажиллагаа болгонд хамаарах зардлыг бүрэн тусгаагүй мөн гарч болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээг (эрсдлийн дүн шинжилгээ болон эрсдлийг бууруулах хүчин зүйлсийг тооцоогүй) агуулаагүй байна. Баталгаажуулалтын журмын дагуу эдгээрийг Үйл ажиллагааны төлөвлөгөөнд харгалзан оруулах ёстой байсан. Баталгаажуулалтын багийн зүгээс Үйл ажиллагааны төлөвлөгөө нь гүйцэтгэх үйл ажиллагаанд бус харин гарах үр дүнд тулгуурласан байх ёстой хэмээн үзэж байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөний голлох үндсэн хэсгүүд нь бүрэн тусгагдсан учраас	Биелсэн

Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулагчдын тайлбар	Баталгаажуулагчдын үнэлгээ
constraints (gov., private sector and civil society)?	энэхүү шүүмжлэл нь шалгуур үзүүлэлтийн биелэлтийг няцаах хангалттай шалтгаан болохгүй билээ.	
БЭЛТГЭЛ ХАНГАХ ХЭРЭГЖИЛТ		Биелсэн
5. Засгийн газраас ОУИТБС-ын хэрэгжилтийг хянах Оролцогч талуудын ажлын бүтцийг (Үндэсний Зөвлөл, Ажлын хэсэг) байгуулсан уу?	Баталгаажуулагчдын зүгээс Ажлын хэсэг болон ҮЗ-ийн хуралдаануудын талаарх мэдээлэл одоогоор хязгаарлагдмал, хаалттай байгаа болохыг тэмдэглэж байна. Ажлын хэсэг болон ҮЗ-ийн хуралдааны тэмдэглэлүүдийг Монголын ОУИТБС-ийн вебсайт дээр байрлуулан, олон нийтийн хүртээл болгоогүй байна.	Биелсэн
6. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үйл явцад иргэний нийгэм оролцож байна уу?		Биелсэн
7. ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үйл явцад компаниуд оролцож байна уу?	Одоогоор Монгол улсад 200 гаруй уул уурхайн компани үйл ажиллагаа явуулж байгаа ч ҮЗ болон Ажлын хэсэгт жижиг болон дунд хэмжээний компаниудын төлөөлөл байхгүй байгаа билээ. Эдгээр жижиг болон дунд хэмжээний компаниуд нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын дийлэнх хувийг эзлэж байгаа билээ (үйл ажиллагааны цар хүрээгээр бус харин тоон үзүүлэлтээр). Цаашдаа Монголын ОУИТБС нь эдгээр компаниудыг илүү зохистойгоор хамруулах талаар анхаарал хандуулах шаардлагатай байна.	Биелсэн
8. Засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үйл явцад тулгарч буй аливаа саад тогторыг арилгаж байна уу?	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх тогтсон арга зам гэж үгүй бөгөөд Монгол улсад хэрэгжиж байгаа энэхүү санаачилгын талаарх бүрэн хэмжээний хяналт болон үйл явцыг ЗГ бүрэн хэмжээгээр хянах боломжгүй билээ. Баталгаажуулагч нарын зүгээс энэ хэсгийн дүгнэлт болон тайлан дээр тусгагдсан саад бэрхшээлүүдийг сайтар судлан үзэж, тухайн саадыг арилгах талаар арга хэмжээ авах хэрэгтэй байна. Үүни хүрээнд хууль зүйн хүрээнд өөрчлөлт хийх болон ОУИТБС-ын институцын бүтцийг өөрчлөх зэрэг байж болно.	Биелсэн
9. ОУИТБС-ын тайлангийн маягтуудыг Оролцогч талууд хэлэлцэн тохирсоны үндсэн дээр боловсруулсан гаргасан уу?	Зарим нэгэн төрлийн татвар, төлбөрийг тайлангын маягтаас хасах болон эргэн авч үзэх зэрэг үйл ажиллагааг Ажлын хэсэг дээр хэлэлцэн шийджээ. Гэхдээ Баталгаажуулагч нарын зүгээс НӨАТ болон нийгмийн даатгалын шимтгэл нь ЗГ-г төлж буй төлбөр мөн тул бусад татвар, төлбөрийн адилаар хяналтад байх ёстой хэмээн үзэж байна. Тиймээс тэдгээрийг эргүүлэн маягтуудад оруулах асуудлыг бодож үзэх хэрэгтэй хэмээн зөвлөж байна. Түүнчлэн Ажлын хэсэг дээр төлбөрийн материаллаг байдал гэдэг дээр ямар зүйлсийг оруулах талаар хэлэлцэх хэрэгтэй байна. Ажлын хэсэг мөн 2007 оны аудитын тайланд дурдагдсан санал зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн хандив, тусламжийг нээлттэй болгох, үүнд материаллаг болон мөнгөн бус тусалмжийг заавал оруулж байх, тайлагнах үйл ажиллагааг сайжруулахын тулд сургалт явуулах, үүгээр дамжуулан төрийн байгууллагууд өөрийн мэдээллээ аудиторруудад нээлттэй гарган өгч байх боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна. Эцэст нь Маягт 1 дээрх мэдээллүүд нь цаанаа аудитлагдсан мэдээлэл дээр үндэслэгдсэн байх ёстойг мөн заавал биелүүлэх үүрэг болгож болно. Үүн дээр нэмээд даган мөрдөөгүй тохиолдолд хуулийн дагуу	Биелсэн

Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулагчдын тайлбар	Баталгаажуулагчдын үнэлгээ
	<p>хариуцлага хүлээлгэдэг болгох хэрэгтэй байна.</p> <p>Ирээдүйдээ маягтуудын цар хүрээг илүү өргөтгөж биет аудит хийх, борлуулалтын үнийн аудит хийх болон бүтээгдэхүүнийг мөнгөн дүнгээр аудитлах түүнчлэн Маягт 1 дээр компаниуд аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангуудаа хавсаргах зэргээр өргөжүүлж болох юм. Гэхдээ одоогын маягтууд нь нарийвчлал сайтай, эдгээрийг ашиглан тодорхой тооны асуудал, зөрүүнүүдийг илрүүлсэн амжилттай байна. Үүн дээр нэмээд ОУИТБС одоо маягтуудыг хянан үзэж байгаа бөгөөд энэ нь 2007 оны аудитын тайлан дээр дурдсан зөвлөмжийн хүрээнд хийгдэж байна.</p>	
10. Тайлануудыг нэгтгэн ОУИТБС-ын тайлан гаргасан аудитын байгууллагын дүгнэлтийг зөвшөөрч байгаа юу?	2006 оны болон 2007 оны тайлангуудыг харьцуулахад ихээхэн ахиц дэвшил гарсан нь тодорхой харагдаж буйн хажуугаар эхний аудиторчуудын санал болгосон маягтуудыг өөрчлөх санал нь хэрэгжин сайжирсан зэргээс үүдэн дараагийн аудитын тайлан ихээхэн сайжирсан байна.	Биелсэн
11. Засгийн Газраас бүх компаниудад ОУИТБС-ын тайлангийн маягтаар ил тод тайлагнах тэгш нөхцлийг хангаж өгсөн үү?	<p>Шинэчлэн найруулсан Ашигт малтмалын хууль нь Монгол улсад ОУИТБС-ын аудитыг явуулах хууль зүйн орчин байгаа болохыг харуулах тодорхой нотолгоо юм. Гэсэн хэдий ч ОУИТБС-ыг хуулиар заах нь чухал шаардлагатай ч гэсэн олборлох үйлдвэрлэл эрхлэж буй бүх компаниудыг тайланг гаргуулах хангалттай хөшүүрэг болохгүй юм. Үүнээс үүдээд 7 компани 2007 онд тайлангаа гаргаагүй бөгөөд аудиторчуудын зүгээс ч гэсэн 2006 болон 2007 онд гарсан их хэмжээний зөрүүнүүдийн учрыг олох тал дээр ихээхэн хүндрэлтэй тулгарч байжээ. Ажлын хэсгийн хуралдаанаар оролцогч талууд энэ асуудлыг сөхөн ярьж бүх компаниуд заавал тайлагнаж байх хуулийн зохицуулалт хэрэгтэй талаар хэлэлцсэн байна. Баталгаажуулагч нар Монгол улсад үйл ажиллагаагаа явуулсаны дараа буюу 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр болсон Ажлын хэсгийн хуралдаанаар тайлангаа буруу гаргасан болон гаргаагүй компаниуд болон удирдах ажилтнуудад хариуцлага тооцох талаар хуулийг өөрчлөх талаар ярилцсан байна. Үүнийг хуралдааны тэмдэглэлийн 6 дугаар зүйл дээрээс харж болно.</p> <p>Гэсэн хэдий ч Баталгаажуулагч нар ЗГ-ын зүгээс бүх оролцогч талуудын нийтлэг зөвшөөрсөн үйл ажиллагааг явуулан компаниуд нь тайлангаа гаргах үйл явцыг бүрэн батлаажуулж байгаа талаарх шалгуур үзүүлэлтэд нийцэхүйц хангалттай нотолгоог олж чадаагүй болно.</p> <p>Тиймээс Баталгаажуулагч нарын зүгээс энэхүү нөхцөл биелэгдээгүй хэмээн дүгнэж байна.</p>	Биелээгүй
12. Компаниудын тайлан олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг Засгийн газраас хангаж өгсөн үү?	Хуулийн дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй бүх компани өөрийн санхүүгийн тайландаа олон улсын стандартын дагуу аудит хийлгэж байх ёстой бөгөөд ОУИТБС-ын таллангийн маягт дээр тайланд дурдагдсан мэдээлэл нь аудитаар батлагдсан иайлан дээр суурилсан байх ёстойг заажээ. Хэрэг дээрээ Олон улсын санхүүгийн тайлангийн стандартууд нь Монголд анх удаа 2003 онд орчуулагдсан ба үүнээс хойш хийгдсэн өөрчлөлтүүд нь огт	Биелээгүй

Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулагчдын тайлбар	Баталгаажуулагчдын үнэлгээ
	<p>орчуулагдан хэрэгжээгүй байна. Бүгд биш ч гэсэн ихэнх томоохон уул уурхайн компаниуд олон улсын стандартад нийцсэн аудитын компаниар санхүүгийн тайландаа аудит хийлгэж байна. Хэдийгээр хууль тогтоомж дээр дээр дурдагдсан олон улсын стандартыг даган мөрдөх талаар заалтууд байгаа хэдий ч үүний хэрэгжилт нь бүрэн хэмжээгээр хэрэгжиж чадаагүй байна'. Үүнтэй холбоотойгоор СЯ-наас “Татвар төлөгч компаниуд нь санхүүгийн тайлангаа Монгол улсын хууль тогтоомж болон олон улсын стандартын дагуу гаргахгүй байгааг харуулж байна” хэмээжээ. ОУИТБС-ын Ажлын төлөвлөгөөг гаргах үед Ажлын хэсгийн гишүүд Дэлхийн банкттай хамтран компаниудын санхүүгийн тайлан гаргах үйл явцыг олон улсын стандартад нийцүүлэх талаар ярьсан хэдий ч энэ нь ОУИТБС-ын хүрэнээс хальсан хэрэг хэмээн үзсэн байна.</p> <p>Баталгаажуулагч нар Ажлын хэсэг дээр компаниудын тайлангын мэдээллийн чанарын асуудлаар ярилцан, ямар нэгэн арга хэмжээ авсан талаарх ямар нэгэн нотолгоог олж чадаагүй. Цаашид ОУИТБС хамтын ажиллагааны болон хууль зүйн аргуудыг ашиглан компаниудын тайлан нь олон улсын стандартын дагуу гаргасан санхүүгийн тайлан дээр үндэслэхийг баталгаажуулах байх хэмээн найдаж байна.</p>	
<p>13. Засгийн газрын тайлангууд олон улсын стандартуудын дагуу аудитлагдсан тоо бүртгэлд тулгуурласан байх нөхцлийг Засгийн газар хангаж өгсөн үү?</p>	<p>Аудитын хуулиар төрийн байгууллагуудын санхүүгийн тайлан нь олон улсын стандартын дагуу аудитаар баталгаажсан байх ёстой ба СЯ-ны Төрийн нарийн бмчгийн дарга тухайн тайлангууд нь олон улсын стандартын дагуу аудитлагдсан болохыг шалган баталгаажуулдаг байна.</p> <p>Гэхдээ ЗГ-ын тайлан нь орон нутагт авч буй хандив, тусламжийг бүрэн тусгаагүй тул олон улсын стандартын дагуу аудитаар баталгаажсан хэмээн тооцох боломжгүй байна. Аймаг болон сумын засаг захиргаа хүлээн авсан бүх хандив тусламжаа тайлагнахгүй байгаа нь үндсэндээ тэдний авсан тусламжийг төв дээр төвлөрүүлэн дахин хуваарилалтад оруулна гэсэн айдасаас үүдэлтэй байна. Ажлын хэсгийн хуралдаанаар энэ асуудлыг хэд хэдэн удаа ярилцсан хэдий ч одоогоор тодорхой зөвшилцөлд хүрээгүй байна.</p> <p>Аудитын хоёрдахь тайлангын 5.2 дугаар хэсэг дээр ЗГ-ын харьяа байгууллагууд олборлох салбарын дүн мэдээг цуглуулан удирдах тал дээр сайжруулах зүйлс их байгааг тэмдэглэн үүний тоонд ҮТЕГ болон Ашигт малтмалын хэрэг эрхлэх газруудыг цохон дурдсан байна. ЗГ-ын тайланд тулгарч буй голлох асуудал нь орон нутгийн засаг захиргааны түвшинд (аймаг болон сум) ЗГ-ын маягтыг бүрэн хэмжээгээр бөглөн тайлагнах чадавх ихээхэн доогуур хэмжээнд буй явдал байна. Баталгаажуулагч нар Монгол улсад ажилласнаас хойш буюу 2009 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр ҮЗ хуралдсан бөгөөд энэхүү хуралдааны тэмдэглэлийн 1 дүгээр заалт дээр “компаниудаас хандив, туслалцаа авах үйл явцыг бүх шатанд зохицуулан, тэдгээрийг тайлагнаж байх талаар ҮЗ-д танилцуулах” хэмээн тэмдэглэсэн байна.</p>	<p>Биелээгүй</p>

Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулагчдын тайлбар	Баталгаажуулагчдын үнэлгээ
ИЛ ТОД ТАЙЛАГНАХ		
14. Компаниудаас төлж байгаа газрын тос, байгалийн хий, уул уурхайн холбогдолтой бүх материаллаг төлбөрүүд (төлбөрүүд) – ийг нэгтгэн дүгнэж, тайлан гаргах гэрээ байгуулсан аудиторын байгууллагад нээлттэй байсан уу?	Компаниудын зүгээс ЗГ-т төлж байгаа бүх төрлийн материаллаг төлбөрийг одоогоор тодорхойлон, тайлагнахгүй байгаа болох нь илэрхий байна. Үүний тоонд гол нь орон нутагт өгсөн хандив тусламж болон орон нутагт зөвшөөрөл авахад төлдөг төлбөр багтаж байна. Эдгээрийн орон нутгийн засаг захиргаа ихэнхдээ тайлагнахгүй, эсвэл дутуу тайлагнадаг, мөн компаниуд үүнийг хандив биш харин зардал хэмээх ангилалд оруулдаг учир сайтар тодрохгүй байна. Одоогоор орлогын материаллаг байдал гэдэгт хандив тусламж орсон хэдий ч энэхүү компанийн зүгээс төлсөн төлбөр болон орон нутагт хүлээн авсан хандив тусламж дээр гарч буй зөрүүг хэрхэн талаар Ажлын хэсэг дээр ярилцан шийдээгүй л байна. Хамгийн сүүлд болсон ҮЗ-ийн хуралдааны хэлэлцэх асуудлын 2 дугаарт ЗГ-ийн зүгээс энэхүү асуудал буюу орон нутагт төлж буй хандив тусламжийг тайлагнуулах чиглэлээр анхаарал хандуулж эхэлж байгааг харуулж байна. Гэсэн ч Баталгаажуулагч нар орлогын материаллаг байдлын талаар ярилцах, үүнийг тайлагнуулах талаар ямар нэгэн үйл ажиллагаа явуулж буй талаарх хангалттай нотолгоог олоогүй	Биелээгүй
15. Засгийн газарт хүлээн авсан газрын тос, байгалийн хий, уул уурхайн бүх материаллаг орлогуудын (орлогууд)- ыг нэгтгэн дүгнэж, тайлан гаргах гэрээ байгуулсан аудиторын байгууллагад нээлттэй байсан уу?	Уул уурхайн компаниудын зүгээс орон нутагт өгч байгаа хандив, тусламжийн тал дээр Ажлын хэсэг бүрэн хэмжээгээр тодорхойлолт гаргаагүй ч одоо явагдаж байгаа аудитын үйл ажиллагааны хүрээнд энэ талаар зарим мэдээллийг гаргаж байгаа нь ихээхэн сайшаалтай хэрэг бөгөөд ЗГ-ийн хүлээн авсан бүх орлогийг нээлттэй болгох анхны алхамуудыг хийж эхлээд байна. Аудитын үйл ажиллагаа бүрэн хэмжээгээр хамарч чадахгүй байгааг нээлттэйгээр хүлээн зөвшөөрч буй нь ихээхэн ололттой тал бөгөөд одоогоор Монгол улсын ЗГ-ын хүлээн авсан бүх материаллаг орлогыг ил тод, нээлттэй болгоогүй байна. Бүх материаллаг орлогыг нээлттэй болгон тайлагнуулах чиглэлээрх ҮЗ-ийн шийдвэр нь (хандив, тусламж болон мөнгөн бус төлбөр) энэ талаар үйл ажиллагаа явуулж эхэлж байгааг баталгаа болж байна. Гэхдээ энэхүү шатанд ҮЗ ч, Ажлын хэсэг ч “материаллаг орлого” гэж юу болохыг бүрэн тодорхойлон гаргаагүйн улмаас уул уурхайн компаниудын зүгээс ЗГ-т өгсөн ихээхэн өндөр хэмжээний төлбөр ОУИТБС-ийн тайланд тусгагдалгүй үлдэж байна. Энэхүү шалтгааны улмаас тухайн шалгуур үзүүлэлт биелээгүй хэмээн үзэж байна.	Биелээгүй
16. Компани, Засгийн газрын тайлангуудыг нэгтгэн дүгнэх гэрээ байгуулсан аудиторын байгууллага үүргээ хангалттай биелүүлсэн гэдгийг Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл зөвшөөрч байгаа юу?	Ажлын хэсэг дээр хэлэлцсэнээр 2006 оны аудитын тайланд нилээд тооны асуудал байсан ба хамгийн гол асуудал нь аудиторууд тоон үзүүлэлтүүдийг эх баримт болон аудитлагдсан санхүүгийн баримттай тулган шалгаагүй явдал байсан ажээ. Гэхдээ 2007 оны аудитын үр дүнд тодорхой ахиц дэвшил гарсан ба сонгогдсон аудитын компани болох Эрнст Яангын мэдэгдсэнээр боломжтой бүх тохиолдолд зарим тоон үзүүлэлтүүдийг эх баримттай нь тулган шалгаасан байна. Гэсэн ч зарим тохиолдолд аудиторууд баримтуудыг гарган өгөхийг шаардах хууль ёсны эрх дутмагаас болоод саад тотгортой тулгарч байжээ. 2006 онтой харьцуулбал 2007 оны аудитын нэгтгэлийн тайлан хавьгүй сайжирсан бөгөөд	Биелсэн

Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулагчдын тайлбар	Баталгаажуулагчдын үнэлгээ
	цаашид өгөх санал зөвлөмжүүдийг биелүүлсэнээр 2008 оны тайлан илүү сайжирна хэмээн итгэж байна.	
17. ОУИТБС-ын тайланд зөрүүтэй байдлыг олж тодорхойлон, авбал зохих арга хэмжээний талаар санал зөвлөмж гаргасан уу?	Монгол улсад хэрэгжиж буй ОУИТБС нь байнгын тасралтгүй үргэлжилж буй үйл явц болоод байгаа бөгөөд үүнийг 2006 оны болон 2007 оны тайлангуудын хооронд гарсан ихээхэн ахиц дэвшлээр нотлон тайлбарлаж болно. Үйл явцтай холбоотой хэд хэдэн асуудал аудиторын гаргасан тайлан болон Баталгаажуулагч нарын ярилцлагад туссан ба тэдгээр асуудлуудад холбогдох талууд Ажлын хэсэг, ҮЗ анхаарлаа хандуулах ёстой. Түүнчлэн иргэний нийгмийн зүгээс 2006 оны шийдэгдээгүй үлдсэн ихээхэн хэмжээний зөрүүнүүдийн талаар асуудлыг дэвшүүлсэн ба үүний гол агуулга нь зөрүү илэрсэн тохиолдолд хэн үүнийг цааш нь лавшруулан шалгах ёстой асуудал дээр оршин буй болно. Учир нь аудиторуудын зүгээс үйл явцтай холбоотой асуудлаар санал зөвлөмж гаргах тал дээр ихээхэн анхаарч байгааг хажуугаар зөрүүнүүдийг хэрхэн тодруулах талаар ямар нэгэн зааварчилгаа өгөх боломжгүй байгаад оршино. Тиймээс үүнтэй холбоотой хариуцлага нь Ажлын хэсэг болон ҮЗ-д ноогдож, хэрхэн цаашид зөрүүнүүдийг тодруулж байх тал дээр тодорхой шийдвэр гаргах шаардлагатай байна. Хэдийгээр ОУИТБС-ын зүгээс 2006 болон 2007 оны аудитаар тогтоогдсон зөрүүнүүдийг шалгах талаар тодорхой ажил цаашид явуулах шаардлагатай байгаа ч одоогоор ОУИТБС-ын хүрээнд зөрүүг тогтоох, үүнийг шийдэх арга замыг хайх, хэрэгжүүлэхэд ихээхэн хэмжээний ахиц дэвшил, амжилт гараад байгаа учраас Баталгаажуулагчдын зүгээс энэхүү шалгуур үзүүлэлт биелэгдсэн хэмээн дүгнэж байна.	Биелсэн
Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр талаар хэрхэн дэмжлэг үзүүлсэн бэ?	ОУИТБС-ын зүгээс аудитын нэгтгэлд зарим жижиг болон дунд хэмжээний компаниудаас хамруулах талаар авч үзэх шаардлагатай бөгөөд үүгээр дамжуулан тухайн компаниудын түвшинд хэдий хэмжээний зөрүү гарч болох талаарх мэдээллийг цуглуулан тогтоож болно.	Биелсэн
ТАЙЛАНГ ИЛ ТОД МЭДЭЭЛЭХ, ТҮГЭЭХ		
18. Засгийн газраас ОУИТБС-ын шалгуурын дагуу тайлангийн дүнг олон нийтийн хүртээл болгосон уу? Тайлангийн дүн олон нийтэд ойлгомжтой, бүрэн бүтнээр, хүртээмжтэй байдлаар очсон уу?	Аудитын нэгтгэл тайлангууд нь Монгол болон Англи хэл дээр бичигдэн, олон нийтэд нээлттэй байгаа бөгөөд 2006 болон 2007 оны тайлангуудыг харьцуулан харахад ихээхэн ахиц дэвшил гарсан байна. Ажлын хэсгийн зүгээс олон нийтэд мэдээлэл хүргэх асуудлыг ирэх жилийн үйл ажиллагааны чухалчлах асуудал болгон тогтоогоод байна.	Биелсэн
ОУИТБС –ыг цааш нь тогтвортой хэрэгжүүлэх, сургамж, алдаанаас сурах, гарсан зөрүүг шийдвэрлэх чиглэлээр ямар арга хэмжээ авах хэрэгтэй вэ?	Баталгаажуулагч нарын үзэж байгаагаар ОУИТБС Монгол улсад анхлан үйл ажиллагаа явуулж эхэлсэнээс хойш ихээхэн хэмжээний ахиц дэвшил гарсан байна. Тайлангын маягтуудыг сайжруулсан, зөрүүнүүдийг тогтоон тайлагнасан болон олон нийтэд мэдээлэл түгээх чиглэлээр хөрөнгө оруулалт хийж эхэлсэн зэрэг нь ОУИТБС нь оролцогч талууд болон аудиторуудын гаргасан шүүмжлэлд нухацтай хандаж, арга хэмжээ авч ирсэнийг	Биелсэн

Шалгуур үзүүлэлт	Баталгаажуулагчдын тайлбар	Баталгаажуулагчдын үнэлгээ
	харуулж байна.	

ХАВСРАЛТ Б. ТОВЧ ТАЙЛАН

1 ТАНИЛЦУУЛГА

Энэхүү Хавсралт дээр Бүлэг 7 дээр гарсан санал, зөвлөмжүүдийг дэлгэрүүлэн тайлбарласан болно. Үүний гол зорилго нь Баталгаажуулагчдын зүгээс бие даасан тойм үнэлгээг гарган, ОУИТБС цаашид хэрэгжүүлэх санал зөвлөмжүүдийг гарган, Монгол улсад байгалийн баялагын орлогын ил тод, хариуцлагатай байдлыг бий болгох зорилгой билээ. Энэхүү Хавсралт нь Монголын ОУИТБС-ын хувьд Шалгуур үзүүлэлт 11-15-д нийцэхийн тулд хийж гүйцэтгэх үйл ажиллагааг тусгайлан заагаагүй бөгөөд харин ОУИТБС-ыг хэрэгжүүлэхийн тулд ямар үйл ажиллагааг явуулах хэрэгтэйг Олон улсын ОУИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газар болон Монголын ЗГ-ын хооронд хэлэлцэн тохирох хэрэгтэй юм.

Ирэх жилүүдэд олборлох салбар нь Монгол улсын хувьд эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий салбар болон хөгжих төлөвтэй байгаа ба Оюу Толгой болон Таван Толгойн ордуудыг ашиглаж эхэлсэнээр энэхүү салбар нь эдийн засагт одоо эзлэж байгаагаасаа хавьгүй илүү байр суурийг эзлэх болоод байна (ОУИТБС-ын аудитад одоогоор уул уурхайн салбар нь хамгийн багаар үзэхэд улсын төсвийн 40%-ийг бүрдүүлж байгааг дурджээ)

Монгол улсын хувьд байгалийн баялагаас олох ашиг нь өнөө болон ирээдүй үеийнхэнд ихээхэн чухал бөгөөд үүнд харин орлогын ил тод байдлыг хангах шаардлага тулгараад байна. Орлогын ил тод байдал болон байгалийн нөөцийн менежментийг засаглалын хүрээнд нэвтрүүлэх хэрэгтэй байгаа билээ. Олон тооны улсууд “нөөц баялагын хараал” хэмээх зүйлийн золиос болоод байгаагын шалтгаан нь нөөц баялагыг эзэмшихийн тулд хүчирхийлэл үүсгэх явдлаас үүдэлтэй байгаа билээ. Хэдийгээр зарим улсад мөргөлдөөн гараагүй ч гэсэн улс төр, эдийн засгийн элит бүлэглэлийн авлигатай холбогдох байдал хэтэрсэнээс үүдэн нөхцөл байдал доройтож, эдийн засаг зогсонги байдалд орж улс төрийн хариуцлага алдагдаж байна.

Монгол улсын хувьд энэ байдалд хүрэхэд хол байгаа хэдий ч Монгол улсын байгалийн баялаг нь энэхүү улсад өөрийн үр өгөөжөө агч байхыг баталгаажуулах нэн тэргүүн шаардлага байгаа билээ. ОУИТБС нь ихээхэн үр дүнд хүрээд байгаа бөгөөд энэхүү үр дүн нь зөвхөн уул уурхайн салбарын орлогын мэдээллийг ил тод болгоод зогсохгүй, төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаанд гарч буй асуудлуудыг тодохойлоход ч тусаа өгсөн байна.

Өөрийн үйл ажиллагаагаа сайжруулах хүсэлтэй байгаа ЗГ-ын хувьд энэ нь ихээхэн чухал зүйл бөгөөд жишээ нь орон нутгийн төрийн байгууллагуудад өгч байгаа хандив, тусламжийг бүрэн тооцохгүй байгаа эсвэл компаниуд өөрийн татвар, хураамжаа олон улсын түвшинд нийцэх хэмжээнд гаргахгүй байгаа зэрэг олон асуудлуудыг гарган иржээ.

Компаниудын хувьд ОУИТБС нь ил тод байдлын давуу талыг ашиглан олон нийтэд компаниуд хэдий хэмжээний орлого оруулж байгааг мэдээлэх нэгэн таатай боломж юм. ЗГ-т төлсөн татвар, төлбөрийхөө хэмжээг нээлттэй байлгаснаар ялангуяа орон нутгийн оролцогчдод нээлттэй байлгаснаар тэд олон нийтэд хэр хариуцлагатай компани болохоо харуулах боломж олдоно. ЗГ-т төлсөн мөнгөн дүнг ил болгосноор зарим тохиолдолд засаглалын аргачлал болж ч болох ба үүнээс үүдэн иргэд татвар хураан авсан ЗГ-аас илүү сайн үйлчилгээг шаардах боломжтой болно.

Иргэний нийгмийн хувьд ОУИТБС нь ЗГ-ыг хариуцлагатай ажилуулах, хүлээн авсан орлогоо шударга, зохистой байдлаар түгээх зэргийг шаардах боломжийг бий болгоно. Гэхдээ орлого цуглуулах нь ЗГ-ын үйл ажиллагааны нэгээхэн хэсэг юм. Магадгүй хамгийн чухал нь энэхүү цуглуулан авсан орлогоо үр дүнтэйгээр удирдах явдал байж болох билээ. Тийм учраас ОУИТБС болон иргэний нийгэм хамтран Оксфорд төвийн гаргасан Байгалийн нөөцийн баримт бичгүүд, Дэлхийн Банкны орон нутгийн түвшний орлогын урсгалыг нээлттэй болгодог санаачилга зэргийг судлан үзүүштэй.

1.1 Монгол улсын уул уурхайн салбар дахь авлигын байдал

Дэлхийн хаана ч гэсэн авлигыг тоон үзүүлэлтээр гаргахад ихээхэн хүндрэлтэй. Зарим олон улсын хэмжээний системийг ашилах нь илүү үр дүнтэй байж болох ба эдгээрт зарим салбаруудыг илүү түлхүү дурдаж оруулсан байдаг. Эдгээрийн тоонд Транспаренси Интернейшнл байгууллагын Авлигын индекс, Дэлхийн Банкны Бизнес эрхлэхийг хөнгөвчлөхүй хэмээх индекс зэрэг багтаж болно. Дээрх хоёр баримт бичигт Монгол улс нь зэрэглэлийн хувьд доошилсон байгаа бөгөөд эхний индекс дээр 2007 онд 99, 2008 онд 102 харин 2009 онд 120 дугаар байрт орсон байх ба дараагын индексээр Монгол улс нь 56-аас 60 дугаар байр руу ухарсан байна. Харин энэхүү судалгааны татвар төлөлт хэсэг дээр ихээхэн амжилттай байсныг дурдах хэрэгтэй. Дээрх хоёр судалгаанаас харвал Монгол улсад авлига, сул засаглалын талаарх санаа зовоосон асуудал байсаар байгаа ба Баталгаажуулагч нар энэхүү салбарт тухайн асуудлууд байгааг баталгаажуулсан болно. Судалгааныхаа үр дүн дээр үндэслэн бид нар энэхүү асуудлууд дээр хэт их анхаарал хандуулалгүйгээр шийдсэн болно. Түүнчлэн Баталгаажуулагч нар авлигын талаарх мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулаагүй билээ. Гэсэн ч ОУИТБС-ыг Баталгаажуулалтын хүрээнд гадны үнэлгээ хийлгэж байгаагын нэг гол хэсэг нь оролцогч талуудын илэрхийлсэн асуудлаар шударга, шулуун, нээлттэй ярилцлага өрнүүлэх боломж байдаг билээ. Оролцогч талуудын зүгээс авлигатай хамааралтай байж магадгүй хэмээн тооцогдож буй салбарууд нь дараах салбарууд байна:

Хайгуулын болон ашиглалтын лиценз олголт

Оролцогч талуудын үзэж байгаагаар хайгуулын болон ашиглалтын лиценз олголт нь хээл хахуулийн нэгэн эх үүсвэр болж байна. Үүний жишээнд А компани ашигт малтмал бүхий талбайд лиценз авахаар өргөдөл өгөхөд үүнд татгалзсан хариу өгөн харин хээл хахууль өгч буй Б компанид олгох зэргээр илэрч болно. Ийм төрлийн

Гэрээ байгуулах, бүтэц болон цаг хугацаа

Гэрээ хэлцэл хийх нь ихээхэн хаалттай байдаг салбар бөгөөд үүнд иргэний нийгмийн хяналт үргэлж дутагдалтай байдаг бөгөөд хаалттай байдлаар компаниуд болон ЗГ хооронд хийгдсэн гэрээ нь ихэнх тохиолдолд Монгол улсад үр дүнгээ өгдөггүй байна.

Иргэний нийгмийнхэний дурдсанаар мөн олон тохиолдолд хэлцэл хийх үеэр орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх үйл явц дутмаг байдагаас хамааран төв ЗГ давуу талыг эдлэн хэлцэл хийдэг бөгөөд үүний сөрөг үр нөлөө нь урт хугацаандаа илэрдэг байна.

Цаг хугацаа нь ихээхэн асуудал болдог талаар зарим компани дурдсан бөгөөд гэрээ хийсний дараа баталгаажихыг удаан хүлээх хэрэг гардаг бөгөөд ингэж удааснаар хээл хахууль авах сонирхол ихээр байдаг ажээ. Дэлхийн Банкны дэмжлэгээр Кадастрын албан дээр хийгдэж байгаа автоматжуулалтын төслийн хүрээнд гэрээг шууд автоматаар батлах тул цаашид нөхцөл байдал сайжирна хэмээн найдаж байна.

Орон нутгийн засаг захиргаанд өгөх хандив, төлбөр

Орон нутгийн засаг захиргаанд өгөх хандив, төлбөр, татвар нь оролцогч талуудын зүгээс өргөнөөр хүлээн зөвшөөрсөн нэгэн асуудал энэ бөгөөд энэ талаар Баталгаажуулалтын тайлан дээр илүү тодорхой тусгасан болно.

1.2 Байгаль орчны асуудал

ОУИТБС-ын гол чиглэл нь ил тод байдал бөгөөд байгаль орчны асуудал нь тэргүүлэх чиглэл биш юм. Гэхдээ ярилцлагын үеэр Монгол улсын байгаль орчин нь шууд, сөрөг байдлаар төв болон орон нутгийн засаг захиргааны авлигын асуудлын нөлөөнд ороод байна. Тодруулбал хэд хэдэн оролцогч тал байгаль орчны зөвшөөрөл өгөх болон байцаагч нарын шалгалтын асуудлыг Монгол улсад бий болсон нэгэн ноцтой асуудал хэмээн үзсэн. Хэд хэдэн ТББ-ийн үзэж байгаагаар уул уурхайн салбар нь гол ус бохирдох, экологид сөрөг нөлөө үзүүлж байгаа ба эдгээр нь үндсэндээ хуулийн хэрэгжилт сул байгаагаас үүдэлтэй байна. Компани болон иргэний нийгмийн төлөөлөл хэлэхдээ байцаагч нарыг хялбархан хахуульдаж болдог хэмээн хэлж байлаа.

2 ҮР ДҮНГҮҮД

2.1 Хууль зүйн болон зохицуулалтын бүтэц

ОУИТБС-ыг Монгол улсын хууль зүй, зохицуулалтын тогтолцоонд хамруулсан хэд хэдэн тогтоол шийдвэрийг гаргажээ. Гол баримт бичгүүдийн тоонд (Хавсралт Е дээр бүгдийг оруулсан)

- 1 ҮЗ-ийн ажиллах журам, дүрэм
- 2 Санамж бичиг (ЗГ, ТББ болон компаниудын хооронд ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай 2007 оны 4 дүгээр сард гарын үсэг зурсан)
- 3 ЗГ-ын 80 дугаар тогтоол (2007 оны 3 дугаар сарын 28-нд гарсан- ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд оролцох төрийн байгууллагуудын чиг үүргийн тухай)
- 4 Ашигт малтмалын хуулийн 48.9 болон 48.10 дугаар заалт.

Үнэлгээний тайлан нь хууль эрх зүйн талаарх илүү мэдээллийг агуулсан байгаа. Одоогын бүтцийн хүрээнд ОУИТБС-ын зарим бүрэлдэхүүн хэсгийг гүйцэтгэх үүрэг хариуцлага төрийн байгууллагуудын алинд нь ноогдож байгаа нь тодорхойгүй байна. Одоогоор УТЕГ нь ЗГ-ын тайлангуудыг нэгтгэн гаргах үүргийг хүлээгээд байна. Гэхдээ эдгээр байгууллагуудад зөвхөн ОУИТБС-ын ажлыг хариуцсан байнгын ажилтан байхгүй, мөн гаргаж буй тайлан нь нямбай, цаг тухайдаа гарч буйг баталгаажуулах хэмжээний чадавхи мөн бүрдээгүй байна. УТЕГ-ын ажилтнууд ч мөн өөрсдөө харьяанд нь ажиллаж байгаа дээд түвшний яамнаас мэдээлэл гаргаж өгөхийг

шахаж шаардаж байх нь протоколын хэмжээний асуудал хүндрэлийг үүсгэдэг талаар дурдаж байсан.

Аудитаар илэрсэн зөрүүг нягтлан шалгах, тодруулах үүрэг хариуцлагыг аль тал хүлээх талаар мөн тодорхойгүй байна. Хэдийгээр ҮЗ ҮАГ-т 2006 оны аудитаар илэрсэн зөрүүний учрыг олох хүсэлт гарган шилжүүлсэн ч тухайн байгууллага нь зөрүүг нягтлан шалгаагүй нь хариуцлага хүлээх байдал тодорхойгүйтэй холбоотой. Баталгаажуулагч нарын зүгээс энэхүү үүрэг хариуцлагыг зөвхөн төрийн нэг байгууллагад хариуцуулах нь ихээхэн чухал бөгөөд ингэснээр тухайн зөрүүнүүдийг нягтлан шалгах боломжтой болохыг тэмдэгдэж байна.

Дараагын нэг зүйл нь ОУИТБС-ын тусгай хуультай болох нь төрийн байгууллагууын хариуцах зүйлсийг тодорхой болгож үүний хажуугаар ч компаниуд болон гадны гэрээлэгч нарын үйл ажиллагааг зохицуулах боломжтой болно. Хуулиар компаниудад заавал тайлагнах үүргийг үүсгэн тэдний гарган өгч буй мэдээлэл нь аудитаар баталгаажсан мэдээлэл байхыг хуульчилж болно. Үүний зэрэгцээ даган төрлөөгүй тохиолдолд авах арга хэмжээ, хүлээлгэх хариуцлага тодорхой болно.

2.2 Иргэний нийгмийн чадавх

Иргэний нийгмийн төлөөлөлтэй Баталгаажуулагч нарын хийсэн ярилцлагын үзэр олон тооны хүмүүс ОУИТБС-ын зарчмуудыг өргөтгөх өөр бусад хамаарах салбар руу өргөжүүлэх хүсэлтэй байгаагаа тэмдэглэн хэлж байлаа.

Иргэний нийгэм нь ирэх жилүүдэд хийх үйл ажиллагаандаа чухалчлах үйл ажиллагааг тодорхойлсоны тоонд орон нутгийн иргэний нийгмийн хүчин чадлыг хөгжүүлэн бүс нутгуудад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаа багтсан байна. Гэхдээ цаашид судлагаа хийх болон ЗГ-ын бодлогын хэрэгжилтийг хянах байнгын боломжийг бий болгох хэрэгтэй байна.

Иргэний нийгмийн зүгээс ОУИТБС-ын хууль ёсний бүтэц болон институцын бүтцэд санаа зовож буй бөгөөд одоогоор ОУИТБС-ын хүрээд буй ололт амжилтад ерөнхийдөө сэтгэл хангалуун байгааг хажуугаар олон талын оролцоот бүтэц болон зөвшилцөлд суурилсан хандлагад ихээхэн талархалтай хандаж байна.

2.3 Стратеги

Монгол улс нь ОУИТБС-ын гол зарчмууд, орлогын ил тод хариуцлагатай байдлыг тусгаг хамруулсан ирээдүйн стратегийг боловсруулан ирэх гурван жилийн ашигт малтмалын салбарын стратегид нийцүүлэх шаардлагатай байна. Энэхүү стратегид Оксфордын их сургуулийн Байгалийн баялагийн эрх хэмээх баримт бичигт дурдсан зарчмуудыг ашиглаж болно. Энэ нь ил тод байдлын зарчмуудаас өргөжин иргэний нийгэм болон ЗГ хэрхэн орлогын урсгалын зохистойгоор удирдах арга замыг харуулсан байдаг.

Монголын ОУИТБС нь тухайн улсад явуулж буй үйл ажиллагаагаа бэхжүүлэх зорилгоор өөрийн гэсэн стратегийг боловсруулах хэрэгтэй. Энэхүү стратегид 2006 болон 2007 оны аудитаар илэрсэн онцлог асуудлууд, Баталгаажуулагч нарын өгсөн санал зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг багтаах нь зүйтэй.

Эцэст нь хэлэхэд одоогын ОУИТБС-ын Үйл ажиллагааны төлөвлөгөө ихээхэн хуучирсан байна. Шинэ төлөвлөгөөг зохиохдоо санаачилгын үйл ажиллагаа, тулгараад байгаа асуудлуудыг эрэмбэлэн, тохиолдож болох саадыг тогтоон тэдгээрийн хэрэгжилтийг хянан шалгууруудыг тогтоох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл шинээр гарах Үйл ажиллагааны төлөвлөгөө нь голлох үйл ажиллагаанууд дээр суурилсан стратегийг хандлагатай байх ёстой.

2.4 Аудит

4. Нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагад гаргаж өгсөн танай компанийн тайлангийн тоон үзүүлэлтийг олон улсын стандартын дагуу хараат бус аудитаар хянуулсан уу?		✓	
5. Нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагаас тодруулга, тайлбар хүссэн хүсэлтэд өмнө гаргаад байсан ОУИТБС- ын тайлангийн маягтын дагуу хариу тодруулга өгч, Засгийн газрын тайлантай нэгтгэх ажилд дэмжлэг үзүүлсэн үү?		✓	
		Тийм	Үгүй
Дээрх хариултын үнэлгээ			
Хариулт авсан хүний санал			
Үгүй гэсэн хариулт бүрт бичих тайлбар:			
Бусад санал, тайлбар			



Баталгаажууллалтын хүрээнд компаниудаас тавих асуулт

Гобь Коул энд Энержи ХХК

Үндэсний түвшинд:			
Компани	Улс		
Хариулт – харалдаа газар ✓ “шувуухай” тавина.		Тийм	Үгүй
1. Танай компани Монгол улсад ОУИТБС- ыг хэрэгжүүлэхийг дэмжинэ гэдгээ ил тод нийтэд мэдээлсэн үү?		✓	
2. Танай компани Монголын ОУИТБС- ын Ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах амлалт өгсөн үү? Үүнд: Хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, захирамж, санамж бичиг зэрэг эрхзүйн баримт бичгүүд орно. Мөн оролцогч талуудын хуралд оролцож байв уу?		✓	
3. Танай компани нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагад тайлангийн маягтын дагуу болон тогтоосон хугацаанд материаллаг төлбөрүүдээ ил тод гаргаж өгч байсан уу?		✓	
4. Нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагад гаргаж өгсөн танай компанийн тайлангийн тоон үзүүлэлтийг олон улсын стандартын дагуу хараат бус аудитаар хянуулсан уу?		✓	
5. Нэгдсэн тайланд аудит хийсэн байгууллагаас тодруулга, тайлбар хүссэн хүсэлтэд өмнө гаргаад байсан ОУИТБС- ын тайлангийн маягтын дагуу хариу тодруулга өгч, Засгийн газрын тайлантай нэгтгэх ажилд дэмжлэг үзүүлсэн үү?		✓	
		Тийм	Үгүй
Дээрх хариултын үнэлгээ			
Хариулт авсан хүний санал	<div style="border: 1px solid black; padding: 5px; display: inline-block;"> ЭНД ЭНЕРЖИ GOBI COAL AND ENERGY LLC УЛААНБААТАР ХОТ </div> <i>Гобь Коул энд Энержи ХХК</i> <i>Хуулийн зөвлөл</i> <i>Н.Олоншиг</i>		
Үгүй гэсэн хариулт бүрт бичих тайлбар:			
Бусад санал, тайлбар			

ХАВСРАЛТ Г. БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛДӨГЧ ТАЛУУД

Нэр	Албан тушаал	Байгууллага
ҮЗ-ийн гишүүд		
С.Баярцогт (орлож Дэд Сайд)	Сангийн сайд	Сангийн Яам
Д.Ганболд	Ерөнхийлөгч	Монголын уул уурхайн үндэсний ассоциац
Н.Баярсайхан	Захирал	Хил хязгааргүй алхам ТББ
Ч.Ганзориг	Ерөнхий захирал	Эрдэнэт корпораци
Д.Зоригт	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
Ажлын хэсгийн гишүүд		
Э.Сумьяа	Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	Монгол улсын ЗГ
Б.Эрдэнэсүрэн	ОУИТБС-ын Ажлын хэсгийн дарга	Монгол улсын ЗГ
Ц.Мөнхбаяр	Тэргүүн	Онги гол хөдөлгөөн
О.Эрдэнээ	Ерөнхий захирал	Монголросцветмет компани
Ц.Ганболд	Тэргүүн	Ил Тод сан
Ц.Оюунбаатар	Дарга	ҮТЕГ
Д.Батхуяг	Дарга	Ашигт малтмалын газар
С.Мягмардаш	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын дарга	СЯ
Д.Сандаг	Дэд ерөнхийлөгч	Бороо Голд компани
Ж.Батболд	Ерөнхийлөгч	Монголын Байгаль орчны ТББ-уудын холбоо
Бусад		
Г.Цогт	Үйлдвэрлэл, уул уурхай хариуцсан дэд ерөнхийлөгч	МАК компани
Л.Отгонцэцэг	Тэргүүн	Онон-Улз гол хөдөлгөөн
Д.Цэрэнжав	Судлаач	Ил Тод сан
Б.Бадарч	Хуульч	Хүний эрх, хөгжил төв
П.Эрдэнэжаргал	Гүйцэтгэх захирал	Нээлттэй нийгэм форум
Д.Сэнгэлмаа	Зохицуулагч	ТАН эвсэл (20 ТББ)
Грем Ханкок	Ахдах зөвлөх	Газрын тос, байгалийн хий, уул уурхай болон химийн үйлдвэрлэлийн газар, Дэлхийн банк
Энхзаяа	Зохицуулагч	Хариуцлагатай уул уурхайн санаачилга
Лейтон Крофт	Компанийн харилцаа	Айвенхоу Майнс Монгол

Нэр	Албан тушаал	Байгууллага
	хариусан дэд ерөнхийлөгч	компани
Г.Алтансүх	Ахлах аудитор, Даатгал болон зөвлөх бизнесийн үйлчилгээ	Эрнст Яанг Монгол компани
С.Оюун	УИХ-ын гишүүн	
Чад Блевитт		Айвенхоу Майнс Монгол компани
Ребекка Дарлинг	Суурин төлөөлөгч	Азийн сан
Жаргалсайхан	Нийтлэлч, иргэний нийгмийн зүтгэлтэн	Шударга татвар, ухаалаг зарцуулалт
Болормаа	Бодлогын ажилтан	Азийн сан
Ш.Уртнасан	Ажилтан	Нягтлан бодох бүртгэлийн газар, СЯ
Жим Двайр	Гүйцэтгэх захирал	Монголын бизнесийн зөвлөл
Дуглас Кентиш	Үйл ажиллагаа хариуцсан менежер	Зүүн Ази
Сэм Бартлет	Баталгаажуулалтын албаны тэргүүн	Олон улсын ОУИТБС-ын Нарийн бичгийн дарга нарын газар

ХАВСРАЛТ Д. ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ БОЛОН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД

2009 оны 11 дүгээр сарын 1-ны байдлаарх ОУИТБС-ын ҮЗ-ийн гишүүд

Албан тушаал	Нэр	Утасны дугаар	Электрон шуудан	Төлөөлөл
ҮЗ-ийн дарга, Монгол улсын Ерөнхий сайд	С.Батболд			ЗГ
ҮЗ-ийн дэд дарга, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	Д.Зоригт	260222 326367 99112984	Zorigt_dashdorj@yahoo.com	ЗГ
Сангийн сайд	С.Баярцогт	260247 91913884		ЗГ
УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга	Ч.Хүрэлбаатар	262346 99112317		ЗГ
Монгол улсын Ерөнхий аудитор	Ч.Раднаа	264653 999117345		ЗГ
Үндэсний статистикын хорооны дарга	С.Мэндсайхан	312433 261433 99117825	nso@magicnet.mn	ЗГ
Авлигатай тэмцэх газрын дарга	Ч.Сангарагчаа	70110251 99114596	contact@iaac.mn	ЗГ
Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн Ерөнхийлөгч	Д.Ганболд	314877	ganbold@miningmongolia.mn	Компани
Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга	С.Дэмбэрэл	327176 324394	chamber@mongolchamber.mn info@mongolchamber.mn	Компани
Эрдэнэт компанийн Ерөнхий захирал	Ч.Ганзориг	01-352-73501;73707; 73855; 320561 99115878	erdenetub@magicnet.mn tsogbaatar@erdenetmc.mn	Компани
Айвенхоу Майнс Монгол компанийн Ерөнхий захирал	Ж.Макен	331880 99114501	sodkhuut@ivancorp.net	Компани
Арева Монгол компанийн Ерөнхий захирал	Е.ДеСез	70110675 99100475	Eric.deseze@areva.com	Компани
Нээлттэй нийгэм	П.Эрдэнэжаргал	313207	jargal@forum.mn	Иргэний

форумын Гүйцэтгэх захирал		99118128		нийгэм
Хний эрх, хөгжил төвийн тэргүүн	Г.Уранцоож	99192857	urantsooj@mongolnet.mn	Иргэний нийгэм
Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн	Н.Баярсайхан	312989 99724869 96200814	Bayar_n2000@yahoo.com	Иргэний нийгэм
Нээлттэй нийгэм форумын менежер	Н.Дорждарь	313207 99085899	dorjdari@forum.mn	Иргэний нийгэм
Монголын ажил олгогч эздийн холбооны Ерөнхийлөгч	Л.Нямсамбуу	313122 99112367	monef@magicnet.mn	Иргэний нийгэм
ҮЗ-ийн нарийн бичгийн дарга, Ерөнхий сайдын ахлах зөвлөх	Б.Эрдэнэсүрэн	263928	Erdenesuren5@yahoo.com	ЗГ

2009 оны 11 дүгээр сарын 1-ны байдлаарх ОУИТБС-ын Ажлын хэсгийн гишүүд

Албан тушаал	Нэр	Утасны дугаар	Электрон шуудан	Төлөөлөл
Ажлын хэсгийн дарга, Ерөнхий сайдын Ахлах зөвлөх	Б.Эрдэнэсүрэн	262938 99113468	Erdenesuren5@yahoo.com	ЗГ
Үндэсний татварын ерөнхий газрын дарга	Ц.Оюунбаатар	320167 99115423	oyunbaatar@mta.mn Puujanu2008@yahoo.com oyuhehe@yahoo.com	ЗГ
Ашигт малтмалын газрын дарга	Д.Батхуяг	263701 99112709 99088479	dbathuyag@mail.mn , byambadagva@mram.gov.mn , ttsegts@yahoo.com	ЗГ
Газрын тосны газрын дарга	Д.Амарсайхан	633861 631447 99088822 99156623	Chuluunbat_ch@yahoo.com	ЗГ
СЯ-ны Нягтлан болох бүртгэлийн бодлогын газрын дарга	С.Мягмардаш	261788 88082679	Myagmardash_s@yahoo.com	ЗГ
Эрдэс баяаг, эрчим хүчний яамны геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дарга	Д.Батхүү	262565 262120 99119423	Tsoigt_ch@yahoo.com	ЗГ
Байгаль орчин, аялал	Д.Энхбат	264166	Enkhbat_num@yahoo.com	ЗГ

Албан тушаал	Нэр	Утасны дугаар	Электрон шуудан	Төлөөлөл
жуулчлалын яамны Байгалийн нөөцийн хэлтсийн дарга				
Авлигтай тэмцэх газрын Авлигатай тэмцэх хэлтсийн дарга	Д.Дуламсүрэн	311919 70112473 88119400	dulamsuren@iaac.mn	ЗГ
Монголросцветмет компанийн Ерөнхий захирал	О.Эрдэнээ	450060 99114210 99119356	erd_och@yahoo.com info@exportmongolia.mn	Компани
Багануур компанийн захирал	Д.Дамбапэлжэ э	12120114 99097150	dambapeljee@baganuurmine.mn	Компани
Бороо Голд компанийн дэд захирал	Д.Сандаг	317798 99112714	Sandag.d@centerragold.mn	Компани
МАК компанийн ерөнхийлөгч	Б.Нямтайшир	458075	mak@mak.mn tsogt@mak.mn erka@mak.mn	Компани
Петрочайна Дачин Тамсаг компанийн ерөнхий захирал	С.Мэргэнсод	463567 99114915	erdenedorj@datamo.mn uranchimeg@datamo.mn	Компани
Уул уурхайн үндэсний ассоциацийн Гүйцэтгэх захирал	Н.Алгаа	314877 99118792	algaa@miningmongolia.mn	Компани
Нүүрс ассоциацийн захирал	Л.Даваацэдэв	324044	coalasso@yahoo.com	Компани
Нээлттэй нийгэм форумын менежер	Н.Дорждарь	313207 99085899	dorjdari@forum.mn	Иргэний нийгэм
Информ Төвийн гүйцэтгэх захирал	Р.Батпүрэв	99776690	sengelmaa@forum.mn	Иргэний нийгэм
Ил тод сангийн тэргүүн	Ц.Ганболд	322641 99125453	ganbold@eiti.mn	Иргэний нийгэм
Онги голынхон хөдөлгөөний тэргүүн	Ц.Мөнхбаяр	327781	tsmunkhbayar@onggiriver.org	Иргэний нийгэм
Миний Монголын газар шороо хөдөлгөөний гүйцэтгэх захирал	Б.Болдбаатар	99089902	Bold_mmgs@yahoo.com	Иргэний нийгэм
Монголын үндэсний үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн	Н.Дашзэвэг	99191313	dashnamjaa@yahoo.com	Иргэний нийгэм

Албан тушаал	Нэр	Утасны дугаар	Электрон шуудан	Төлөөлөл
Монголын Байгаль орчны ТББ-уудын холбооны ерөнхийлөгч	Ж.Батболд	315306 99113499	Batbold@selenetravel.cm batbold@magicnet.mn	Иргэний нийгэм
Монголын ажил олгогчдын холбооны Гүйцэтгэх захирал	Х.Ганбаатар	325635 98888449 99118449	ganbaatar@monef.mn	Иргэний нийгэм
Монголын МНБ-ын институтын ерөнхийлөгч	Д.Энх-Амгалан	70111927 99112647	enkh@monicpa.mn	Иргэний нийгэм
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын ахлах референт	Э.Сумьяа	260911	Sumiya_e@cabinet.gov.mn	ЗГ

ХАВСРАЛТ Е. МОНГОЛЫН ОУИТБС-ЫН ҮНДСЭН БАРИМТ БИЧГҮҮД

Үндэсний зөвлөлийн 2006 оны 5 дугаар сарын
12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн батлав.
Үндэсний зөвлөлийн 2007 оны 3 дугаар сарын
13-ны өдрийн хуралдаанаар өөрчлөлт оруулав.

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ҮНДСЭНИЙ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага /цаашид “санаачлага- гэнэ/-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэнэ/ нь төрийн байгууллага, үйлдвэрлэл, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий зөвшлийн байгууллага мөн.
2. Үндэсний зөвлөлийн зорилго нь Санаачлагыг хэрэгжүүлэх үндсэн зарчим болон улс төр, эрх зүй, зохион байгуулалтын нөхцлийг бүрдүүлэх явдал мөн.
3. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

Хоёр. Үндэсний зөвлөлийн зохион байгуулалт

4. Үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд байна.
5. Ерөнхий сайдыг эзгүйд Ерөнхий сайдын даалгаснаар үндэсний зөвлөлийн аль нэг гишүүн үндэсний зөвлөлийн хуралдааныг удирдан явуулах, хуралдааны чөлөөт цагт үндэсний зөвлөлийн ажлыг зохицуулна.
6. Үндэсний зөвлөл нь Улсын Их Хурал, сайд, яам, агентлагын дарга зэрэг төрийн байгууллагын төлөөлөл, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн төлөөлөл, иргэний нийгэм, төрийн бус байгууллага гэсэн 3 талт адил тэгш төлөөллөөс бүрдэнэ. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын тогтоолоор батална.
7. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Ажлын хэсгийн ахлагч байна. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүний нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
8. Үндэсний зөвлөл шаардлагатай үед Үндэсний зөвлөлийн даргын, түүний эзгүйд орлож байгаа гишүүний зөвшөөрснөөр хуралдана. Хуралдааны бэлтгэлийг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга хангана.
9. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Үндэсний зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүнд танилцуулж хуралдаанаас 2-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд бичгээр хүргүүлнэ.
10. Үндэсний зөвлөлийн хуралдаан гишүүдийн олонхи бүрдсэнээр эхэлнэ. Зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүний зөвшөөрснөөр гишүүн саналаа бичгээр ирүүлж болно.
11. Үндэсний зөвлөл хуралдааны тэмдэглэл гаргана. Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг ажлын хэсгийн аль нэг гишүүн хөтөлнө. Тэмдэглэлд Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга гарын үсэг зурж албажуулна.

12. Үндэсний зөвлөлийн удирдлаган дор ажлын хэсэг ажиллах бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Ерөнхий сайдын захирамжаар батална. Ажлын хэсэг нь төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

13. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг ажлын хэсэг эхлэн боловсруулж ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн Үндэсний зөвлөлд танилцуулж байна.

14. Үндэсний зөвлөлийн гишүүн хуралдаанд асуудал боловсруулан хэлэлцүүлэх, хэлэлцэх асуудлын талаар санал гаргах эрхтэй. Гишүүн хуралдаанаар хэлэлцүүлэхээр боловсруулсан асуудлаа Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргад өгч хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж гишүүдэд хүргүүлнэ.

15. Үндэсний зөвлөл нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар эрдэмтэн, мэргэжилтэн, зөвлөх оролцсон шинжээчийн хэсэг байгуулж дүгнэлт гаргуулж болно.

Гурав. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал

16. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын талаарх хууль тогтоомж, шийдвэрийн төслийг боловсруулах чиглэлийг өгөх асуудал;

17. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажлын хэсгээс боловсруулсан төслүүд;

18. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сайд, агентлагийн удирдлагын мэдээлэл, санал;

19. Үндэсний зөвлөлийн ажиллах журам, ажлын хэсгийн тайлан, мэдээлэл;

20. Хуралдаанаар хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

Дөрөв. Үндэсний зөвлөлөөс тавих хяналт

21. Үндэсний зөвлөл гаргасан шийдвэр, өгсөн үүргийн биелэлтээ гаргуулж гишүүдэд танилцуулах, шаардлагатай бол хуралдаанаар хэлэлцэх бөгөөд хуралдааны чөлөө цагт Үндэсний зөвлөлийн дарга танилцаж чиглэл өгнө.

22. Үндэсний зөвлөлийн гаргасан шийдвэрийн биелэлт, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлж байгаа байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гишүүд, ажлын хэсэг хяналт тавина.

23. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх чиглэлээр Ажлын хэсгээс хийж байгаа үйл ажиллагааны явц, биелэлттэй Үндэсний зөвлөлийн дарга, гишүүд танилцаж, явцыг эрчимжүүлэх арга хэмжээ авч болно.

Тав. Бусад

24. Үндэсний зөвлөлийн бичиг хэргийн зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, ажлын алба хариуцна.

25. Үндэсний зөвлөл нь Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдгийг хэрэглэнэ.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор оролцогч 3 тал Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагын эвслийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичиг

Нэг. Оршил

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын олон улсын санаачлагын зорилго, зарчим, шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын оролцогч 3 тал хүлээн зөвшөөрч, сахин баримтлахаа илэрхийлж,
2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэх хүрээнд нягт хамтран ажиллахаар тохиролцож,
3. Компаниуд болон Засгийн газар санаачлагын тайлан гаргаж улсад төлсөн болон хүлээн авсан албан татвар, төлбөрөө нийтэд мэдээлэх нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах, авилгал хээл хахуулиас урьдчилан сэргийлэх, үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахад онцгой үүрэгтэйг оролцогч 3 тал хүлээн зөвшөөрч,
4. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг газрын тос, эрдэс баялгыг ашиглах хүрээнд, мөн Төв Засгийн газрын хэмжээнд төдийгүй орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхээр тогтсоноо нотолж,
5. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайланг олборлох үйлдвэрлэл эрхэлж байгаа компаниуд болон Засгийн газар гарган нийтэд мэдээлж, түүндээ аудит хийлгэн энэхүү санаачлагын хэрэгжилтийг цаашид улам боловсронгуй болгон тогтворжуулж хөгжүүлэхийн чухлыг онцлон тэмдэглэж, санаачлагад оролцогч 3 тал дараахь агуулга бүхий хамтын ажиллагааны санамж бичгийг байгуулж байна:

Хоёр. Талуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

6. Санаачлагад оролцогч гурван талын хамтран хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

- 6.1. санаачлагыг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалт, арга зүйн үндсийг боловсруулж хэлэлцэн тохирч бүрдүүлэх;
- 6.2. санаачлагын тайлан гаргах маягт, зааврыг боловсруулан оролцогч 3 талын оролцоотойгоор зөвшилцөн мөрдөх;
- 6.3. санаачлагад оролцогч 3 тал бие биеэ хүндэтгэн адил тэгш, харилцан ойлголцсон хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- 6.4. санаачлагын хүрээнд тайлангийн аудитаар баталгаажсан үзүүлэлтийг ашиглах;
- 6.5. санаачлагад оролцогч 3 талын хооронд гарсан аливаа маргаан, зөрчлийг 3 талын оролцоотойгоор харилцан зөвшилцөн шийдвэрлэх;
- 6.6. санаачлагатай холбоотой аливаа хяналт шалгалтыг тухайн оролцогч талын удирдах байгууллагын албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу явуулах;
- 6.7. санаачлагыг хэрэгжүүлэх санхүүгийн боломжийг олон улсын жишиг, хууль тогтоомжийн хүрээнд хэлэлцэн зохицуулах;
- 6.8. санаачлагын тайланд аудит хийлгэж, цаашдын хөгжлийн асуудлыг төлөвлөн хэрэгжүүлэх;
- 6.9. санаачлагын хэрэгжилтийн явц, байдалд олон улсын холбогдох байгууллагаар баталгаажуулалт хийлгэх.

7. Засгийн газрын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

7.1. санаачлагыг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүү, арга зүйн дэмжлэгээр хангаж ажиллах, энэ хүрээнд хандивлагч олон улсын байгууллага, гадаад орны зөвлөлгөө, тусламж дэмжлэгийг авч байх;

7.2. санаачлагыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулах ажлыг эрхэлж, санаачлагатай холбоотой аливаа бодлого, шийдвэрийн төслийг ажлын хэсгийн түвшинд оролцогч 3 талын тэгш оролцоог хангасан нөхцөлд, Үндэсний зөвлөлийн төвшинд оролцогч талуудын оролцоог хангасан нөхцөлд хэлэлцэн шийдвэрлэж байх;

7.3. олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийг санаачлагад хамруулах, аж ахуйн нэгжээс хүлээн авсан албан татвар, төлбөрийн Засгийн газрын тайланг аж ахуйн нэгж бүрээр болон улсын хэмжээнд нэгдсэн дүнгээр Сангийн яам нэгтгэн батлагдсан маягтын дагуу гаргаж нийтэд мэдээлэх, улмаар санаачлагын бие даасан ажлын албанд тайлагнаж байх;

7.4. санаачлагын хэрэгжилтийн явц, үр дүнг оролцогч талуудын оролцоотой хэлэлцэн дүгнэх, цаашдын зорилгоо тодорхойлж байх.

8. Компаниудын хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

8.1. санаачлагыг хэрэгжүүлэх бодлого тодорхойлох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогч компанийн төлөөлөлд саналаа өгөх, шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

8.2. олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг батлагдсан маягтын дагуу гарган нийтэд мэдээлж, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах;

8.3. санаачлагын тайланд орсон тоо баримт нь аудитаар баталгаажсан, үнэн зөв байхыг компанийн удирдлага хариуцах;

8.4. олон улсын жишиг, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санаачлагын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр ил тод санхүүжүүлж болно.

9. Төрийн бус байгууллагын эвслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

9.1. санаачлагыг хэрэгжүүлэх бодлого тодорхойлох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд төлөөллөө оролцуулж, шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

9.2. санаачлагын тайланг Сангийн яам, компаниуд гарган нийтэд хэрхэн мэдээлж байгаа явц, үр дүнд ажиглалт, хяналт-шинжилгээ хийх;

9.3. төрийн бус байгууллага хийсэн ажиглалт, хяналт-шинжилгээний үр дүнгээ эвслийн хурлаар хэлэлцэн оролцогч талуудад хүргэн шийдвэрлүүлж байх, ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулах, санал санаачлага гаргах;

9.4. олон улсын жишиг, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санаачлагын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр ил тод санхүүжүүлж болно.

10. Санаачлагыг хэрэгжүүлэх бие даасан ажлын албаны хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

10.1. санаачлагыг хэрэгжүүлэх бие даасан ажлын албыг байгуулж ажиллана.

10.2.бие даасан ажлын алба нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлж санаачлагад оролцогч талуудыг мэдээллээр ижил тэгш хангаж, оролцогч талуудыг зохицуулах;

10.3.санаачлагын тайлан гаргах явцад хяналт тавьж, мэдээлэл цуглуулах, олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан албан татвар, төлбөрийн тайланг батлагдсан маягтын дагуу аж ахуй нэгж бүрээр болон улсын хэмжээгээр гаргасан Засгийн газрын тайланг Сангийн яамнаас хүлээн авна. Олборлох үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт төлсөн тайланг аж ахуйн нэгж бүрээр батлагдсан маягтын дагуу уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүлээн авна. Хоёр тайланг шалган санаачлагын улсын тайлан гаргах, аудит хийлгэх ажлыг зохион байгуулах;

10.4.санаачлагын хэрэгжилтэд олон улсын баталгаажуулалт хийлгэх ажлыг зохион байгуулж, баталгаажуулалт болон аудитын дүгнэлтийн мөрөөр авах арга хэмжээг төлөвлөн ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж байх.

Гурав. Санамж бичиг байгуулсан:

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлэгч 3 тал:

Засгийн газрыг төлөөлж:	Компанийг төлөөлж:	Төрийн бус байгууллагын эвслийг төлөөлж:
Монгол Улсын Ерөнхий сайд, Үндэсний зөвлөлийн дарга	Уул уурхайн ассоциацийн хүндэт ерөнхийлөгч, Үндэсний зөвлөлийн гишүүн	Төрийн бус байгууллагын эвслийн зохицуулагч, Үндэсний зөвлөлийн гишүүн
М.ЭНХБОЛД	П.ОЧИРБАТ	Ц.ГАНБОЛД
Огноо: 2007.4.25	Огноо: 2007.4.11.	Огноо: 2007.4.6.
Монгол Улсын Сангийн сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн	Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал, Үндэсний зөвлөлийн гишүүн	Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал, Үндэсний зөвлөлийн гишүүн
Н.БАЯРТСАЙХАН	П.АЛГАА	П.ЭРДЭНЭЖАРГАЛ
Огноо: 2007.4.25.	Огноо: 2007.4.12.	Огноо: 2007.4.6.
Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайд, Үндэсний зөвлөлийн гишүүн	Монгол-Орсын хамтарсан Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирал, Үндэсний зөвлөлийн гишүүн	Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн, Үндэсний зөвлөлийн гишүүн
Ц.ДАВААДОРЖ	Х.НАРАНХҮҮ	Г.УРАНЦООЖ
Огноо: 2007.4.25.	Огноо: 2006.4.4.	Огноо: 2007.4.6.

Үндэсний статистикийн Монголын алт Миний монголын газар
газрын дарга, Үндэсний корпорацийн ерөнхийлөгч, шороо хөдөлгөөний
зөвлөлийн гишүүн ажлын хэсгийн гишүүн гүйцэтгэх захирал, ажлын
хэсгийн гишүүн

П.БЯМБАЦЭРЭН

Б.НЯНТАЙШИР

Б.БОЛДБААТАР

Огноо:2007.3.28.

Огноо: 2007.4.12.

Огноо: 2007.4.6.

Монгол Улсын ерөнхий
аудитор, Үндэсний
зөвлөлийн гишүүн

Монгол газар компанийн
Төлөөлөн удирдах
зөвлөлийн дарга, ажлын
хэсгийн гишүүн

Онги голынхон
хөдөлгөөний тэргүүн,
ажлын хэсгийн гишүүн

Л.ЖАВЗМАА

Ц.МЯНГАНБАЯР

Ц.МӨНХБАЯР

Огноо: 2007.3.28

Огноо: 2007.4.13.

Огноо: 2007.4.12.

Ерөнхий сайдын ахлах
зөвлөх, Үндэсний зөвлөл-
ийн нарийн бичгийн дарга,
ажлын хэсгийн ахлагч

Д.БАТБАЯР

Айвенхоу майнз
компанийн дэд
ерөнхийлөгч, ажлын
хэсгийн гишүүн

Информ төвийн гүйцэтгэх
захирал, ажлын хэсгийн
гишүүн

Р.БАТПҮРЭВ

А.МӨНХБАТ

Огноо: 2007.4.23.

Огноо: 2007.4.12

Огноо: 2007.4.06.

Үндэсний татварын
ерөнхий газрын дарга,
ажлын хэсгийн гишүүн

Л.ЗОРИГ

Бороо гоулд компанийн
дэд захирал, ажлын
хэсгийн гишүүн

Д.САНДАГ

Монголын үндэсний
үйлдвэрлэгчдийн холбооны
тэргүүн, ажлын хэсгийн
гишүүн

Н.ДАШЗЭВЭГ

Огноо: 2007.3.28

Огноо: 2007.4.10

Огноо: 2007.4.6.

Ашигт малтмал, газрын
тосны хэрэг эрхлэх газрын
дарга, ажлын хэсгийн
гишүүн

Л.БОЛД

Нүүрс асоциацийн тэргүүн,
ажлын хэсгийн гишүүн

Л.ДАВААЦЭДЭВ

Байгаль хамгаалах ТББ-
уудын тэргүүн, ажлын
хэсгийн гишүүн

Ж.БАТБОЛД

Огноо: 2007.3.28.

Огноо: 2007.4.10

Огноо:

Улсын мэргэжлийн
хяналтын газрын дарга,
ажлын хэсгийн гишүүн

Д.БАТБААТАР

Огноо: 2007.4.10

Мэргэшсэн нягтлан
бодогчдын институтын
ерөнхийлөгч, ажлын
хэсгийн гишүүн

Л.ДОНДОГ

Огноо: 2007.4.10.

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг үргэлжлүүлэн
хэрэгжүүлэх 2009-2010 оны ажлын төлөвлөгөө**

I. Зорилго: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (цаашид “ОУИТБС” гэх)-ын зохион байгуулалт, бүтэц, 3 талын оролцогчдын мэдлэг, ур чадвар, чадавхи бий болгох, дээшлүүлэх санаачлагыг үр дүнтэй, үр нөлөөтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлэх явдал мөн.

II. Хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хугацаа, эзэн, зардал:

№	Зорилтууд	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн	Зардал
I Үе шат- Санаачлагыг хэрэгжүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх.					
Б. Чадавхи бий болгох, үргэлжлүүлэн бэхжүүлэх талаар					
1	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын явц, цаашдын зорилгын талаар 3 тал (Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагууд)-ын үндэсний чуулган зохион байгуулах	-ОУИТБС-ыг Монголд хэрэгжүүлж байгаа туршлага, ололт, алдаа, цаашдын арга хэмжээг хэлэлцэх үндэсний чуулган зохион байгуулах бэлтгэл хангах -Семинарын төсөв зохиох - Чуулганд 100 хүн оролцуулах	2010 оны 5 дугаар сард	-Үндэсний зөвлөл -Ажлын хэсэг -Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 6140 \$ зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал 3Г хариуцна
2	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын явц, цаашдын зорилгын талаар 3 тал (Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагууд)-ын уулзалт зохион байгуулах	-ОУИТБС-ыг Монголд хэрэгжүүлж байгаа туршлага, ололт, алдаа, цаашдын арга хэмжээг хэлэлцэх уулзалт зохион байгуулах бэлтгэл хангах -Семинарын төсөв зохиох - Уулзалтанд 50 хүн оролцуулах	2009 оны 12 дугаар сард	Ажлын хэсэг -Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 3065 \$ зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал 3Г хариуцна
3	ОУИТБС-ын Засгийн газрын тайлан гаргах байгууллагын удирдлага, ажилтанд зориулсан сургалт	Төрийн байгууллагын холбогдох албан хаагч 50 хүн, үүнээс орон нутгаас 31 хүн	2009 оны 3 дугаар сард	Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 3065 \$ зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал 3Г хариуцна
4	Олборлох үйлдвэрлэл эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн удирдлагад зориулсан сургалт	Компанийн удирдлагуудаас 40 хүн оролцуулна.	2009 оны 3 дугаар сард	Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 2476 \$ зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал 3Г хариуцна
5	Олборлох үйлдвэрлэл эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалт	-Компанийн санхүүгийн ажилтнуудад зориулсан сургалтанд 40 хүн оролцуулна.	2009 оны 3 дугаар сард	Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 2476 \$ зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал 3Г хариуцна
6	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх	-ОУИТБС Төвийн бүсэд хэрхэн хэрэгжиж байгаа талаар уулзалт, хэрэгцээтэй мэдээллээр сургалт зохион байгуулах	2009 оны 6	Ажлын хэсэг	-Хандивлагчийн

	ажлын явц, цаашдын зорилгын талаар 3 тал (Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагууд)-ын Төвийн бүсийн уулзалт, сургалт зохион байгуулах-	бэлтгэл хангах -Семинарын төсөв зохиох - Уулзалт сургалтанд 50 хүн оролцуулах -Дотоодын компанийг сонгон газар дээр үзүүлэх, сургалтад оролцуулж заах	дугаар сард	Ажлын алба	итгэлийн сангаас 3065 S зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал ЗГ хариуцна
7	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын явц, цаашдын зорилгын талаар 3 тал (Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагууд)-ын Зүүн бүсийн уулзалт, сургалт зохион байгуулах	-ОУИТБС Зүүн бүсэд хэрхэн хэрэгжиж байгаа талаар уулзалт, хэрэгцээтэй мэдээллээр сургалт зохион байгуулах бэлтгэл хангах -Семинарын төсөв зохиох - Уулзалт сургалтанд 50 хүн оролцуулах	2009 оны 8 дугаар сард	Ажлын хэсэг Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 3065 S зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал ЗГ хариуцна
8	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын явц, цаашдын зорилгын талаар 3 тал (Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагууд)-ын Баруун бүсийн уулзалт, сургалт зохион байгуулах	-ОУИТБС Баруун бүсэд хэрхэн хэрэгжиж байгаа талаар уулзалт, хэрэгцээтэй мэдээллээр сургалт зохион байгуулах бэлтгэл хангах -Семинарын төсөв зохиох - Уулзалт сургалтанд 50 хүн оролцуулах	2009 оны 9 дугаар сард	Ажлын хэсэг Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 3065 S зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал ЗГ хариуцна
9	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлын явц, цаашдын зорилгын талаар 3 тал (Засгийн газар, компаниуд, төрийн бус байгууллагууд)-ын Хойд бүсийн уулзалт, сургалт зохион байгуулах	-ОУИТБС Хойд бүсэд хэрхэн хэрэгжиж байгаа талаар уулзалт, хэрэгцээтэй мэдээллээр сургалт зохион байгуулах бэлтгэл хангах -Семинарын төсөв зохиох - Уулзалт сургалтанд 50 хүн оролцуулах	2009 оны 9 дугаар сард	Ажлын хэсэг Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 3065 S зардлыг санхүүжүүлнэ -Байр зардал ЗГ хариуцна
10	Олборлох үйлдвэрлэл эрхлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид зориулсан зөвлөлгөө өгөх	-Компанийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад биечлэн зөвлөлгөө өгөх -Шаардлагатай бол орон нутагт явж зөвлөлгөө өгөх	2009-2010	Ажлын алба Ажлын хэсэг ТББ-ын эвсэл	Ажлын албаны зардал Унааны зардал АМГТХЭГ
11	Хэвлэл, мэдээллийн байгууллагын эдийн засгийн тоймч, сурвалжлагч нарт	-Мэдээлэл, зөвлөмжөөр хангах -уулзалтад урьж танилцуулга хийх -Үйл ажиллагаандаа оролцуулах	2009-2010	Ажлын алба	Ажлын албаны өдөр тутмын зардал

	мэдээлэл өгөх				
12	Компанийн болон Засгийн газрын тайлан гаргалтын явцад ажиглалт хийх	-Компаниудын тайлан гаргах явцад ажиглалт хийж зөвлөлгөө өгөх -Засгийн газрын тайлан гаргах явцад ажиглалт хийж зөвлөлгөө өгөх	2009-2010	Ажлын алба	Ажлын албаны өдөр тутмын зардал
13	ОУИТБС-ыг амжилттай хэрэгжүүлж байгаа улсад хийх танилцах аялал-2 удаа	Танилцах аялал зохион байгуулах ҮЗ-2 хүн, АХ-2 хүн, АА-2 хүн, ААН-2 хүн, ТББ-2 хүн	2009-2010 онд	Ажлын алба	-Хандивлагчийн итгэлийн сангаас 25000 \$ зардлыг санхүүжүүлнэ
В. Мэдээлэл түгээх, сурталчилгаа хийх, туршлага судлах талаар /communications/					
14	Компаниудаас ирүүлсэн ОУИТБС-ын тайланг эмхтгэн хэвлэн нийтлэх	-Тайланг цуглуулах -Хэвлэн нийтлүүлэх	2009	-Ажлын алба	-Зардал 5000 \$ ХИС
15	ОУИТБС-ын талаархи танилцуулга, гарын авлага материалыг англи хэлнээс орчуулан бэлдэж оролцогч компани, төрийн бус байгууллагад тараах	-холбогдох материал олох -Орчуулах -Захиалж хэвлүүлэх	2009-2010	-Ажлын алба	-Зардал 4000 \$ ХИС
		Засгийн газрын байгууллага, компаниуд, төрийн бус байгууллагыг холбогдох электрон мэдээллээр хангах	2009-2010	Ажлын алба	Ажлын алба
16	Монгол Улс-ОУИТБС вэб сайтаа тогтмол баяжуулж байх	Веб хуудсыг тогтмол баяжуулж байх, хэлэлцүүлэг явуулах	2009-2010	-Ажлын алба	-
17	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ОУИТБС-ын хэрэгжилтийн явц, үр дүнг тусгай төлөвлөгөөний үндсэн дээр тогтмол сурталчлах	-а/ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр TV нэвтрүүлэг хийлгэх.	2009-2010	-Ажлын алба	Хандивлагчийн итгэлийн сангаас 8000 \$ зардлыг санхүүжүүлнэ
		-б/өдөр тутмын сонинтой гэрээ байгуулан цуврал нийтлэл гаргах, хэлэлцүүлэг зохион байгуулах	2009-2010	Ажлын алба Зөвлөх	Хандивлагчийн итгэлийн сангаас 14400 \$ зардлыг санхүүжүүлнэ
		-в/Хэвлэлийн бага хурал зохион байгуулах -г/мэдээлэл түгээх бусад арга зам	2 удаа -	ҮЗ, АХ, Ажлын алба Ажлын алба	Ажлын алба Ажлын алба
18	ОУИТБС-ыг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан хууль тогтоомж, шийдвэр, тайлангийн	-Холбогдох хууль тогтоомж, баримт материалыг түүвэрлэж олшруулах	2009-2010	Ажлын алба	Хандивлагчийн итгэлийн сангаас 4000

	маягт, хамрагдах 3 талт байгууллагын чиг үүрэг зэргийг багтаасан эмхтгэл хэвлүүлэх				S зардлыг санхүүжүүлнэ
19	ОУИТБС-ын хэрэгжилт, үйл ажиллагааны талаар товхимол бэлтгэн хэвлүүлж сурталчлах	Тайлан, мэдээлэл, санхүүгийн тайлан, аудитын дүнг брошюр болгон хэвлэж байх	2009-2010	-Ажлын алба	-Зардал 4000 \$ ХИС
20	“ОУИТБС-Монгол Улс” товхимол англи, монгол хэлээр цуврал брошюр бэлтгэх	-Төлөвлөгөө гаргаж материал бүрдүүлэх -Орчуулах	2010	Ажлын алба	-Зардал 7500 \$ ХИС
21	“ОУИТБС”-ийн календарь хэвлүүлж, сурталчлах	Материал бүрдүүлэх, эх зохиох Хэвлүүлэх	2009 оны 10-р сард	Ажлын алба	-Зардал 7500 \$ ХИС
Ш үе шат Санаачлага хэрэгжүүлэх үйл ажиллагаа					
А. Санаачлагыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа					
22	Санаачлагын хэрэгжилтэд мониторинг хийх	-Санаачлагыг хэрэгжүүлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, татварын байгууллагад мониторинг хийх -Мониторингийн дүнг гаргах	2009 оны 9-11 дугаар сар	-Ажлын алба -Ажлын хэсэг -ТББ-ын эвсэл	-Зардал 10000\$ ХИС
23	Улсын болон орон нутагт төлсөн албан татвар, төлбөрийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн тайланг аж ахуй бүр гаргаж нийтэд мэдээлэх	-Аж ахуйн нэгж бүр маягтын дагуу тайлан гаргах, нийтэд мэдээлэх -Тайлангаа АМГТХЭГ хүргүүлэх, улмаар ажлын албанд хүргүүлэх	2009,2010 оны эхний улиралд	-Ажлын хэсэг -АМГТХЭГ	Зардлыг үйлдвэр, аж ахуйн нэгж хариуцна.
24	Улсын болон орон нутгийн төсөвт тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниас хүлээн авсан албан татвар, төлбөрийн Засгийн газрын тайланг Сангийн яам гаргаж нийтэд мэдээлэх	-компаниас улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан албан татвар, төлбөрийн Засгийн газрын тайланг маягтын дагуу Сангийн яам гаргаж нийтэд мэдээлэх -Тайлангаа ажлын албанд хүргүүлэх	2009,2010 оны эхний улиралд	Сангийн яам /ҮТЕГ, ГЕГ, орон нутгийн татварын албад, бусад холбогдох байгууллага/	Зардлыг тус тусын төсвөөс хариуцна
25	Компанийн болон Засгийн газрын тайланг хүлээн авах	-Тайланг 2 талын мэдээллийн эх үүсвэрээс хүлээн авах	2009,2010 оны эхний улиралд	Ажлын алба	-
26	Сонгогдсон компаниудын тайланд аудит хийх аж ахуйн нэгжийг	Сонгон шалгаруулах тендер зарлах, Үнэлгээний хороо байгуулж ажиллуулах	2009, 2010 оны 5-8-р сард	Ажлын хэсэг Ажлын алба	Ажлын алба

	сонгон шалгаруулах аудит хийлгэх	Аудит хийлгэх	9-р сард	Ажлын алба	Итгэлийн сангаас авсан зардал 200000\$ ХИС
		Аудитын дүнг хэлэлцүүлэх	10-р сард	Ажлын алба	-
27	Сонгогдоогүй компаниудын тайланд аудит хийх дотоодын байгууллагыг сонгон шалгаруулах, аудит хийлгэх	Сонгон шалгаруулах тендер зарлах, Үнэлгээний хороо байгуулж ажиллуулах	2009, 2010 оны 8-р сард	Ажлын хэсэг Ажлын алба	Ажлын алба
		Аудит хийлгэх	9-р сард	Ажлын алба	Итгэлийн сангаас авсан зардал 20000\$ ХИС
		Аудитын дүнг хэлэлцүүлэх	10-р сард	Ажлын алба	-
28	Орон нутагт болон оролцогч 3 талд ОУИТБС-ыг хариуцсан орон тооны 18 ажилтныг ажиллуулах	Холбогдох ажилтнуудтай гэрээ хийх	2009 оны 1-р улиралд	Ажлын алба	32400 \$ ХИС
		ОУИТБС-ын ажилтнуудын хийсэн ажлыг дүгнэх	Сар бүр		
		Цалинжуулах	Сар бүр		
29	ОУИТБС, түүний хэрэгжилтийн талаар санал асуулга явуулах	-Санал асуулга явуулах сэдвийг тодорхойлох -Санал асуулгын хуудас боловсруулах	2009 оны 5-6 -р сард	-Ажлын алба -ТББ-ууд	Ажлын алба
		-Санал асуулга явуулах -Санал асуулгын дүнг үндэслэн үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулах	дүнг үндэслэн	-Ажлын алба -ажлын хэсэг	Ажлын алба
30	Аудитын тайлан, санал зөвлөмж, санал асуулгын дүнгийн дагуу 2010 онд ажиллах төлөвлөгөө боловсруулах	-Санал зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах -Төлөвлөгөөний төслийг ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталж хэрэгжүүлэх	2009 оны 12 дугаар сард	-Үндэсний зөвлөл -Ажлын хэсэг -Ажлын алба	-
31	ОУИТБС хэрэгжүүлэгч улсуудтай мэдээлэл солилцох	Мэдээлэл солилцох Шуудан холбоо, e-mail	тогтмол	Ажлын хэсэг	Ажлын алба
Б. ОУИТБС-ыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, тогтворжуулах нөхцлийг бүрдүүлэх					
32	2009 оны Улсын төсөвт ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, олон улсын баталгаажуулалтын зардлыг тусгах	-Улсын төсөвт тусгах зардлын тооцоо, үндэслэлийг боловсруулах -Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулах -Үндэсний зөвлөлөөс Сангийн яаманд санал болгох	2008 оны 4-6 дугаар сард	-Ажлын алба -Ажлын хэсэг -Үндэсний зөвлөл	-Улсын төсөв
33	ОУИТБС-ыг цаашид	-Ажлын төлөвлөгөө төсөл, хандив авах төсөл боловсруулах	2010 онд	-Ажлын алба	-

	үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хандивын санал бэлтгэх	-Төслүүдээ ажлын хэсэг, Үндэсний зөвлөлд танилцуулж хандивлагч нарт санал тавих			
34	ОУИТБС-ыг хэрэгжүүлэхэд хандивлагч компанитай болох санал боловсруулах	-Төсөл бичиж хүсэлт тавих -Зохих журмын дагуу тусламж авч, үр дүнг мэдээлэх	2010 онд	-Ажлын алба -УУА	-
35	ОУИТБС-ын төслийн зарцуулалтыг аудитын шалгалтад оруулах	-аудитаар шалгуулах -дүгнэлтийг холбогдох байгууллагуудад явуулах	2009, 2010 онд	-Ажлын алба	ХИС 4000\$
В. Баталгаажуулах чиглэлээр					
38	Олон улсын баталгаажуулалтад бэлтгэх	-Баталгаажуулалтын аргачлалын дагуу бэлтгэл хангах	2009 онд	-ҮЗ, Ажлын хэсэг -ТББ эвсэл, компаниуд	Ажлын алба
		-Зохих журмын дагуу дотоод баталгаажуулалт хийх	2010 онд	- “ -	- “ -
39	Олон улсын баталгаажуулалтад хамрагдахыг хүсэх	-Баталгаажуулалтын талаар олон улсын байгууллагаас лавлагаа авах -Баталгаажуулалтад хамрагдах хүсэлт олон улсын байгууллагад тавих, сонгох	2009 онд	-Үндэсний зөвлөл -Ажлын хэсэг -Ажлын алба	Ажлын алба
		Баталгаажуулахад дэмжлэг үзүүлэх	2009-2010 онд	- “ -	Зардал /60000000Г/-ыг улсын төсөвт

III. Хүлээгдэж байгаа үр дүн: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг хэрэгжүүлж, олборлох үйлдвэрлэл эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигч компани улсын болон орон нутагт төлсөн албан татвар, төлбөрөө, Засгийн газар компаниас хүлээн авсан албан татвар, төлбөрийг ил тод тайлагнан нийтэд мэдээлэхийг хэвшүүлэх, зөрөөтэй байдлыг аудитаар тодорхойлж, авилгалаас урьдчилан сэргийлэх орчинг бүрдүүлж, уул уурхайн салбарын орлогын менежментийг сайжруулна.

Засгийн газрын 80 дугаар тогтоол

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

ЧИГ ҮҮРЭГ БАТЛАХ ТУХАЙ

2007 оны 3 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар 80

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхэд Засгийн газрын талаас оролцох төрийн захиргааны байгууллагуудын гүйцэтгэх чиг үүргийг хавсралт ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

М.ЭНХБОЛД

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг

эрхлэх газрын дарга

С.БАТБОЛД

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРОЛЦОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
БАЙГУУЛЛАГУУДЫН ЧИГ ҮҮРЭГ**

1. Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (цаашид “санаачилга” гэх)-ын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1.1. санаачилгын тайлангийн маягт, түүнийг гаргах болон нийтэд мэдээлэх зааврыг батлах, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн талаар татварын болон орон нутгийн байгууллагад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

1.2. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч (гадаадын хөрөнгө оруулалттай, хувийн хөрөнгө оруулалттай, төрийн өмчийн оролцоотой, хамтарсан үйлдвэр зэрэг бүх хэлбэрийн аж ахуйн нэгж)-ээс улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан албан татвар, төлбөр зэргийг тайлангийн маягт, зааврын дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр болон нэгтгэн гаргасан мэдээг Үндэсний татварын ерөнхий газраас гаргуулан авч хянах;

1.3. мэдээ буруу гаргасан бол холбогдох байгууллага, албан тушаалтнаар дахин гаргуулах;

1.4. Үндэсний татварын ерөнхий газраас ирүүлсэн мэдээг үндэслэн санаачилгын Засгийн газрын тайланг маягтын дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр болон улсын хэмжээгээр эцэслэн хянан албажуулж, санаачилгын бие даасан ажлын албанд хүргүүлэх;

1.5. улсын болон орон нутгийн төсөвт олборлох үйлдвэрлэл эрхлэгчдээс хүлээн авсан албан татвар, төлбөрийн улсын хэмжээгээр гаргасан Засгийн газрын тайланг нийтэд мэдээлэх;

1.6. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж ажиллах.

2. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэдгээрийг санаачилгад хамруулах;

2.2. санаачилгыг хэрэгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хуулийн төсөл боловсруулах;

2.3. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт бодлого, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлж ажиллах.

3. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс Ашигт малтмалын тухай хуулийн 38.1.8, 39.1.9-д заасан байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн эсэх, аж ахуйн нэгжээс байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаа, байгаль орчинд учруулсан хохирол зэргийг ил тод нийтэд мэдээлэх.

4. Үндэсний татварын төв байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1. бүх шатны татварын байгууллага, татварын байцаагч, холбогдох төрийн захиргааны байгууллагын удирдлага, ажилтан нарыг санаачилгын тайлан гаргах талаар мэргэжил арга зүйгээр хангах, зохион байгуулах;

4.2. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс улсын болон орон нутгийн төсөвт хүлээн авсан албан татвар, төлбөрийн талаархи мэдээг санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аймаг, нийслэл, холбогдох төрийн захиргааны байгууллагаас орон нутгийн татварын байгууллага, байцаагчаар дамжуулан аж ахуйн нэгж бүрийн нэрээр хүлээн авч хянан нэгтгэх;

4.3. мэдээ буруу гаргасан тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтнаар дахин гаргуулах;

4.4. аж ахуйн нэгж бүрийн нэрээр болон улсын хэмжээний мэдээг санаачилгын холбогдох маягтын дагуу гаргаж Сангийн яаманд мэдээлэх;

4.5. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэгт үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх.

5. Гаалийн төв байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

5.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс хүлээн авсан гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар болон үйлчилгээний хөлсний хэмжээг санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх.

6. Ашигт малтмал, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

6.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэднийг санаачилгад хамруулах;

6.2. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн удирдлага болон бүртгэл, санхүүгийн ажилтанг санаачилгын тайлан гаргах арга зүй, заавраар хангах;

6.3. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс хүлээн авсан тусгай зөвшөөрлийн болон бусад төлбөр, үйлчилгээний хөлсний талаархи мэдээг санаачилгын маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гарган Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх;

6.4. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайн жилд үйлдвэрлэсэн, борлуулсан бүтээгдэхүүний мэдээг улсын хэмжээгээр нэгтгэн холбогдох маягтын дагуу тайлан гаргаж, нийтэд мэдээлэх;

6.5. Ашигт малтмалын тухай хуулийн 48.10-ын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн тайлан, түүнийг нийтэд мэдээлсэн товч тайлангийн хамт аж ахуйн нэгж бүрээс гаргуулан авч санаачилгын бие даасан ажлын албанд хүргүүлэх;

6.6. санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Үндэсний зөвлөл, ажлын хэсэг, ажлын албанд үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх.

7. Төрийн өмчийн хороо олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийн удирдлагад санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэднийг санаачилгад хамруулах;

7.2. санаачилгын тайлан гаргах арга зүй, заавраар аж ахуйн нэгжийн удирдлага болон бүртгэл, санхүүгийн ажилтныг хангах;

7.3. төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийн газраас хүлээн авсан төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийн тайланг аж ахуйн нэгж бүрийн нэрээр санаачилгын маягтад заасан үзүүлэлтийн дагуу гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх.

8. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулсны ажлын байрны тухайн жилийн хүлээн авсан

төлбөрийг аж ахуйн нэгж бүрийн нэрээр санаачилгын маягтад заасан үзүүлэлтийн дагуу гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх.

9. Улсын мэргэжлийн хяналтын төв байгууллага санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг шалгахдаа санаачилгыг хэрхэн хэрэгжүүлж байгааг холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн хүрээнд шалгаж, нийтэд мэдээлэх.

10. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар санаачилгын талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1. олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх салбар зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулан оролцогч 3 талын ижил тэгш бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулах;

10.2. нутаг дэвсгэртээ орших олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд санаачилгын зарчим, шалгуур, ач холбогдлыг сурталчлах, тайлбарлан таниулах, тэднийг санаачилгад хамруулан тайлан гаргуулах, нийтэд мэдээлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

10.3. нутаг дэвсгэрт нь орших олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж санаачилгын тайлангаа гаргаж нийтэд мэдээлж байгаа байдалд хяналт тавих, энэ чиглэлээр аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

10.4. сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тухайн сум, дүүрэгт хүлээн авсан албан татвар, төлбөр, үйлчилгээний төрөл бүрийн хөлс, үзүүлсэн аливаа мөнгөн болон биет (машин, өвс тэжээл зэрэг) дэмжлэгийн талаархи мэдээг санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдээлэх;

10.5. олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс тухайн аймаг, нийслэлд хүлээн авсан албан татвар, төлбөр, үйлчилгээний төрөл бүрийн хөлс, үзүүлсэн мөнгөн болон биет (машин, өвс тэжээл зэрэг) дэмжлэгийн талаархи мэдээг сум, дүүргээс ирүүлсэн энэхүү чиг үүргийн 10.4-т заасан мэдээтэй нэгтгэн санаачилгын тайлангийн маягтад заасан үзүүлэлтийн дагуу аж ахуйн нэгж бүрийн нэрээр гаргаж Үндэсний татварын ерөнхий газарт мэдээлэх;

10.6. санаачилгыг хэрэгжүүлэх, цаашид тогтворжуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах.

Ашигт малтмалын хуулийн 48.9 болон 48.10 дугаар заалтууд

48.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 48.7.3-т заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын албанаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж дараагын улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор татварын албант тус тус тушаана.

48.10 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг дараа оны 1 дүгээр улиралд багтаан нийтэд мэдээлнэ.